

Үүсгэн байгуулагч:



Үнэт цаас гаргагч:




ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААС

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

Андеррайтер:
“Апекс Капитал ҮЦК” ХХК

Хуулийн компани:
“Өмгөөллийн Ханлекс Партерс” ХХН

Зээлийн шинжилгээ гаргагч:
“Грант Торnton Аудит” ХХК



МОНГОЛ УИХЫН НАМ
МОНГОЛ УИХЫН НАМ
АГУУЛГА

Хөрөнгө оруулагчдын анхааралд.....



ҮНЭТ ЦААСНЫ ХУРААНГУЙ МЭДЭЭЛЭЛ..... 6

ҮНЭТ ЦААС ГАРГАХ ПРОЦЕССД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД..... 7

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР..... 8

ХБҮЦ-НЫ ТУХАЙ ҮНДСЭН ОЙЛГОЛТ..... 9

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны онцлог 10

Үүсэл хөгжил 11

Олон улсын чиг хандлага, жишээ 12

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны зах зээл (Монгол улс) 14

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧИН..... 15

Гадаад зах зээл 15

Дотоодын макро орчин 19

Хөрөнгийн зах зээлийн нөхцөл байдал 22

Банк бус санхүүгийн байгууллага 24

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ..... 28

Үүсгэн байгуулагч/Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн тухай 29

Үнэт цаас гаргагчийн удирдлага зохион байгуулалт 33

Үнэт цаас гаргагчийн санхүүгийн байдал, төсөөлөл 37

ТЗК байгуулах данс- орлого зарлагын урсгалын тодорхойлолт 40

Хөндлөнгийн аудитын тухай 41

ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ..... 43

Үнэт цаасны нөхцөл 43

Хүүг тогтоосон үндэслэл 44

Үнэт цаасны төлбөрийн бодолт 45

Төлбөр төлөх дараалал 46

Үнэт цаасны төлбөрийн график 46

Үнэт цаасны төлбөрийн эх үүсвэр 47

Үнэт цаасжуулах хэлцлийн зураглал 47

Багцын тойм 49

Багцад багтсан зээлийн төрөл, онцлог 53

Багцын зээлийн санхүүгийн болон хуулийн шалгуур 56

Хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах тухай 58

Эрсдэл, эрсдэлийн удирдлага 60

Хууль эрх зүйн орчин 65

Омни актив ТЗК-тай холбоотой гэрээнүүд 67

Омни актив ТЗК-ийн гаргаж буй ХБҮЦ-тай холбоотой дүрэм, журмууд 67

ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭГЧИЙН ТУХАЙ 68





ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА.....	70
БҮРТГЭВ-03	
Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах процессын зураглал	70
Үнэт цаасны арилжаанд оролцох, захиалга авах заавар.....	70
Үнэт цаас эзэмшигчийн эрх	71
ҮНЭТ ЦААС ГАРГАХАД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУДЫН ТУХАЙ.....	74
"ХаанЛекс Партнерс" ХХН	74
"Апекс капитал" УЦК.....	75
"Грант Торnton аудит" ХХК.....	76

F. B. G.



2022 -01- 28

БҮРТГЭВ-03

Хөрөнгө оруулагчдын анхааралд

СЗХ
оң 2022. 01. 12 дээр
БҮРТГЭВ
№ 1

Үнэт цаас гаргагч нь Монгол улсын компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон Монгол улсын Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монголын Хөрөнгийн Биржийн холбогдох журмуудын дагуу хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргаж байгаа болно.

Уг танилцуулгыг Үнэт цаас гаргагчаас нэг бүр нь 100,000 /Нэг зуун мянган/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 50,000 /Тавин мянган/ ширхэг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй гаргахтай холбоотойгоор хөрөнгө оруулагчдад зориулан бэлтгэсэн болно. Үнэт цаас гаргагч "Омни Актив ТЗК" ХХК нь тус 5,000,000,000 /таван тэрбум/ төгрөгийн үнэт цаасыг анхны үүрэг гүйцэтгүүлэгч болох "Омни Капитал ББСБ" ХХК-с зээлийн багцыг шилжүүлэн авах буюу анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь өөрийн үйл ажиллагааны хүрээг тэлэхэд ашиглана.

Санхүүгийн зохицуулах хорооноос үнэт цаасыг бүртгэсэн нь уг үнэт цаас болон түүнийг баталгаажуулж буй зээлийн багц дахь мэдээлэл, холбогдох үнэлгээ болон бусад мэдээллүүдийн үнэн зөв, эрсдэлгүй эсэхийн баталгаа биш бөгөөд үүнтэй холбоотойгоор үүссэн хариуцлагыг Санхүүгийн зохицуулах хороо хариуцахгүй болно. Тиймээс хөрөнгө оруулагч та гаргаж буй үнэт цаас болон үнэт цаас гаргагчийн талаар бие даасан дэлгэрэнгүй судалгаа шинжилгээг хийх, мэргэжлийн санхүүгийн, хуулийн болон бусад зохих мэргэжилтнүүдтэй зөвлөлдөхийг зөвлөж байна.

Энэхүү үнэт цаасны танилцуулгад тусгагдсан зарим мэдээлэл нь зөвхөн одоогоор цаг хугацааны шинж чанартай гаргасан мэдээлэл, мэдэгдэл, тооцоолол болно. Андеррайтер нь холбогдох баталгаат гэж үзсэн эх сурвалжаас цуглувансан мэдээлэл, итгэл үнэмшил дээр тулгуурлан тооцоолол төсөөллийг оруулсан, санаатайгаар ямар нэг мэдээллийг орхигдуулаагүй бөгөөд үүний биелэлтэд ямар нэг баталгаа өгөөгүй болно.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО, МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИД ҮНЭТ ЦААСЫГ БҮРТГЭСЭН НЬ АЛИВАА ЭРСДЭЛЭЭС ХАМГААЛАХ БАТАЛГАА БИШ БОЛОХЫГ АНХААРНА УУ. ҮНЭТ ЦААС ХУДАЛДАН АВАХ ЗАМААР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ НЬ ЭРСДЭЛТЭЙ ҮЙЛДЭЛ ГЭДГИЙГ ОНЦГОЙЛОН АНХААРЧ, ТУХАЙН ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА, ЗАХ ЗЭЭЛД ҮНЭТ ЦААС ГАРГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ САЙТАР АНХААРАН СУДАЛЖ ШИЙДВЭРЭЭ ГАРГАХЫГ ЗӨВЛӨЖ БАЙНА.

Үнэт цаасны танилцуулгад хөрөнгө оруулагч танд тус үнэт цаасыг худалдан авах шийдвэр гаргахад туслах шаардлагатай бүхий л мэдээллийг агуулахыг зорьсон болно. Хөрөнгө оруулагч таныг шийдвэрээ гаргахад шаардлагатай буюу нэмэлтээр асууж, лавлан тодруулах зүйл байвал Андеррайтер болох Алекс капитал ҮЦК-д хандана уу.

ОМНИ АКТИВ
ХХК



ХАВСРАЛТ, ЗУРГИЙН ТОВЬЁОГ

Зураг 1 ХБҮЦ зураглал.....	9
Зураг 2 Эрсдэлийн хувь	13
Зураг 3 ХБҮЦ хөгжил.....	14



ХАВСРАЛТ, ХҮСНЭГТИЙН ТОВЬЁОГ

Хүснэгт 1 Эрсдэл ба өгөөжийн тэнцэл	12
Хүснэгт 2 Эдийн засгийн өсөлт салбараар.....	20
Хүснэгт 3 Экспортын голлох бүтээгдэхүүн	20
Хүснэгт 4 ЭЗ-ийн голлох үзүүлэлт төсөөллүүд.....	21
Хүснэгт 5 Банкнуудын хөрөнгө босголт-төсөөлөл.....	23
Хүснэгт 6 ББСБ салбарын тоон үзүүлэлт	24
Хүснэгт 7 "Омни актив ТЗК" ХХК Эхлэлтийн баланс.....	37
Хүснэгт 8 "Омни актив ТЗК" ХХК Санхүүгийн байдлын тайлан (төсөөлөл).....	37
Хүснэгт 9 "Омни актив ТЗК" ХХК Орлогын тайлан (төсөөлөл).....	38
Хүснэгт 10 "Омни актив ТЗК" ХХК үйл ажиллагааны зардал (төсөөлөл)	38
Хүснэгт 11 "Омни актив ТЗК" ХХК Мөнгөн урсгал(төсөөлөл)	39
Хүснэгт 12 Үнэт цаасны нөхцөл	43

ХАВСРАЛТ, ГРАФИКИЙН ТОВЬЁОГ

График 1 1985 оноос хойш ХБҮЦ-ны зах зээлийн хэмжээ (Тэрбум \$)	11
График 2 Дэлхийн тогтмол өгөөжтэй үнэт цаасны зах зээлд эзлэх байр суурь	12
График 3 Бодлогын хүүний динамик.....	16
График 4 Инфляцийн өсөлт болон хүлээлт.....	16
График 5 Инфляцид нөлөөлж буй хүчин зүйлс.....	16
График 6 Вакцинжсан хүн амын тоо	18
График 7 Өдөрт бүртгэгдэж буй өвчлөлийн тоо.....	18
График 8 ДНБ-ийн төсөөлөл	18
График 9 Импортын голлох бүтээгдэхүүн	20
График 10 Экспортын голлох бүтээгдэхүүн	20
График 11 Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ.....	22
График 12 Топ 20 индекс	22
График 13 Арилжааны идэвхи	22
График 14 Санхүүгийн зах зээлийн хэмжээ.....	23
График 15 ББСБ-ийн эх үүсвэрийн бүтэц.....	25
График 16 ББСБ-ийн хөрөнгийн өсөлт.....	25
График 17 Зээлийн үлдэгдэл (хугацаагаар).....	25
График 18 Зээлийн чанарын үзүүлэлт.....	26
График 19 Ашиг ажиллагааны үзүүлэлт.....	26
График 20 Төстэй бүтээгдэхүүний хүүгийн харьцуулалт.....	43

D.Schulz



2022 -01- 28

БҮРТГЭВ-03

Хөрөнгө оруулагчдын анхааралд

СЗХ
оң 2022. 01. 12 дээр
БҮРТГЭВ
№ 1

Үнэт цаас гаргагч нь Монгол улсын компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон Монгол улсын Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монголын Хөрөнгийн Биржийн холбогдох журмуудын дагуу хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргаж байгаа болно.

Уг танилцуулгыг Үнэт цаас гаргагчаас нэг бүр нь 100,000 /Нэг зуун мянган/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 50,000 /Тавин мянган/ ширхэг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй гаргахтай холбоотойгоор хөрөнгө оруулагчдад зориулан бэлтгэсэн болно. Үнэт цаас гаргагч "Омни Актив ТЗК" ХХК нь тус 5,000,000,000 /таван тэрбум/ төгрөгийн үнэт цаасыг анхны үүрэг гүйцэтгүүлэгч болох "Омни Капитал ББСБ" ХХК-с зээлийн багцыг шилжүүлэн авах буюу анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь өөрийн үйл ажиллагааны хүрээг тэлэхэд ашиглана.

Санхүүгийн зохицуулах хорооноос үнэт цаасыг бүртгэсэн нь уг үнэт цаас болон түүнийг баталгаажуулж буй зээлийн багц дахь мэдээлэл, холбогдох үнэлгээ болон бусад мэдээллүүдийн үнэн зөв, эрсдэлгүй эсэхийн баталгаа биш бөгөөд үүнтэй холбоотойгоор үүссэн хариуцлагыг Санхүүгийн зохицуулах хороо хариуцахгүй болно. Тиймээс хөрөнгө оруулагч та гаргаж буй үнэт цаас болон үнэт цаас гаргагчийн талаар бие даасан дэлгэрэнгүй судалгаа шинжилгээг хийх, мэргэжлийн санхүүгийн, хуулийн болон бусад зохих мэргэжилтнүүдтэй зөвлөлдөхийг зөвлөж байна.

Энэхүү үнэт цаасны танилцуулгад тусгагдсан зарим мэдээлэл нь зөвхөн одоогоор цаг хугацааны шинж чанартай гаргасан мэдээлэл, мэдэгдэл, тооцоолол болно. Андеррайтер нь холбогдох баталгаат гэж үзсэн эх сурвалжаас цуглувансан мэдээлэл, итгэл үнэмшил дээр тулгуурлан тооцоолол төсөөллийг оруулсан, санаатайгаар ямар нэг мэдээллийг орхигдуулаагүй бөгөөд үүний биелэлтэд ямар нэг баталгаа өгөөгүй болно.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО, МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИД ҮНЭТ ЦААСЫГ БҮРТГЭСЭН НЬ АЛИВАА ЭРСДЭЛЭЭС ХАМГААЛАХ БАТАЛГАА БИШ БОЛОХЫГ АНХААРНА УУ. ҮНЭТ ЦААС ХУДАЛДАН АВАХ ЗАМААР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ НЬ ЭРСДЭЛТЭЙ ҮЙЛДЭЛ ГЭДГИЙГ ОНЦГОЙЛОН АНХААРЧ, ТУХАЙН ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА, ЗАХ ЗЭЭЛД ҮНЭТ ЦААС ГАРГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ САЙТАР АНХААРАН СУДАЛЖ ШИЙДВЭРЭЭ ГАРГАХЫГ ЗӨВЛӨЖ БАЙНА.


Үнэт цаасны танилцуулгад хөрөнгө оруулагч танд тус үнэт цаасыг худалдан авах шийдвэр гаргахад туслах шаардлагатай бүхий л мэдээллийг агуулахыг зорьсон болно. Хөрөнгө оруулагч таныг шийдвэрээ гаргахад шаардлагатай буюу нэмэлтээр асууж, лавлан тодруулах зүйл байвал Андеррайтер болох Алекс капитал ҮЦК-д хандана уу.

ОМНИ АКТИВ
ХХК



2022 -01- 28

БҮРТГЭВ-03



ҮНЭТ ЦААСНЫ ХУРААНГУЙ МЭДЭЭЛЭЛ

Үнэт цаас гаргагч	"Омни Актив ТЗК" ХХК
Анхны үүрэг гүйцэтгүүлэгч	"Омни Капитал ББСБ" ХХК
Үнэт цаасны төрөл	Зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас
Үнэт цаасны тоо ширхэг	50,000 ширхэг
Үнэт цаасны нэгжийн нээрлэсэн үнэ	100,000 төгрөг
Үнэт цаасны нийт дүн	5,000,000,000 төгрөг
Үнэт цаасны хугацаа	24 сар
Үнэт цаасны хүү	14.5 хувь (жилийн)
Хүү төлөгдөх хугацаа	Улирал тутам
Үндсэн төлбөр төлөгдөх хугацаа	12 сард 1 удаа
Үнэт цаасны төлбөр төлөгдөх эх үүсвэр	Хөрөнгийн багцын зээлийн үндсэн болон хүүгийн орлого
Үнэт цаасны хүүд ногдох татвар	Хувь хүн болон ААН-д хүүгийн орлогод ногдох дүнгээс 5 хувь
Үнэт цаасны хадгалалт	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн данс
Арилжаалах зах зээл	Монголын хөрөнгийн бирж ТӨХК
Багцын зээлийн нийт дүн	5,010,629 төгрөг
Хэрэглээний зээл	1,328,078 төгрөг
Автомашиний зээл	1,621,131 төгрөг
Бизнесийн зээл	2,061,420 төгрөг
Зээлдэгчдийн тоо	808
Зээлийн чанар	100 хувь хэвийн
Андеррайтер	"Апекс капитал УЦК" ХХК



2022 -01- 28

БҮРТГЭВ-03



ҮНЭТ ЦААС ГАРГАХ ПРОЦЕССД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД

АПЕКС КАПИТАЛ ҮЦК ХХК



Андеррайтерийн компани

📞 +976 75107500

📍 Монгол улс, Улаанбаатар, Сүхбаатар
дүүрэг, 1-р хороо, Олимпийн 4-р гудамж,
Нью Хоризонс оффис 902 тоот

✉️ Investment@apex.mn

ӨМГӨӨЛЛИЙН ХААНЛЕКС ПАРТНЕРС ХХН

Хуулийн фирм



📞 +976 77471112

📍 Монгол улс, Улаанбаатар, Сүхбаатар
дүүрэг, 1-р хороо, Олимпийн 5-р гудамж,
Аюуд тауэр 14 давхар 1404 тоот

✉️ Info@khanlex.mn

ГРАНТ ТОРНТОН АУДИТ ХХК

Зээлийн шинжилгээ гаргагч



📞 70110744

📍 Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, юнеско,
Далай тауэр, 9 давхар

✉️ info@mn.gt.mn



2022 -01- 28

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

БҮРТГӨВ-03



Анхны үүрэг гүйцэтгүүлэгч

Зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий, тухайн багцалсан зээлийн анхны эзэн буюу "Омни капитал ББСБ" ХХК

Анхдагч зах зээлийн арилжаа

Үнэт цаас гаргагч анх удаагаа олон нийтэд санал болгох замаар арилжих арилжааг

Багцын шаардлага

"Омни Актив ТЗК" ХХК-ийн ТУЗ-21/06 тоот тогтоолоор баталсан зээлийн багцад тавигдах хуулийн болон санхүүгийн шалгуур

Зээлдэгч

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй Зээлийн гэрээ байгуулж, зээл авсан бөгөөд зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг уг зээлийн гэрээний дагуу төлөх үүргийг хүлээсэн иргэн, хуулийн этгээдийг

Зээлийн эргэн төлөлт

Баталгаат үнэт цаасны хөрөнгийн багцад багтсан Зээлийн төлөлт буюу Зээлдэгчээс зээлийн гэрээний дагуу Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид төлөх мөнгөн төлбөрийг

Зээлийн багц эсхүл багц

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс Үнэт цаас гаргагчид худалдсан хөрөнгүүдийн багц

Үнэт цаас гаргагч

"Омни актив ТЗК" ХХК

Үйлчилгээ үзүүлэгч

Үүрэг гүйцэтгүүлэгчтэй харилцаж, хөрөнгөтэй холбоотой төлбөрийг цуглуулан тусгай зориулалтын компанийд шилжүүлэх, бүртгэх, тайлагнах болон үйлчилгээ үзүүлэхээр тусгай зориулалтын компанийтай гэрээ байгуулсан хуулийн этгээд буюу "Омни капитал ББСБ" ХХК

Хөрөнгө итгэмжлэн удирдагч

Тусгай зориулалтын компанийтай гэрээ байгуулсан, хөрөнгө оруулагчид барьцаалуулсан хөрөнгийг түүний эрх ашигт нийцүүлэн эзэмшиж, удирдах үүрэг бүхий этгээд

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ХБҮЦ

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас

МХБ эсхүл бирж

"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК

СЗХ

Санхүүгийн Зохицуулах Хороо

ТУЗ

Төлөөлөн удирдах зөвлөл

ТЗК

Тусгай зориулалтын компани

ҮЦТХТ

Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв

ТУЗ

Төлөөлөн удирдах зөвлөл

D. Chyld




2022 -01- 28

ХБҮЦ-НЫ ТУХАЙ ҮНДСЭН ОЙЛГОЛТ

БҮРТГЭВ-03

Монгол улсын холбогдох хуульд заасны дагуу "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас" нь зээл, түрээс болон санхүүгийн түрээсийн гэрээ, өрийн бичгээс үүсэх шаардах эрх, зээлийн карт олгогчийн авлага зэрэг мөнгөн урсгал бий болгох боломжтой хөрөнгөөр баталгааждаг, хөрөнгө оруулагч нь уг хөрөнгийн орлогоос тэргүүн ээлжид телбөрөө гаргуулах эрхийг баталгаажуулсан үнэт цаас гэж заажээ. Өөрөөр хэлбэл ирээдүйд төлөгдөх мөнгөн урсгал бүхий зээлийн багцуудыг багцлан борлогдох боломжтой үнэт цаас болгон эцсийн өмчлөгчийг өөрчилсөөр хөрөнгө оруулагчид тухайн багцаас орж ирэх ирээдүйн орлогыг эзэмших замаар мөнгөө өсгөх боломжтой болох юм. Энэ нь үнэт цаас гаргагчдад ирээдүйн орлогоо барьцаалан шинэ санхүүжилт татах боломжийг олгодог бол хөрөнгө оруулагчдад эрсдэлийн түвшин бага, тогтмол өгөөж бүхий бүтээгдэхүүнийг эзэмших боломж бий болгодог. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хэлцлийн бүтцийн зураглалыг жишээ болгон дор оруулав.

Зураг 1 ХБҮЦ зураглал



"Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль"-д заасны дагуу хэлцлийн бүтцэд оролцох шаардлага бүхий этгээдүүд болон тэдний үүрэг оролцоог товч дурдвал:

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч- Зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий тухайн багцалсан зээлийн анхны эзэн (Банк, банк бус санхүүгийн байгууллага эсвэл OSCSK)

Үйлчилгээ үзүүлэгч- Үүрэг гүйцэтгэгчтэй харилцаж, хөрөнгөтэй холбоотой төлбөрийг цуглуулан тусгай зориулалтын компанийд шилжүүлэх, бүртгэх, тайлاغнах болон үйлчилгээ үзүүлэх гэрээнд заасан хөрөнгөтэй холбоотой бусад үйлчилгээ, үйл ажиллагаа эрхлэхээр тусгай зориулалтын компанийтай гэрээ байгуулсан хуулийн этгээд

Тусгай зориулалтын компани- Багцалсан хөрөнгийг (зээл) хүлээж аван, ХБҮЦ нь идэвхтэй байх хугацаанд эзэмших, бүртгэх үүрэгтэйгээр түр байгуулагдах бөгөөд албан ёсоор үнэт цаас гаргана.

Хөрөнгө Итгэмжлэн удирдагч- Тусгай зориулалтын компанийтай гэрээ хийн хөрөнгө оруулагчдын барьцаалуулсан хөрөнгийг түүний эрх ашигт нийцүүлэн эзэмшиж, удирдах үүрэгтэй нэгж.

Хуулийн фирм, зээлийн шинжилгээ гаргагч- Тусгаарлаж буй зээлүүд нь хууль, санхүүгийн хувьд зохимжит эсэх талаар болон хэлцлийн зураглал, оролцогч талууд нь зохимжтой, хууль ёсны дагуу эсэх талаар дүгнэлт гаргана.



2022 -01- 28

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны онцлог



Тодорхой байдал

ЕРӨНХИЙ ОНЦЛОГ

Тогтвортой, тодорхой активын ирээдүйн мөнгөн урсгалаар баталгаажсан байдаг. Багцалсан зээлүүд нь тодорхой хугацаанд, тодорхой хүүтэйгээр эргэн төлөгдөх нөхцөлтэй, зохих хууль журмын дагуу бүртгэгдсэн барьцаагаар хангагдсан байна. Зээлийн нөхцөлүүд нь гэрээгээр баталгаажсан тул тодорхой төсөөлөл гаргах боломжтой.

Хяналтын тогтолцоо

Үүсгэн байгуулахаас өмнө болон үүсгэн байгуулсны дараах хяналтын тогтолцоо, оролцогч талууд хууль болон журмын дагуу тодорхой тогтсон байдаг. Ингэснээр хөрөнгө, мөнгөн урсгалыг хянах бололцоотой байдаг.

Эрсдэлийн хязгаарлалт

Үнэт цаас гаргагчийн бусад үйл ажиллагаатай холбоотой эрсдэлүүд хамаарахгүй. Зөвхөн багцалсан хамгийн эрсдэл багатай, хэвийн зээлийн төлөлт хамаарна.

Удирдлага

Багцын зээлийн чанарын үзүүлэлт, бэлэн мөнгөний хүрэлцээ зэргийг хөрөнгө оруулагчдын өмнөөс хөрөнгө итгэмжлэн удирдагч тогтмол хяналт тавин ажиллана. Ингэснээр үнэт цаасны эргэн төлөлтийн эх үүсвэрт тасалдал, хоцрогдол үүсэх гэх мэт эрсдэлийг бууруулдаг.

Өгөөжийн түвшин

Бусад өрийн хэрэгсэлтэй харьцуулахад эрсдэл бага/өгөөж харьцангуй өндөр байдаг

ҮНЭТ ЦААС ГАРГАЧИД БИЙ БОЛОХ ДАВУУ ТАЛ

Дахин санхүүжилт

Ирээдүйн орлогыг барьцаалж дахин санхүүжилт татах боломж бий болдог.

Бүтцийн шинэчлэлт

Багцын эрсдэлийг тархаах, дахин санхүүжилтийг ашиглан хөрөнгийн бүтцийг шинэчлэн бусад төрлийн шинэ зээл гаргах, хөрөнгө оруулалт хийх зэрэг боломж үүснэ.

Тогтвортой эх үүсвэр

Харьцангуй хямд санхүүжилтийн эх үүсвэр болно.

БОЛОМЖИТ ЭРСДЭЛ

Хөрөнгийн эрсдэлүүд

Багцалсан зээлүүдтэй холбоотой эрсдэл үүсэх

Бүтцийн эрсдэлүүд

Хэлцлийн зураглалын анхны хэлбэр, журам зохицуулалтууд бодит үйл ажиллагаанд нийцэл бага байх, эрсдэлийн эсрэг авах арга хэмжээ тодорхой бус байх, түүнээс үүдэн мөнгөн урсгалд эрсдэл үүсэх

Оролцогч талуудын эрсдэлүүд

Хэлцэлд оролцож буй оролцогч талуудтай холбоотой гүйцэтгэсэн ажлын хариуцлага, төлбөрийн чадвар зэрэг эрсдэлүүд үүсэх

Т. Сүрье



2022 -01- 28

Үүсэл хөгжил


БҮРТГЭВ-03



Asset-backed securities буюу Монгол улсын хууль тогтоомжтой хамгийн ойролцоо нэршил нь баталгаат хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (ХБҮЦ) нь анх 1985 онд Сперри Лиз Санхүүгийн Корпораци (Sperry Lease Finance Corporation) компьютер тоног төхөөрөмжийн лизингийн эргэн төлөлтөөр баталгаажсан шинэ төрлийн үнэт цаасыг зах зээлд нэвтрүүлснээр бий болжээ¹. Анхны ХБҮЦ зах зээлд танилцуулагдснаас хойш уг зах зээлд автомашинийн зээлээр баталгаажсан, гар утасны лизингээр баталгаажсан, кредит картны зээлээр баталгаажсан үнэт цаас гэх мэт олон төрлийн ХБҮЦ-үүд бий болоод байгаа юм.

Ийнхүү анх бий болсон цагаасаа хойш тасралтгүй өссөөр 2008 оны дэлхийн санхүүгийн хямралын өмнөхөн бүх цаг үеийн дээд түвшиндээ хүрсэн ба тухайн уед MBS (Mortgafe backed securities) буюу ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаастай холбоотой ихээхэн хохирол бий болсноор нийт ХБҮЦ-ны зах зээлийн хэмжээ огцом буурсан. 2012 оноос тус зах зээл ахин сэргэлт үзүүлж эхэлснээр 2021 оны эхний улирлын байдлаар АНУ-ын ХБҮЦ-ний зах зээл 1.5 триллион ам.долларт хүрээд байна².

График 1 1985 оноос хойш ХБҮЦ-ны зах зээлийн хэмжээ (Тэрбум \$)



Эх сурвалж : Securities Industry and Financial Markets Association (SIFMA)

J. Shy



2022-01-28

СЗХ
од 2022 01. 12 дэр
БҮРТГЭВ
№ 01

Олон улсын чиг хандлага, жишээ

2021 оны 1-р улирлын байдлаар дэлхийн тогтмол өгөөжтэй бүтээгдэхүүний зах зээлийн хамгийн том хувь хэмжээг АНУ эзэлж байна. Энэ нь эргэлтэд буй нийт үнэт цаасны 38.9% буюу 48 триллион ам.доллартай тэнцэх дүн юм. Харин Европын бондын зах зээл нь хэмжээгээрээ АНУ-ын дараа ордог бөгөөд тус улстай харьцуулахад зах зээлийн хэмжээ нь 1.9 дахин бага дүнтэй байна. Удаах байранд БНХАУ, Япон, Англи, Канад, Австрали зэрэг орнууд багтаж байна.

График 2 Дэлхийн тогтмол өгөөжтэй унэт цаасны задх зээлд эзлэх байр суурь



Эх сурвалж: Bank for International Settlements (1Q21)

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас нь бусад ижил зэрэглэлтэй бондуудтай харьцуулахад харьцангуй өндөр өгөөжийг олгодог байна. Дараах графикаар өгөөж болон хугацаа хоорондын хамаарлыг ялгаатай төрлийн үнэт цаасны жишээн дэх харуулжээ.

Хүснэгт 1 Эрсдэл ба өгөөжийн тэнцэл

Үнэлгээ	Хэмжээ	Купон	Хугацаа
AAA	256	3 cap LIBOR+1.6%	5.6
AA	51	3 cap LIBOR+2.2%	7.3
A	18	3 cap LIBOR+3%	7.9
BBB	26	3 cap LIBOR+4.25%	8.3
BB	17	3 cap LIBOR+6.75%	8.6

Кейс жишээ: ХБҮЦ нь Домино компанийд хэрхэн санхүүжилтийн боломжийг бий болгосон бэ?

1960 онд үүсгэн байгуулагдсан Домино пиццаны компани нь одоогийн байдлаар дэлхийд 14,000 гаруй салбартай бөгөөд жилийн 11 тэрбум амдолларын орлоготой. 2010 оноос хойш компанийн борлуулалт дунджаар жилийн 7% өсч байгаа ба бизнесийн гол модель нь франчайз хэлбэрээр явагддаг.

Домино /франчайз олгогч/ нь дэлгүүрийг ажиллуулах эзэнд оюуны өмч, лицензийн зөвшөөрлийг өгснийхөө төлөө борлуулалтаас тасралтгүй шимтгэлийн орлого авах боломжтой болдог. Харин дэлгүүрийн эзэн шимтгэл төлснөөрөө брэндийн нэр хүнд, өнгө төрх, түүхий эд материалын эх сурвалж, мэдээлэл болон технологи, маркетингийн хувьд давуу талыг олж авдаг байна. Тус компани хөрөнгө оруулалтын ангиллын өрийн бичгийг гаргахдаа дараах алхмуудыг хийжээ.

- “Domino's Master Issuer” нэртэй тусгай зориулалтын компанийг байгуулж, орлогын эх үүсвэрийг бий болгодог хөрөнгүүдээ заржээ. Үүнд одоо болон ирээдүйд хийгдэх франчайз гэрээнүүд, оюуны өмч, франчайз газрууд, үл

D. Cyl



2022-01-28


хөдлөх х
байна.

СЭХ
0222 №1.12-
БҮРТГЭВ
багтсан

- Дээрх хөрөнгүүд нь эргэн төлөлтэд барьцаа болгон ашиглагдах ба ТЗК нь Домино-д хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бичгийг гарган өгсөн.
 - ТЗК нь ХБҮЦ эзэмшигчийн шаардлагатай төлөлтөөс илүү гарсан мөнгөн урсгалыг эзэмших эрхтэй.

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (Asset backed securities) нь олон улсад олон төрлөөр арилжаалагддаг хөрөнгийн зах зээлийн томоохон бүтээгдэхүүн юм. 1986-2018 оны мэдээллээс үзэхэд "AAA" үнэлгээтэй ХБҮЦ нэг ч удаа чанаргүйдээгүй байдаг. Харин "AA" үнэлгээтэй ХБҮЦ 1 удаа, "A" үнэлгээтэй ХБҮЦ 4 удаа л чанаргүйдсэн³ байгаа нь үнэлгээ тогтоогч байгууллагуудаас өндөр үнэлгээ авч чадсан ХБҮЦ найдвартай байдаг гэдгийг харуулж байна. (Тус дата нь MBS буюу Mortgage Backed securities-г багтаагаагүй болно.

Зураг 2 Эрсдэлийн хувь



Эх сурвалж: S&P Global Ratings



2022. -01- 28

СЭХ
2022. 01. 12
БҮРТГЭВ
№ 01

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны зах зээл (Монгол улс)

Зураг 3 ХБҮЦ хөгжил



Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны төрөл Монгол улсад

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас нь Монгол улсад Баталгаат болон Барьцаат гэсэн үндсэн 2 төрөлтэй байх ба нээлттэй болон хаалттай хэлбэрээр санал болгох боломжтой. Аль ч хэлбэрээр санал болгох тохиолдолд Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрөл авах шаардлагатай. ХБҮЦ-тай холбоотой холбогдох хууль, журмууд манай улсад 2011 оноос эхлэн баталгаажсанаар хаалттай хүрээнд ипотекийн зээлээр баталгаажсан барьцаат үнэт цааснуудыг "МИК ХК" нь өөрийн үүсгэн байгуулсан Тусгай зориулалтын компаниудаар дамжуулан санал болгон арилжаалсаар байна. Анхны нээлттэй, автомашины зээлээр баталгаажсан ХБҮЦ-ыг 2021 онд "Инвесткор актив ТЗК" ХХК олон нийтэд санал болгон санхүүжилтийг амжилттай татан төвлөрүүлсэн.

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд Барьцаат болон Баталгаат үнэт цаасыг дараах байдлаар тодорхойлжээ:

1. Баталгаат үнэт цаас

Баталгаат үнэт цаас нь хөрөнгийг анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үнэт цаас гаргагчийг үүсгэн байгуулагч, худалдагчийн санхүүгийн тайлан, тэнцлээс хасч, хөрөнгөтэй холбоотой шаардах эрх болон олох орлогыг тусгай зориулалтын компанийн санхүүгийн тайлан, тэнцэлд шилжүүлэн анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үүсгэн байгуулагч, худалдагчийг хөрөнгөтэй холбоотой үүргээс бүрэн чөлөөлснийг гэрчилсэн үнэт цаас байна.

2. Барьцаат үнэт цаас

Барьцаат үнэт цаас нь үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайлан, тэнцэлд тусгаарлан бүртгэгдсэн, орон сууцны зээлийн болон энэ хуулиар зөвшөөрсөн бусад үл хөдлөх эд хөрөнгийн барьцаатай холбоотой шаардах эрхээр баталгаажсан, үнэт цаасны танилцуулгад заасан хугацаанд үндсэн төлбөр, түүний хүүг хөрөнгө оруулагчид төлөх үүргийг гэрчилсэн үнэт цаас байна.



2022 -01- 28

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧИН

Гадаад зах зээл



ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЗҮҮЛЭЛТ

	2019	2020	2021*	2022*
Жилийн өөрчлөлт (хувиар)				
Дэлхийд (Олон улсад)	2.5	-3.6	5.4	4.1
Хөгжингүй эдийн засаг	1.7	-5.0	5.0	3.4
Америкийн нэгдсэн улс	2.2	-3.5	6.2	3.2
Япон	0.3	-4.8	3.3	2.2
Европын холбоо	1.5	-6.4	4.1	3.8
Европын холбоо-15	1.3	-7.3	4.3	4.2
Европын холбоо-13	3.7	-4.0	4.0	3.5
Евро бүс	1.3	-6.9	4.2	3.9
Их Британи Умард Ирландын нэгдсэн вант улс (ИБУИНВУ)	1.3	-9.9	5.1	5.5
Бусад хөгжингүй орнууд	1.7	-3.5	3.6	2.9
Шилжиж буй эдийн засаг	2.2	-2.7	3.3	3.3
Зүүн Өмнөд Европ	3.7	-3.5	4.2	3.5
Тусгаар улсуудын хамтын нөхөрлөл	2.2	-2.6	3.3	3.3
Оросын Холбооны Улс	1.3	-3.0	3.0	3.0
Хөгжиж буй эдийн засаг	3.6	-1.7	6.1	5.0
Африк	2.9	-3.5	3.6	3.7
Хойд Африк	3.2	-5.5	5.6	4.0
Зүүн Африк	6.5	0.1	3.3	4.5
Төв Африк	1.9	-1.8	3.0	3.2
Баруун Африк	3.3	-1.0	2.7	3.6
Өмнөд Африк	-0.2	-6.1	2.2	2.6
Зүүн ба өмнөд Ази	4.9	-0.1	7.1	5.7
Зүүн Ази	5.3	1.0	7.1	5.2
Хятад	6.1	2.3	8.2	5.8
Өмнөд Ази	3.1	-5.6	6.9	8.3
Энэтхэг	4.6	-6.8	7.5	10.1
Баруун Ази	1.2	-3.2	3.7	3.4
Латин Америк ба Карибын тэнгис	-0.3	-7.3	4.3	3.3
Өмнөд Америк	-0.7	-6.8	4.1	3.1
Бразил	1.4	-4.1	3.0	2.4
Мексик ба Төв Америк	0.6	-8.2	4.7	3.6
Карибын тэнгис	0.5	-8.1	4.3	6.8
Буурай хөгжилтэй орнууд	4.9	-0.3	4.0	5.0
Дэлхийн худалдаа	1.2	-8.1	9.4	5.7
Худалдан авах чадварын харьцаа	2.8	-3.5	5.5	4.4

Эх сурвалж- Дэлхийн банк

*Төсөөлөл

2020 оноос эхэлсэн цар тахлын нөлөөлөл дэлхий нийтийг бүрэн хамарч дэлхийн эдийн засаг 3.6 хувиар агшив. Цар тахлын нөлөөлөлд хамгийн хүчтэй өртсөн




2022 -01- 26



салбаруудад аялал жуулчлал, худалдаа, үйлчилгээ, тээвэр зэрэг салбарууд багтана. Улс орнуудын хувьд Европын холбоо болон зарим хөгжиж буй орнууд хамгийн хүндээр өртжээ. 2021 оныг вакцинжуулалт, эдийн засгийн өсөлт эргэлтийн жил болох талаар хүлээлт өндөр байсан хэдий ч Covid-19-ийн шинэчлэгдсэн хувилбарууд гарснаар цар тахлын дэгдэлтийн бууралт удаашралтай явагдаж байна.

График 3 Бодлогын хуундийн динамик



газрын өр, ДНБ-ний харьцаа 61 хувьд хүрч нэмэгдэж байна. (Монгол банк).

Засгийн газрын бодлогууд

Цар тахлыг хохирол багатай давахын тулд төв банкнууд мөнгөний зөвлөн бодлого баримталж бодлогын хүг буурууллаа. Мөн мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлж, төсөв, мөнгөний бодлогыг их хэмжээгээр тэлсэн нь бодит секторт зээл тасалдахгүй байх нөхцөлийг бүрдүүлж, эдийн засагт дэмжлэг үзүүлэв. Гэвч энэ нь засгийн газруудын өрийг нэмэгдүүлж инфляцийг өрдөх шалтгаан болов. ОУВС-гийн тооцооллоор хөгжиж буй орнуудын Засгийн

Эдийн засгийн өсөлт, инфляфи

Вакцинжуулалттай зэрэгцэн 2021 оноос эдийн засгийн сэргэлт идэвхжэв. Дэлхийн аж үйлдвэрлэлийн хэмжээ 2020 оны 4 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 15.6 хувиар буурч байсан бол 2021 оны 6 дугаар сарын байдлаар 11.7 хувиар өсөж, цар тахлын өмнөх түвшинд хүрлээ. Үүнд, удаан эдэлгээт бараа (ялангуяа автомашин) болон зайнлас үйлдвэрлэх боломжтой бүтээгдэхүүний эрэлт нэмэгдсэн нь томоохон нөлөө үзүүлэв. Дэлхийн банк, ОУВС-гийн төсөөллөөр дэлхийн худалдааны хэмжээ 2021 онд 8.3 - 8.4 хувиар, 2022 онд 6.3 хувиар өсөх хүлээлттэй байна.

Мөнгөний зөвлөн бодлого, газрын тос, түүхий эдийн үнийн өсөлт болон худалдааны салбарын сэргэлттэй холбоотой инфляцийн түвшин 2021 онд бүхий л улсад өссөн үзүүлэлттэй байна. АНУ-ын инфляцийн түвшин 2021 оны эхний хагас жилийн байдлаар 3.9%, Азийн орнуудын инфляцын түвшин 2.4% байгаа бол 2022 онд инфляцийн түвшин 2.7%-д хүрэх төлөвтэй байна гэж Азийн хөгжлийн банкны ADO 2021 эхний хагас жилийн тайланд тусгажээ.

График 5 Инфляцид нөлөөлж буй хүчин зүйлс





График 4 Инфляцийн өсөлт болон хүлээлт



Эх сурвалж: Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллага

Д. Сүр





Түүхий эдийн үнийн өсөлт, цаашдын төлөв

Манай улсын эдийн засагт нүүрс, зэс, төмрийн хүдэр зэрэг таваарын түүхий эдийн ханш онцлох нөлөөтэй байдаг билээ. 2021 онд дэлхийн зах зээл дээрх металл, түүхий эдийн үнэ сэргэж, манай улсын экспортын орлогод дэмжлэг үзүүллээ. БНХАУ-ын аж үйлдвэрлэл сэргэж, зарим томоохон бус нутгуудад төсвийн хөрөнгө оруулалтууд нэмэгдэх нөлөөгөөр металлын зах зээлд зэрэг хүлээлт давамгайлж, аж үйлдвэрлэл, барилгын салбарт ихээхэн ашиглагддаг суурь металлууд болох зэс, төмрийн хүдрийн үнэ 2021 оны 6 дугаар сард өмнөх оны мөн үеэс харгалзан 63 хувь, 68.3 хувиар тус тус нэмэгдэв. Суурь металлуудын үнийн индекс 2021 онд 32.1 хувиар өсөх хүлээлттэй байгаа бол 2022 онд тогтворжих, 4.5 хувиар саарах төлөвтэй байна (ОУВС-гийн төсөөлөл).

Суурь металлуудын үнэ эрэлтийн гаралтай буюу эдийн засгийн өсөлтөөс, газрын тосны үнэ эрэлт болон нийлүүлэгч орнуудын хязгаарлалт буюу нийлүүлэлтээс, ХАА-н бүтээгдэхүүнүүд нийлүүлэлтийн гаралтайгаар тус тус үнийн өсөлт үзүүлжээ.

Нүүрс

Зах зээл дэх нүүрсний үнэ 2021 онд огцом өссөн нь цар тахлын дараах эдийн засгийн сэргэлт, зүүн хойд Азийн цаг агаарын онцлог (хүйтэн) болон нийлүүлэлтийн хэмжээ өөрчлөгдсөнтэй холбоотой.

Цаашдын төлөв: Уур амьсгалын өөрчлөлтийн тухай Парисын хэлэлцээрийн үеэр улс орнууд нүүрсний хэрэглээг багасгах, нүүрстөрөгчийн ялгарлыг багасгах талаар зорилт тавьсан хэдий ч огцом халж чадахгүй байна. Олон улсуудад сэргээгдэх эрчим хүчийг цахилгаан үйлдвэрлэх хамгийн хямд өртөг бүхий эх үүсвэр болгохоор зорин ажиллаж буй. Гэвч богино хугацаанд буюу 1-2 жилд нүүрсний үнэ одоогийн үнэд тогтворжих хүлээлттэй байна.

Зэс

2021 оны 1-р улиралд зэсийн үнэ 18%-р өсч, гуравдугаар сард дунджаар 9000 ам.доллар/тонн байсан нь бараг 10 жилийн хугацаанд байгаагүй өндөр үзүүлэлт байв. Хятад улс дэд бүтэц, барилгын салбartaа ихээхэн хөрөнгө оруулалтуудыг хийж эхэлсэн нь зэсийн эрэлтийг нэмэгдүүлсэн бол эрчим хүчний шилжилт, ялангуяа цахилгаан машин (цахилгаан хөдөлгүүр), сэргээгдэх эрчим хүчний хэрэглээ нэмэгдсэнээр цаашид зэсийн эрэлт улам өсөх хандлагатай байна. Зэсийн үнэ 2021 онд дунджаар 38%-р өсөх төлөвтэй байгаа ч нийлүүлэлтийн хэмжээ нэмэгдэхийн хэрээр 2022 онд 12%-р буурах төлөвтэй байна гэж дэлхийн банкны зүгээс дүгнэжээ.

Алт

Алтны үнэ 2021 оны 1 -р улиралд 4%-р буурсан нь эрэлт буурч, нийлүүлэлт өссөнтэй холбоотой. Төв банкнууд алтны худалдан авалтаяа бууруулснаас гадна алтны эрэлт цар тахлаас өмнөх үетэй харьцуулахад доогуур үзүүлэлттэй байна. Түүнчлэн АНУ-ын инфляциаас хамгаалагдсан ЗГҮЦ-ы өгөөж 1-р сард -1% байсан бол 3 -р сард - 0.66% болж өсөн 2020 оны 6 -р сараас хойших хамгийн өндөр өсөлтийг үзүүлснээр алтны эрэлтийг бууруулахад хүргэсэн. Цаашид эдийн засгийн өсөлттэй холбоотойгоор алтны үнэ тогтворжих хандлагатай байна.



Коронавирус халдварын нөхцөл байдал

Дэлхий нийтээр 2021 оны 10 дүгээр сарын 07-ны өдрийн байдлаар коронавирус халдвараар 238 сая хүн өвчилж, 4.8 сая хүн нас барж, 215 мянган хүн эдгэсэн байна.

График 7 Өдөрт бүртгэгдэж буй өвчлөлийн тоо





График 6 Вакцинжсан хүн амын тоо




Эх сурвалж: ourworldindata.org

Дэлхий даяар 6.5 тэрбум вакцинжуулалт хийгдсэн ба өнөөдрийн байдлаар нийт хүн амын 46.4% хамгийн багадаа 1 тунд бүрэн хамрагдсан байна. Өндөр хөгжилтэй орнууд буюу Европын холбоо хүн амын 60%, АНУ хүн амын 50 гаруй хувийг бүрэн вакцинжуулсан байна. Гэвч өдөрт гарах халдварын тохиолдол 2020 оны сүүл үеэс буурсан ч эдийн засаг хэвийн явагдах түвшинд буурахгүй байгаа нь цар тахлын нөлөөлөл дэлхийн эдийн засгийн өсслтийн суурь шалтгаан хэвээр хадгалагдах төлвийг харуулж байна.

Ирээдүйн төлөв

Олон улсын валютын сан (IMF)-гаас гаргасан “Дэлхийн эдийн засгийн төлөв байдал” 2021 оны эхний хагас жилийн тайланд дэлхийн ДНБ 2021 онд 6%-иар, 2022 онд 4.9%-иар өснө хэмээх төсөөллийг гаргажээ. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-аас болон дэлхийн банкны зүгээс дэлхийн эдийн засаг 5.6% өсөх төлөвтэй гэжээ. Дэлхийн эдийн засгийн дөрөвний нэгийг АНУ, Хятад зэрэг өндөр хөгжилтэй орнуудын эдийн засаг бурдуулдэг гэдгийг онцлуулжээ.

График 8 ДНБ-ийн төсөөлөл



Эх сурвалж: Дэлхийн банк



Дотоодын макро орчин

Эдийн засгийн голлох үзүүлэлтүүд

Үзүүлэлт	2018	2019	2020	2021-I	2020-II	Өөрчлөлт	Нэгж
ДНБ, оны үнээр	32,411	36,898	36,958	8,803	10,478	19%	Тэрбум, төг
ДНБ-ний өсөлт	7.2%	5.1%	-5.3%	15.5%	-		Хувь
бодит							
Нэгдсэн төсвийн орлого	10,054	11,937	10,402	2,876	7,106	147%	Тэрбум, төг
Нэгдсэн төсвийн тэнцэл	831	508	-96272	151	-392	-360%	Тэрбум, төг
Гадаад валютын албан нөөц	3,549	4,349	4,534.2	4,774	4,731	-1%	Сая ам.дол
Экспорт	7,012	7,620	7,576	3,974	4,111	3%	Сая ам.дол
Импорт	5,875	6,127	5,293	2,904	3,261	12%	Сая ам.дол
Төлбөрийн тэнцэл	-142	453	2,282	1,070	-54.2	-105%	Сая ам.дол
Долларын ханш	2427	2644	2734	2849	2849	0%	Төгрөг
Бодлогын хүү	11.0%	11.0%	6.0%	6.0%	6.0%	0%	Хувь
Инфляцын төвшин	8.1%	5.2%	2.3%	3.1%	7.4%	139%	Хувь
Чанаргүй зээл (Банк)	10.4%	10.1%	11.2%	11.5%	10.0%	-11%	Хувь
Чанаргүй зээл (ББСБ)	9.5%	8.5%	10.3%	10.3%	9.7%	-6%	Хувь
Зээлийн өрийн үлдэгдэл	17,226	18,096	17,683	17,636	19,158	9%	Тэрбум төг

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монгол банк, СЗХ





Хүснэгт 2 Эдийн засгийн өсөлт салбараар

	2018	2019	2020	2021
Жил бүрийн эхний улирал				
Эдийн засгийн өсөлт	6.2	8.6	-10.7	15.7
Хөдөө аж ахуй	3.7	2.1	14.0	-6.6
Үйлдвэрлэл	5.6	14.0	-19.6	26.6
Уул уурхай	3.8	14.4	-29.5	34.1
Боловсруулалт аж үйлдвэр	7.9	7.3	5.1	20.1
Цахилгаан	9.6	3.7	6.8	7.6
Барилга	27.2	7.3	12.0	-6.4
Үйлчилгээ	4.4	7.6	-6.8	3.6
Худалдаа	6.0	15.1	-11.1	6.3
Тээвэр	0.1	3.4	-30.6	5.6
Мэдээлэл, холбоо	6.4	10.7	0.3	3.7
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	4.7	5.2	0.7	2.2
Цвэр татвар	16.4	5.5	-7.9	45.3

Цар тахалтай холбоотой 2020 оны эдийн засгийн уналт, 2021 оны сэргэлт Монгол улсад мөн ажиглагдав. 2021 оны эхний улиралд эдийн засаг өмнөх оны мөн үеэс 15.7 хувь өссөн байна. Нүүрсний экспорт эхний улиралд өмнөх оны мөн үеэс 113.7 хувиар өссөн, Оюутолгойн зэсийн баяжмал дахь алтны агууламж нэмэгдсэн, зэсийн баяжмалын экспортын хэмжээ 77.2 хувиар өссөн, бодлогын хүүг бууруулж, 10 их наядын хөтөлбөр хэрэгжүүлсэн зэрэг үйл явдлууд эдийн засгийн өсөлтдэд голлох нөлөөлөв үзүүлэв. Гадаад худалдааны тэнцэл 2021 оны эхний хагас жилд 7.4 тэрбум амдолларт хүрч 39.4 хувиар өссөн ба үүнд экспортын хэмжээ 45.4 хувь, импортын хэмжээ 32.6 хувь өссөн нь нөлөөлжээ. Уул уурхайн бус бүтээгдэхүүний экспорт өмнөх оны мөн үеэс 152.8 хувиар өссөн ба үүнд угаасан ноолуур, хушны самар, лаазалсан махны экспортын өсөлт голлох нөлөөг үзүүлжээ. Дизель түлш, ачааны автомашин, чиргүүл болон тэдгээрийн эд ангийн импорт нэмэгдсэн нь импортын хэмжээ өсөхөд голлох нөлөөг үзүүлэв (Сангийн яам, Статистикийн хороо).

График 10 Экспортын голлох бүтээгдэхүүн





График 9 Импортын голлох бүтээгдэхүүн



Эх сурвалж: УСХ

Манай улсын голлох түүхий эдийн ханшийн мэдээлэл доорх байдалтай байна.

Хүснэгт 3 Экспортын голлох бүтээгдэхүүн

	Бүтээгдэхүүн		Q1	Q2	Q3	Q4	Q1
	2019	2020					
Нүүрс (Австрали)	77.9	60.8	68.0	54.4	52.1	68.6	89.5
Газрын тос	61.4	41.3	49.1	30.3	42.0	43.6	59.3
Зэс	6,010	6,174	5,634	5,351	6,525	7,185	8,477
Төмөр	93.8	108.9	90.8	93.9	117.8	133.2	167.2
Алт	1,392	1,770	1,583	1,710	1,912	1,875	1,798
Мөнгө	16.2	20.5	16.9	16.3	24.5	24.4	26.3

Эх сурвалж: Дэлхийн банк

Д.Сүрье



2022 - 01 - 28

СЭХ
7007.09.12. одаа
БҮРТГЭВ

Төсвийн тодотголд цэвэр зэсийн үнийг тонн тутамд 9,076 ам.доллар, нүүрсний үнийг тонн тутамд 75-125 ам.доллар, зэсийн баяжмалын экспортын хэмжээг 1,118.4 мянган тонн, нүүрсний экспортын биет хэмжээг 28.7 сая тоннд хүрнэ гэж тооцсон. Улмаар уул уурхайн салбараас нийт 3,515.6 тэрбум төгрөгийн орлого, үүнээс 47.5 хувь орлогыг зэсээс, 36.6 хувь нүүрснээс, үлдэх 15.9 хувь орлогыг бусад ашигт малтмалаас бүрдүүлэхээр тооцон оруулсан байна.

2020 оноос эхлэн эдийн засгийг идэвхжүүлэх чиглэлээр бодлогын хүүг 6 хувь буюу түүхэн доод түшвинд хүргэнсээр зээлийн болон хадгаламжийн хүү буурав. Үүнтэй холбоотой зээл гаргалт мөн 2 их наяд орчим төгрөгөөр өссөн байна. Шатахууны үнэ, сайжруулсан шахмал түлшний үнэ, мөн хүнсний бүлгийн үнэ өссөнтэй холбоотойгоор инфляцийн түвшин огцом өсөлт үзүүлэв. Мөн хугацаагүй хадгаламжийн хүүг тэг болгосонтой холбоотой хугацаатай хадгаламжийн хүү эрс буурч одоогийн байдлаар шинээр татсан хадгамламжийн хүү 7.58 хувийн жигнэсэн дундаж хүү хүрсэн нь хадгаламжийн бодит хүүг сөрөг түвшинд оруулав. Инфляцийн түвшин Монголбанкны зорилтот түвшин болох 6+2 нэгж хувьд байгаа бөгөөд удаан үргэлжилсэн инфляциын дарамт үүсэн тохиолдолд нэмэгдүүлэх хүлээлттэй байна.

Дүгнэлт

2021 онд гадаад худалдааны нийт эргэлт 14.5 тэрбум ам долларт хүрч, гадаад худалдааны тэнцэл 1.9 тэрбум ам долларын ашигтай гарах, томоохон дүнтэй бонд, зээлийн эргэн төлөлттэй холбоотой валютын гадагшлах урсгал байхгүй тул төлбөрийн тэнцэл ашигтай гарах талаар төсвийн тодотголд дурджээ. Гэвч төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл -2,842.7 тэрбум буюу ДНБ-ий -6.8 хувьтай тэнцэхээр төлөвлөж байна.

Хүснэгт 4 ЭЗЭ-ийн голлох үзүүлэлт төсөөллүүд

Үзүүлэлт	Бодит	2021-II	2021-III	2021-IV	2022-I	2022
ДНБ өсөлт, %	-5.3	6.5	6.5	5.1	5.1	5.1
Ажилгүйдлийн хувь, %	7.6	10	8.5	8.5	7.5	7.5
Инфляцийн хувь, %	2.6	4	4.5	4	3.6	4
Зээлийн хүү, %	6	6	6	6	6.25	7
Худалдааны тэнцэл /сая доллар/	412.3	35	31	350	350	350
ДНБ-д эзлэх засгийн газрын өр, %	55	82	82	82	82	82

Эх сурвалж: Trading view

Ирэх 3-5 жилд эдийн засагт эерэг нөлөөлөлтэй хэд хэдэн онцлох үйл явдлууд хүлээгдэж байна. 2022 онд төмөр зам ашиглалтад орох, түүнтэй холбоотой нүүрсний экспорт жилд 2-3 дахин өсөх хүлээлттэй байна. Мөн 2023 онд Оюутолгойн далд уурхайн экспорт эхэлснээр одоогийн түвшнээс зэсийн экспорт 2 дахин өсөх боломж бий болох ажээ. Эдийн засгийн сэргэлттэй холбоотойгоор 2021 онд огцом өсөлт үзүүлсэн таваар, түүхий эдийн ханш 2-3 жилийн хугацаанд энэ түвшинд тогтвортыхих хүлээлттэй байгаа нь төмөр зам, Оюутолгойн төслийн хэрэгжилттэй давхцах, улмаар дунд хугацааны эдийн засгийн хүлээлтийг эерэг болгож байна. Дээрх том төслүүдийн хэрэгжилт нь ирэх жилүүдэд хүлээгдэж буй засгийн газрын бондын төлөлтуүдийг төлөх, дахин санхүүжүүлэхэд өндөр ач холбогдолтой ба хэрэгжилтэд асуудал, удаашрал үүсэх тохиолдолд мөн сөрөг нөлөө өндөр юм.

Д.Чир

Хөрөнгийн зах зээлийн нөхцөл байдал

БҮРТГЭВ-СС



2021 онд Монголын хөрөнгийн биржийн арилжааны дүн 1 их наяд төгрөгийг, ТОП-20 индекс 41 мянган нэгжийг, зах зээлийн үнэлгээ 4.5 их наяд төгрөгийг тус тус давснаар хөрөнгийн зах зээлийн түүхэн дээд үзүүлэлтүүдийг шинэчлэлээ. 2021.09.16-нд MSE Top 20 индекс жилийн эхэн үетэй харьцуулахад 130 орчим хувийн өсөлт үзүүлснээр 2021 оны дэлхийд хамгийн өндөр өсөлт үзүүлсэн хөрөнгийн зах зээлтэй улсаар тодорлоо.

График 11 Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ



Шинэ бүтээгдэхүүнүүд

Эх сурвалж: МХБ

Хөрөнгийн зах зээлийн өсөлт нь эрэлт болон нийлүүлэлтийн шалтгаантай бий боллоо. Эрэлтийн гаралтай өсөлт нь 2020 оны дунд үеэс бодлогын хүүг бууруулснаар банкны хадгаламжийн хүү буурч, инфляцийн түвшин өссөнтэй холбоотой. Хадгаламжийн бодит өгөөж сөрөг утга уруу орсон нь иргэд болон аж ахуй нэгжүүд бусад төрлийн хөрөнгө оруулалтын хэрэгслийг эрэлхийлэх үндсэн хүчин зүйл болж хөрөнгө оруулагчдын хөрөнгийн зах зээл уруу чиглэх урсгалыг нэмэгдүүлэв.

График 13 Арилжааны идэвхи





График 12 Топ 20 индекс



Эх сурвалж: МХБ

Бүтээгдэхүүний нийлүүлэлтийн гаралтай өсөлтөд Монгол улсын түүхэн дээд дүн бүхий компанийн бонд, хөрөнгө оруулалтын сан, анхны нээлттэй ХБҮЦ зэрэг олон төрлийн бүтээгдэхүүнүүд гарсан нь нөлөөлөв. Жилийн эхний хагаст Монголын хөрөнгийн биржид Эрдэнэс Таван толгой ХК-ийн ETT бонд 677 тэрбум төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлж, анхны нээлттэй 4 тэрбум төгрөгийн дүн бүхий Инвекспор актив ТЗК-ийн ХБҮЦ бүртгэгдэн, Инвекспор ББСБ ХК-ийн 8 тэрбум, ЛэндМН ББСБ ХК-ийн 5 тэрбум төгрөгийн нээлттэй бонд бүртгэгдсэн юм.

Д. Нямжаргалан



2022 -01 - 28

БҮРТГЭВ-03

Цаашдын төлөв, хүлээлт


СЗХ
2022 , бр. 1.2 өдөр
БҮРТГЭВ
№ 04

2020 онд банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжсэн билээ. Банкны тухай хуулийн төсөлд банк нь зөвхөн хувьцаат компани хэлбэртэй байх тухай, аливаа этгээд банкны саналын эрхтэй хувьцааны 20-иос дээш хувийг эзэмшихийг хориглох тухай туссан. 2022 оны хагас жил гэхэд топ 5 банк хувьцаат компани болж хөрөнгийн биржид бүртгэгдэх, нийт хувь эзэмшлийн 10-с дээш хувийг гаргах үүрэг хүлээгээд байгаа бол 2021 оны 9 сарын байдлаар 11 банк СЗХ болон төв банканд хувьцаат компани болох төлөвлөгөөгөө ирүүлсэн талаар мэдээллэсэн байна. 2021 оны 3-р улирлын тайлан мэдээлэлд тулгуурлан Топ 5 банк дотоодын хөрөнгийн бирж дээр гарвал татах дүн болон хөрөнгийн зах зээлийн үнэлгээ хэрхэн өөрчлөгдхө талаар дараах таамгийг дэвшүүлж байна.

Хүснэгт 5 Банкнуудын хөрөнгө босголт-төсөөлөл

График 14 Санхүүгийн зах зээлийн хэмжээ

Банк	Эздийн өмч	Эздийн өмч*1.5	Татах дүн
Хаан банк	1298.2	1947.3	194.7
Голомт банк	591.7	887.5	88.7
ХХБ	1094.7	1642.1	164.2
Хас банк	316.6	474.9	47.5
Төрийн банк	384.4	576.6	57.6
Нийт	3685.6	5528.4	552.8



Стратегийн 5 банкны нийт өөрийн хөрөнгө 2021 оны 3-р улирлын байдлаар 3.7 их наяд төгрөг байна. PB ratio 1.5 буюу өөрийн хөрөнгийн дүнг 1.5 дахин үнэлж зах зээлд санал болговол 5 банкны нийт үнэлгээ 5.5 их наяд төгрөг болно (төсөөлөл). 2022 оны 6 сараас өмнө 10-с доошгүй хувийг санал болгоно гэж үзвэл 553 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 5 банк татах юм. Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2021 оны 9 сарын байдлаар 4.9 их наяд байгаа бол топ 5 банкны үнэлгээний төсөөллийг нэмж тооцвол 10.4 их наяд болно. Эдгээр нь зөвхөн топ 5 банкны үзүүлэлтэд тулгуурласан тооцоолол ба илүү олон банкууд нээлттэй болох, түүнээс үүдэн илүү өсөлт үзүүлэх хүлээлттэй байна. Зөвхөн банкны IPO-той холбоотой хөрөнгийн зах зээлийн үнэлгээ хамгийн багадаа 2 дахин өсөх хүлээлт үүсч байгаа нь богино хугацаанд Монголын хөрөнгийн зах зээл хурдацтай тэлэх төлвийг харуулж байна. Мөн 2021 оны 9 сарын байдлаар манай улсын мөнгөний нийлүүлэлт 26.3 хувиар өсч 27.1 их наяд төгрөгт хүрсэн буюу Монгол банкны зүгээс эдийн засгийг дэмжих чиглэлээр мөнгөний зөвлөн бодлого хэрэгжүүлж зах зээлд эргэлдэх мөнгөний хэмжээг нэмэгдүүлсэн байна. Сул мөнгөний урсгал нь хөрөнгө оруулагчдын хувьд ихэвчлэн банкны хугацаатай хадгаламж руу чиглэдэг байсан бол өгөөжийн түвшин буурснаар дараагийн сонголт болох хөрөнгийн зах зээл руу шилжилт нэмэгдэх хүлээлттэй байна. Дэлхийн улсуудад ч мөн мөнгөний зөвлөн бодлогын нэлөөлөл, мөнгөний нийлүүлэлтийн өсөлт, эдийн засгийн өсөлтийн хүлээлт нь хөрөнгийн зах зээлийн өсөлтийг өрдөх үзэгдэл бий болж дэлхийн хөрөнгийн зах зээлийн ихэнх индексүүд өсөлт үзүүлэн АНУ-ын S&P 500 индекс 25 хувь, Английн FTSE 100 индекс 12 хувь, Германы DAX 17 хувь, Японы NIKKEI 8.5 хувь өсөлт үзүүлээд байгаа юм. Төмөр зам, оюутолгойн далд уурхайн олборлолт эхлэх, цар тахлын нэлөөлөл эдийн засгийн засагт буурах зэрэг зөрөг төсөөллүүдтэй холбоотойгоор өрхийн орлого нэмэгдэх, түүнийг даган хөрөнгийн зах зээл руу чиглэх хөрөнгийн урсгал мөн нэмэгдэх хүлээлттэй байна.



2022 -01- 28

Банк бус санхүүгийн байгууллага

БААНЫ САЛБАРЫН ТООН ҮЗҮҮЛЭЛТ

Хүснэгт 6 ББСБ салбарын тоон үзүүлэлт



Салбарын үзүүлэлт	2017	2018	2019	2020	2021-II
ББСБ тоо	534	539	538	532	536
Харилцагчдын тоо	1,387,894	1,601,749	2,854,530	2,844,782	3,292,164
Санхүүгийн үзүүлэлтүүд, тэрбум ₮					
Нийт хөрөнгө	969.2	1,284.9	1,730.1	2,006.9	2,263.0
Нийт өр	218.7	319.7	502.8	591.1	768.8
Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө	595.4	740.6	927.0	1,017.7	1,047.9
Нийт хуримтлагдсан ашиг	155.1	224.6	300.3	398.1	446.3
Зээлийн багцийн ангилал, тэрбум ₮					
Нийт зээл	638.0	869.2	1,233.1	1327.0	1571.9
Хэвийн зээл	527.0	752.9	1,072.8	1,125.7	1373.1
Хугацаа хэтэрсэн	29.9	33.4	54.9	64.9	46.0
Чанаргүй	81.1	82.9	105.4	136.4	152.7
Хэвийн бус	17.6	15.7	21.3	30.3	34.4
Эргэлзээтэй	14.2	19.0	25.6	28.7	29.4
Мүү	49.3	48.2	58.5	77.4	88.9
Зээлийн эрсдэлийн сан	(56.0)	(64.5)	(81.1)	(104.4)	(116.0)
Зээлийн багцийн ангилал хувиар					
Нийт зээл	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%
Хэвийн зээл	82.6%	86.6%	87%	84.8%	87.4%
Хугацаа хэтэрсэн	4.7%	3.8%	4.5%	4.9%	2.9%
Чанаргүй зээл	12.7%	9.5%	8.5%	10.3%	9.7%
Хэвийн бус	2.8%	1.8%	1.7%	2.3%	2.2%
Эргэлзээтэй	2.2%	2.2%	2.1%	2.2%	1.9%
Мүү	7.7%	5.5%	4.7%	5.8%	5.6%
Зээлийн эрсдэлийн сан	8.8%	7.4%	6.6%	7.8%	7.4%

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо



Банк бус санхүүгийн байгууллага нь 2021 оны 2 дугаар улирлын байдлаар нийт хөрөнгийн хэмжээ 2.3 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 400.8 тэрбум төгрөгөөр буюу 21.5 хувиар, 2017 оны 2 дугаар улирлаас 1.3 их наяд төгрөгөөр буюу 164.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Мөн салбарын харилцагчдын тоо 3.3 тэрбумд хүрсэн нь 2017 оны үзүүлэлтээс 146 хувиар өссөн үзүүлэлт юм. Үнд цахим зээлийн үйлчилгээг үзүүлэгч ББСБ-ийн нөлөөлөл өндөр байна. Нийт харилцагчдын 90.7%, зээлдэгчдийн 66.0% нь санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж /финтек/, онлайн зээлийн үйлчилгээ нэвтрүүлж буй ББСБ-уудын харилцагч, зээлдэгч байгаа нь сүүлийн жилүүдэд финтек шийдэл тус салбарын өсөлтийн үндсэн хүчин зүйл болж буйг харуулж байна.

Мөн хөрөнгийн бүтцийг авч үзвэл 69 хувь өөрийн хөрөнгө, 31 хувь өр төлбөр эзэлж байгаа нь санхүүгийн хувьд харыцангуй эрүүл, эрсдэлийн түвшинг бага түвшинд барьж байгааг харуулж байна. Харин хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ арилжааны банкнуудын хувь нийлүүлсэн хөрөнгөөс өндөр байгаа нь ББСБ-үүд нь банктай харьцуулахад хадгаламж татдаггүй буюу эх үүсвэрийн ихэнх хувийг өөрийн хөрөнгөндөө тулгуурлан үйл ажиллагаа эрхэлдэгтэй холбоотой.

Хөрөнгийн өсөлт, өөрийн хөрөнгө, эздийн өмч

График 15 ББСБ-ийн эх үүсвэрийн бутэц






График 16 ББСБ-ийн хөрөнгийн өсөлт



Зээлийн улдэгдэл, олгосон салбарын ангилаал

График 17 Зээлийн үлдэгдэл (хугацаагаар)



2021 оны 2-р улирлын байдлаар нийт 1.1 тэрбум төгрөгийн зээл олгосон бөгөөд үүний дийлэнх буюу 88.2 хувийг иргэдэд, 11.8 хувийг хуулийн этгээдэд олгосон байна. Нийт олгосон зээлийг төрлөөр ангилбал 60 хувийг хэрэглээний зээл, 24.4 хувийг бизнесийн, 15.6 хувийг бусад зээл эзэлж байна. Нийт олгосон зээлийг салбарын ангилбал 65 хувийг бусад буюу хэрэглээний, 10.1 хувийг бөөний болон жижиглэн худалдааны салбарт олгосон.

хугацаатай олгосон зээл нийт зээлийн 25.8 хувийг, 6-12 сарын хугацаатай олгосон зээл нийт зээлийн 21.3 хувийг буюу хамгийн өндөр хувийг бүрдүүлжээ. Дээрх үзүүлэлтүүд нь ББСБ-үуд ихэвчлэн иргэдэд, хэрэглээний зориулалттай богино хугацаатай зээлүүдийг олгодгийг илэрхийлж өндөр жинг эзэлж байна.


Зээлийн хугацаагаар ангилбал 1-2.5 жилийн

J. C. L.



Бага дүнтэй, хэрэглээний зээл түлхүү гаргадаг тул ББСБ-ийн зээлийн чанарын үзүүлэлт нь банкны салбарын чанарын үзүүлэлтээс сайн байна.


График 18 Зээлийн чанарын узүүлэлт



Ашигт ажиллагааны үзүүлэлт

Санхүүжилтийн эх үүсвэрийн ихэнх хувийг өөрийн хөрөнгө бүрдүүлдэг тул эх үүсвэрийн зардал бага байдаг. Мөн богино хугацаат зээл зонхилдог тул мөнгөний эргэц өндөр, банкны хүүгийн түвшинтэй харьцуулахад өндөр хүйтэй зээл олгож буйтай холбоотой борлуулалтын орлого өндөр байна. Орлого өндөр, зардал бага суурь хүчин зүйлээс хамаарч салбарын дундаж цэвэр ашгийн маржин 39 хувь буюу бусад бизнесүүдтэй харьцуулахад маш өндөр байна.

График 19 Ашиг ажиллагааны үзүүлэлт



Луценко

ББСБ нь финтекийн хөгжилтэй зэрэгцэн санхүүгийн салбарт хамгийн өндөр өсөлттэй салбарын нэгзээр тооцогдож буй. Тус салбар нь ихэвчлэн хэрэглээний, богино хугацаатай, иргэдийн зээл олгодог онцлог нь нийт салбарын тухайд эрсдэлийг бууруулдаг ба 2018 оноос хойш тогтмол банкны чанаргүй зээлийн үзүүлэлтээс бага чанаргүй зээлтэй байна. Мөн эх үүсвэрийн бутцийн хувьд ихэнх буюу 69 хувийг өөрийн хөрөнгө зээлдэг нь салбарын эрсдэлийг бууруулах, өрийн дарамт, хүүгийн зардал бага байх нэхцэлийг бий болгож салбарын цэвэр ашгийн маржинг өсгөх суурь нэхцэл болжээ. Сүүлийн 4 жилийн хугацаанд нийт зээлийн үлдэгдлийн хэмжээ 2.4 дахин өссөн нь тус салбарт зээлийн эрэлт өндөр байгааг илэрхийлж байна.





ҮНЭТ ЦААС
ГАРГАГЧИЙН
ТУХАЙ

Т. Сүрэг



2022 -01- 28



ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 11.1-т зааснаар Баталгаат үнэт цаасыг тусгай зориулалтын компани гаргах эрхтэй. Мөн хуулийн 6.1-т зааснаар Хорооноос хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авах шаардлагатай.

Үнэт цаас гаргагч “Омни Актив” ХХК 2021 оны 7 сарын 28-ний өдөр үүсгэн байгуулагдсан хуулийн этгээд бөгөөд Хорооны 2021 оны 11 сарын 24 өдрийн 534 тоот тогтоолоор Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасан хөрөнгөөр баталгаажсан үнэт гаргах үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг авсан болно.

Үнэт цаас гаргагч	“Омни Актив ТЗК” ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9011830497
Улсын бүртгэлд бүртгүүлсэн огноо	2021 оны 08 сарын 16-ний өдөр
Регистрийн дугаар	6742904
Үйл ажиллагааны үндсэн чиглэл	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах
МХБ-д бүртгэлтэй эсэх	Үгүй
Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ	80,000,000 (Наян сая төгрөг)
Хаяг	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Монгол ньюс тауэр барилга, 403 тоот
Утас	99795115, 70105657
Э-Шуудан	davaasuren@omnicapital.mn
Хувьцаа эзэмшигч	“Омни Капитал ББСБ” ХХК
Эзэмшиж буй хувьцаа	80,000ш
Эзэмшлийн хувь	100 хувь

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.4-т баталгаат үнэт цаасыг гаргагч ТЗК-г банк, банк бус санхүүгийн байгууллага, орон сууцны санхүүжилтийн компани болон Хорооноос зөвшөөрсөн санхүүгийн бусад байгууллага байгуулж болох эрхтэй байдаг. “Омни актив ТЗК”-г үүсгэн байгуулагч нь хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан “Омни Капитал ББСБ” ХХК байна. “Омни капитал ББСБ” нь “Омни актив ТЗК”-ийн 80,000 ширхэг энгийн хувьцааг 100 хувь эзэмшдэг.



БИСОН БАЙГУУЛАГЧ
ДАЛДААНЫ СТОСКТ ХӨРНӨЛ
2022-01-28

СЭХ
2022.01.12.6
БҮРТГЭВ
№04

Үүсгэн байгуулагч/Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн тухай

Нэр:	“Омни капитал ББСБ” ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9015003126
РД:	6075657
Үүсгэн байгуулагдсан огноо:	2016.05.10
Тусгай зөвшөөрөл:	<ol style="list-style-type: none"> 1. Зээлийн үйл ажиллагаа 2. Төлбөрийн баталгаа 3. Итгэлцлийн үйл ажиллагаа 4. Факторингийн үйл ажиллагаа 5. Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх 6. Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх
Хувьцаа эзэмшигч:	Ч.Даваасүрэн (56%) ЦБОН ХХК (44%)
Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ	2,500,000,000₮
Арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй эсэх	Үгүй
Хаяг	Улаанбаатар, Сүхбаатар, 8-р хороо, Монгол ньюс тауэр барилга 403
Зарласан болон гаргасан хувьцаа	2,500,000 ширхэг
Хувьцааны нэрлэсэн үнэ	1,000 төгрөг

Үүсгэн байгуулагч нь 2016.05.10-ны өдөр үүсгэн байгуулагдсан, Санхүүгийн зохицуулах хорооноос б teriorийн тусгай зөвшөөрөл эзэмшиж буй компани юм. Үүсгэн байгуулагчийн 5-аас дээш хувийн хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээлэл доорх байдалтай байна.





Ч.Даваасүрэн (56% - 1,400,000 ширхэг)

Ч.Даваасүрэн нь эрүүл мэндийн салбарт удирдах ажиллаж байхдаа өөрийн хүсэл тэмүүллийнхээ дагуу санхүүгийн үйлчилгээ хэрэгцээтэй байгаа ч банкны зээлийн үйлчилгээнд хамрагдах боломжгүй иргэд болон жижиг дунд бизнес эрхлэгчдэд санхүүгийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор "Омни Капитал ББСБ" ХХК-ийг 2017 онд үүсгэн байгуулсан байна.

- 14 жилийн хугацаанд тесөв боловсруулж, байгууллагын санхүү хянаж, 20 гаруй ажилчинтай мэргэжлийн хамт олон удирдсан туршлагатай
- 2017- Үүсгэн байгуулагч, Омни капитал ББСБ
- 2005-2015: Захирал, Өрхийн Эрүүл Мэндийн Төв
- 1995: Хүний Их Эмч (Ахлах Эрхтэй), Анаагаах
- Ухааны Их Сургууль

ЦБОН ХХК – РД:2572869 (44% - 1,100,000 ширхэг)

1999 онд байгуулгасан уул уурхайн салбарын шилдэг ханган нийлүүлэгч компани болох "ЦБОН" ХХК нь "Омни капитал ББСБ" ХХК-ийн 44%-г эзэмшиж байна.

Тус компани нь 1,000,000 гаруй засвар, үйлчилгээний бараанаас гадна уул уурхай, үйлдвэрлэлийн цогц шийдлийг харилцагчиддаа санал болгодог байна.

Компани нь 2017 онд Оюу Толгойн томоохон шугам хоолойн төслийн гэрээнд гарын үсэг зурсан бөгөөд энэ нь компанийн хөгжилд ээрэгээр нөлөөлжээ.

Бүтээгдэхүүнүүд:



GEOORG FISCHER

Хуванцар
шугам хоолой



Хүдэр, чулуулаг,
хаягдлыг
боловсруулах тоног
техөөрөмж



Уул уурхайн тоног
техөөрөмжийн
засвар үйлчилгээн
тусгай багаж



Даралт, температур,
түвшин, урсгал
зэргийн хэмжил зүй

R. Noyon



2022 -01- 28

БҮРТГЭВ-03


Санхүүгийн товч үзүүлэлтүүд



ЦЭВЭР АШИГ

1515.8


сая ₮



ХУУГИЙН ОРЛОГО

2003.9


сая ₮



НИЙТ ХӨРӨНГӨ

14509.5


сая ₮



ЗЭЭЛИЙН БАГЦ

12048.3


сая ₮



ӨӨРИЙН ХӨРӨНГӨ

6875.1


сая ₮



Компани 2016 оноос анх зээлийн үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш үйл ажиллагаагаа хурдацтай тэлэн Санхүүгийн зохицуулах хорооноос 6 төрлийн тусгай зөвшөөрөл эзэмшин Уламжлалт болон дижитал зээлийг харилцагчиддаа санал болгож байна. 2021 оны 3-р улирлын байдлаар компани 85,000 бүртгэлтэй харилцагчтай, 4 салбартайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Компани үйл ажиллагаа явуулж эхэлсэн цагаасаа СЗХ-ноос тогтоосон Банк бус санхүүгийн байгууллагын зохистой харьцааг тогтмол хангаж ажилласан. Мөн санхүүгийн ашгийн болон зохистой харьцааны үзүүлэлтүүд тогтмол салбарын дунджаас өндөр үзүүлэлттэй байжээ.



Зээлийн багцын мэдээлэл



Нийт зээлийн багц өмнөх оны мөн үеэс 100 хувь өсч 12.5 тэрбум хүрсэн байна. Нийт зээлдэгчдийн тоо 2156 хүрч өмнөх оны мөн үеэс 3 дахин өсжээ.

Компани үндсэн 4 төрлийн зээл санал болгодог ба үүнд бизнесийн, дижитал, хэрэглээний, автомашины зээлүүд багтана. Багцын бүтцийг солонгоруулах үйл ажиллагаа хэрэгжүүлснээр бизнесийн зээл 36 хувь, дижитал зээл 22 хувь, хэрэглээний зээл 20 хувь, автомашины зээл 21 хувийг эзэлж байгаа нь 1 төрлийн зээлээс үүдэх эрсдэл, нөлөөллийг багасгах давууталтай юм.


Үндсэн харьцаанууд

Үндсэн үзүүлэлтүүд	2018	2019	2020	2021Q3	Салбар
Нийт хөрөнгийн өгөөж	24.6%	15.4%	13.3%	10.4%	6.0%
Цэвэр ашгийн маржин	76.3%	62.8%	48.4%	43.6%	41.7%
Өөрийн хөрөнгийн өгөөж	28.3%	24.6%	28.2%	22.0%	8.8%
Нийт хөрөнгийн өсөлт	81.8%	203.8%	56.3%		26.7%
Зээлийн өсөлт	289.0%	196.8%	47.3%	41.0%	30.1%
Цэвэр ашгийн өсөлт	880.3%	90.4%	35.6%		29.0%
Өрийн харьцаа	13.3%	37.5%	52.6%	52.6%	31.6%
Зээлийн багц/Нийт хөрөнгө	92.3%	90.1%	84.9%	83.0%	67.0%
Зээлийн багц/Өөрийн хөрөнгө	106.4%	144.2%	179.3%	175.2%	105.0%
Зээлийн үзүүлэлтүүд					
Хэвийн зээл	92.7%	91.9%	86.6%	91.0%	88.8%
Хугацаа хэтэрсэн зээл	1.1%	4.7%	2.5%	2.9%	2.9%
Чанаргүй зээл	6.1%	3.4%	10.9%	6.1%	8.3%

Компанийн ашгийн харьцаа үзүүлэлтүүд болон өсөлтийн үзүүлэлтүүд 2018 оноос хойш салбарын дунджаас өндөр байна. Нийт хөрөнгийг нэмэгдүүлэхийн тулд эздийн өмчийн болон өрийн өсөлтийг тэнцвэртэйгээр нэмэгдүүлснээр зээлийн хэмжээ нэмэгдэн, түүнийг дагах орлогын, цэвэр ашгийн өсөлтүүд өндөр байх нөхцөл бий болжээ. Үйл ажиллагааны зардал салбарын дунджаас бага түвшинд хадгалагдаж буйтай холбоотой цэвэр ашгийн болон өөрийн хөрөнгийн өгөөж өндөр байна. Нийт зээлийн багцыг нийт хөрөнгө болон өөрийн хөрөнгөд харьцуулсан харьцаа мөн салбарын дунджаас өндөр байгаа нь компани хөрөнгөө ашиглан зээл гаргах түвшин өндөр байгааг илэрхийлнэ.

Зээлийн чанарын үзүүлэлтийн хувьд 2021 оны 3-р улирлын байдлаар салбарын дунджаас хэвийн зээл 2.2 нэгж хувь өндөр, хугацаа хэтэрсэн зээл салбарын түвшинд, чанаргүй зээл 2.2 хувиар бага байна.





2022-01-28



Үнэт цаас гаргагчийн удирдлага зохион байгуулалт

Компанийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчийн хурал юм. Хувьцаа эзэмшигчийн хурал нь ээлжит болон ээлжит бус байна. Дараах асуудлыг зөвхөн ХЭХ-аар шийдвэрлэнэ.

1. Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах буюу шинэчилсэн найруулгыг батлах;
2. Компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, томилох, бүрэн эрхийг хугацаанаас өмнө дуусгавар болгох;
4. Компанийн тухайн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох;
6. Төлөөлөн удирдах зөвлөлөөс ХЭХ-аар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал

Тусгай зориулалтын компани нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасны дагуу хөдөлмөрийн гэрээний дагуу ажилтан авч ажиллуулж болохгүй тул гүйцэтгэх удирдлага томилохгүй бөгөөд өдөр тутмын үйл ажиллагааг гэрээний үндсэн дээр гуравдагч этгээдээр гүйцэтгүүлнэ. ТУЗ-ийн үйл ажиллагааны хэлбэр нь ТУЗ-ийн хурал байх бөгөөд ТУЗ нь Компанийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Компанийн дүрэмд заасны дагуу дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Компанийн үйл ажиллагааг удирдах, хянах ажлын хүрээнд дараах журмыг батлах:
 - a. Баталгаат үнэт цаасанд багтах зээлийн сонгох шалгуур үзүүлэлтийг батлах;
 - b. Хөндлөнгийн аудит, хөрөнгө итгэмжлэгдсэн удирдагч, үйлчилгээ үзүүлэгчийг сонгох солих тухай журам;
 - c. Багцын хөрөнгөд өөрчлөлт оруулах, хөрөнгийг багцаас хасах тухай журам;
 - d. Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргэх тухай журам;
 - e. Төлбөр төлөх, цуглуулах тухай журам;
 - f. Эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх тухай журам
2. Компани нь хуулиар гэрээгээр ажилтан томилон ажиллуулахыг хориглосон тул Компанийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх гуравдагч этгээдтэй дараах гэрээг байгуулах:
 - a. Хөрөнгө худалдан авахтай холбоотой гэрээг анхны үүрэг гүйцэтгэгчтэй байгуулах;
 - b. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах ажиллагааны хамтран оролцогч болох Андеррайтер, Хуулийн фирм, Зээлийн шинжилгээ гаргах аудит, Хөрөнгө итгэмжлэгдэн удирдагч нартай гэрээ байгуулах;
 - c. Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж болон бусад байгууллагын өмнө Компанийг төлөөлөн өргөдөл, хүсэлт, гаргах, шаардлагатай гэрээ байгуулах;
 - d. Компанийн нэрийн өмнөөс данс нээлгэх, холбогдох гэрээ байгуулах;
 - e. Хууль болон Компанийн дүрмээр хориглоогүй, шаардлагатай бусад гэрээ хэлцэл хийх.
3. Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргахтай холбоотой хэрэгжүүлэх бүрэн эрх:
 - a. Компанийн хөрөнгийн бүртгэлээс нэмэх, хасах, түүнд өөрчлөлт оруулах тухай шийдвэрийг гаргах, батлах хөрөнгө итгэмжлэгдэн удирдагчдаас уг шийдвэрийн биелэлтийг хангаж ажиллахыг шаардах;



- b. Гэрээнд заасан үндэслэлээр хөрөнгийн багцыг анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдах арга хэмжээ авах, холбогдох шийдвэр гаргах;
- c. Хөрөнгө итгэмжлэгдэн удирдагч нь хөрөнгийн ашиглалт, нөөц хөрөнгийн талаар зөрчил гаргасан тохиолдолд шаардлагатай холбогдох арга хэмжээг авах үүнтэй холбоотой шийдвэр гаргах;
- d. Үйлчилгээ үзүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, хөндлөнгийн аудитыг сонгох;
- e. Хөрөнгө итгэмжлэгдэн удирдагчтай байгуулсан гэрээний дагуу тогтмол тайлан хүлээн авах, тэдгээрийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавих;
- f. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах ажиллагаа болон оролцогчидтай холбоотой бусад арга хэмжээ, үүнтэй холбоотой шийдвэр гаргах.

ТУЗ нь дараах үүрэгтэй. Үүнд:

1. Компанийн дүрмийн хэрэгжилтийг хангах, хангуулах;
2. Компанийн дүрэм, үнэт цаасны танилцуулга, үнэт цаас гаргах, Компани байгуулагдсан гэдэгт баталгаа гаргах;
3. Компанийн хөрөнгийг хадгалж хамгаалах;
4. Хөрөнгө оруулагч болон бусад эрх бүхий этгээдэд тогтмол мэдээлэл хүргэх;
5. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны танилцуулгад тусгасан шаардлагын биелэлтийг хангах;
6. Хууль, журам болон энэхүү дүрэмд заасан бусад үүрэг.

ТУЗ-ийн гишүүд дараах эрх үүрэгтэй байна. Үүнд:

1. Компанийн дүрэм, журам, бүртгэл тайлан, санхүүгийн болон аудитын байгууллагын дүгнэлт болон ТУЗ-ийн бүрэн эрхэд хамаарах асуудлыг шийдвэрлэхэд шаардагдах бусад холбогдох баримт материалтай танилцах эрхтэй;
2. Зарлагдсан хурлуудад оролцох үүрэгтэй бөгөөд хэлэлцэж байгаа асуудлын талаар асуулт тавьж, хариулт авах санал дүгнэлт гаргах эрхтэй;
3. ТУЗ-ийн тогтоолын биелэлтийн талаар холбогдох оролцогчдоос мэдээлэл шаардах эрхтэй;
4. ТУЗ-ийн хуралд оролцох боломжгүй болсон тохиолдолд оролцох боломжгүй шалтгаанаа ТУЗ-ийн даргад эсхүл түүний орлогчид урьдчилан мэдэгдэх;
5. Гишүүнээр ажиллаж буй компани болон компанийн үнэт цаастай холбоотой үйл ажиллагаанд оролцох зорилго гэх мэт компанийн үйл ажиллагаа, гэрээ, төсөлд хувийн арилжаа, ашиг сонирхлын улмаас (шууд болон шууд бус) оролцох бол энэ талаар ТУЗ-ийн даргад нэн даруй бичгээр мэдэгдэнэ;
6. ТУЗ-ийн гишүүнээр ажиллах үедээ олж мэдсэн нууц, дотоод болон бусад албан мэдээллийг 5 жилийн турш мэдээллийг ашиглах ёсгүй хүмүүст задруулахгүй, хувийн ашиг сонирхол болон гуравдагч талын ашиг сонирхлын төлөө ашиглахгүй;
7. Компанийн нууц мэдээллийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах дотоод журмаар тогтоосон дүрэм, журмын дагуу ажиллах;
8. Хараат бус гишүүд хараат бус байдалд нь нөлөөлөх аливаа үйл ажиллагаанаас татгалзана. Хэрэв нөхцөл байдалд өөрчлөлт орсны улмаас хараат бус гишүүн хараат бус байх боломжгүй болсон бол тухайн гишүүн энэ талаар ТУЗ-д бичгээр 14 хоногийн дотор мэдэгдэнэ;
9. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахтай холбоотой аливаа мэдээлэл, баримт бичгийг шалган үзэж гарын үсгээр баталгаажуулах, мэдээллийн үнэн зөвийг хариуцна

ТУЗ Эрх үүргээ хэсэгчлэн шилжүүлэх

ТУЗ нь ТЗК-ийн багцын хөрөнгөд өөрчлөлт оруулах үйл ажиллагаатай холбоотой дараах эрх, үүргээ Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай байгуулах гэрээний дагуу шилжүүлэх эрхтэй.




- ТЗК нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй байгуулсан Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний дагуу шилжүүлэн авсан багцын хөрөнгийг солих, нэмэгдүүлэх тухай мэдэгдлийг Хөрөнгө итгэмжлэн удирдагчаар гүйцэтгүүлэх;
- Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс "Багцын хөрөнгөд тавих шаардлага" хангасан солих болон нэмэгдүүлэх хөрөнгийг "Багцын хөрөнгөд өөрчлөлт оруулах, түүнийг хэрэгжүүлэх журам"-д заасан актаар хүлээн авч, гарын үсэг тамга тэмдэгээр баталгаажуулж, ТЗК-ийн хөрөнгөд бүртгэх;
- ТЗК-ийн багцын хөрөнгөд өөрчлөлт орсонтой холбоотой ТЗК-ийг төлөөлж Үйлчилгээ үзүүлэгчээр шинэчилсэн багцын хөрөнгийн дагуу төлбөр цуглуулахыг шаардах.

ТУЗ-ийн гишүүдийн талаарх мэдээлэл

ТУЗ-ийн гишүүдийг дараах шаардлагыг хангасан Монгол улсын иргэн ажиллаж байгаа болно. Үүнд:

- Дээд боловсролтой;
- Эдийн засаг, эрх зүй, нягтлан бодох бүртгэл, банк, санхүү, хөрөнгийн зах зээлийн аль нэг чиглэлээр мэргэжил эзэмшсэн, тухайн салбарт 5-аас доошгүй жил ажилласан байх;
- Өөр бусад 2-оос дээш ТЗК-ийн ТУЗ-ийн гишүүнээр давхар ажиллаагүй;
- "ТУЗ-ийн гишүүдийн олонхи нь анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үүсгэн байгуулагч, худалдагч, тэдгээрийн хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан болон тэдгээрийн гэр бүлийн гишүүн байхыг хориглоно" гэх заалтыг хангаж байна.

ТУЗ-ийн гишүүдийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон Компанийн дүрэмд заасан үндэслэлээр Компани татан буугдах хүртэл хугацаатай томилсон.

"Омни актив ТЗК" ХХК-ийн ТУЗ нь "Омни актив ТЗК" ХХК-ийн дүрмийн 6 дахь хэсгийн 6.2 дахь хэсэгт заасны дагуу З гишүүний бүрэлдэхүүнтэй байх ба гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. ТУЗ-ийн даргаар хараат бус гишүүн С.Бямбасүрэнг томилсон байна.

Албан тушаал	Овог	Нэр	РД	Эзэмшсэн мэргэжил
Хараат бус гишүүн бөгөөд ТУЗ-ын дарга	Сүхбаатар	Бямбасүрэн	ХВ84102008	Банкны эдийн засагч нягтлан бодогч
Энгийн гишүүн	Сосор	Нина	БЮ84112701	Банкны эдийн засаг
Хараат бус гишүүн	Пүрэвдаваа	Сэлэнгэ	ЗФ90101700	Хуульч


ТУЗ-ын дарга-С.Бямбасүрэн

Ерөнхий мэдээлэл



Ургийн овог:	Сартуул
Овог нэр:	Сүхбаатар Бямбасүрэн
Регистрийн дугаар:	ХВ84102008
Иргэний харьяалал:	Монгол
Зохицуулалттай этгээдэд эрхлэх албан тушаал:	Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга
Эрхэлж байгаа ажил, албан тушаал	"Богд" банкны санхүүгийн газрын захирал





С.Бямбасүрэн нь Санхүү Эдийн Засгийн Дээд сургуульд банкны эдийн засагч, нягтлан бодогч мэргэжлээр бакалаврын зэрэг хамгаалсан. Банк санхүүгийн салбарт 13 жил ажилласан туршлагатай тэрээр 2006-2008 онд "Капитал" банк, 2009-2020 онуудад "Хас" банкинд ажиллаж байсан туршлагатай, одоогоор "Богд" банкинд санхүүгийн газрын захиралаар ажилладаг.

ТУЗ-ЫН ЭНГИЙН ГИШҮҮН-С.Нина

Ерөнхий мэдээлэл



Ургийн овог:	Урианхай
Овог нэр:	Сосор Нина
Регистрийн дугаар:	БЮ84112701
Иргэний харьяалал:	Монгол
Зохицуулалттай этгээдэд эрхлэх албан тушаал:	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн
Эрхэлж байгаа ажил, албан тушаал	"Омни Капитал" ББСБ-ын гүйцэтгэх захирал

С.Нина нь Санхүү Банкны Өлзийт дээд сургуульд банкны эдийн засагч чиглэлээр бакалавр, Санхүү эдийн засгийн дээд сургуульд бизнесийн удирдлагын магистр зэрэг хамгаалсан. Тэрээр "Хас" банкинд 2006-2017 онуудад ажиллаж байсан бөгөөд 2018 оноос хойш одоог хүртэл "Омни Капитал" ББСБ ХХК-ийн Гүйцэтгэх захиралаар ажиллаж байна.

Хараат бус гишүүн-П.Сэлэнгэ

Ерөнхий мэдээлэл



Ургийн овог:	Боржигон
Овог нэр:	Пүрэвдаваагийн Сэлэнгэ
Регистрийн дугаар:	ЗФ90101700
Иргэний харьяалал:	Монгол
Зохицуулалттай этгээдэд эрхлэх албан тушаал:	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн
Эрхэлж байгаа ажил, албан тушаал	Алекс капитал УЦК ХХК-д хуулийн зөвлөх

П.Сэлэнгэ нь БНХАУ-н Шанхай хотын Хайши Их Сургуульд бакалавр, Монгол Улсын Их Сургуульд хуульч мэргэжлээр магистрын зэрэг тус тус хамгаалсан. Өмгөөллийн "Зөв Зохицол" ХХН, "Хууль Эрхийн Судалгааны Төв" ТББ, "Таван Богд Интернэйшнл" ХХК-д хуульч, өмгөөлөгчөөр ажиллаж байсан туршлагатай бөгөөд, одоогоор "Алекс Капитал УЦК" ХХК-д гэрээт хуулийн зөвлөхөөр ажилладаг.



2022 -01- 28

Үнэт цаас гаргагчийн санхүүгийн байдал, төсөөлөл



Үнэт цаас гаргагчийн эхлэлтийн тайлангийн мэдээлэл

Хүснэгт 7 "Омни актив ТЗК" ХХК Эхлэлтийн баланс

Үзүүлэлтийн нэр	Дүн
Мөнгөн хөрөнгө	80,000,000
Нийт хөрөнгө	80,000,000
Компани хувь нийлүүлсэн хөрөнгө	80,000,000
Өр төлбөр ба эздийн өмч	80,000,000

Үүсгэн байгуулагч "Омни капитал ББСБ" ХХК нь үнэт цаас гаргагчид 80 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийснээр үнэт цаас гаргагчийн эхлэлтийн хөрөнгө 80 сая төгрөгтэй тэнцэж байна.

Санхүү байдлын тайлангийн төсөөлөл

Хүснэгт 8 "Омни актив ТЗК" ХХК Санхүүгийн байдлын тайлан (төсөөлөл)

Баланс тайлан (сая. төгрөг)	Q0	Q1	Q2	Q3	Q4	Q5	Q6	Q7	Q8
Бэлэн мөнгө	233	1,030	1,853	2,545	659	1,332	1,918	2,326	31
Дансны авлага	4,955	4,297	3,596	2,943	2,295	1,687	1,123	680	415
Нийт хөрөнгө	5,188	5,327	5,449	5,488	2,954	3,019	3,041	3,005	446
Богино хугацаат өр төлбөр	0	0	0	0	0	0	0	0	0
Урт хугацаат өр төлбөр	5,000	5,000	5,000	5,000	2,500	2,500	2,500	2,500	0
Нийт өр төлбөр	5,000	5,000	5,000	5,000	2,500	2,500	2,500	2,500	0
Хувь нийлүүлсэн хөрөнгө	80	80	80	80	80	80	80	80	80
Хуримтлагдсан ашиг	108	247	369	408	374	439	461	425	366
Эздийн өмчийн дүн	188	327	449	488	454	519	541	505	446
Өр төлбөр ба эздийн өмч	5,188	5,327	5,449	5,488	2,954	3,019	3,041	3,005	446

Үнэт цаас гаргагчийн санхүү байдлын төсөөллийг одоогийн буй багцаас орж ирэх мөнгөн урсгалд үндэслэн дээрх байдаар төсөөлж байна. Үнэт цаасны төлбөрийг бүрэн төлж дууссанаар Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасны дагуу ТЗК нь татан буугдан, үүсгэн байгуулагчид холбогдох хөрөнгийг хуваарилна.



2022 -01 - 26

СҮЙ

2022.01.12
БҮРДЛЭВ
№ 21**Орлогын тайлангийн төсөөлөл****Хүснэгт 9 "Омни актив ТЗК" ХХК Орлогын тайлан (төсөөлөл)**

Орлогын тайлан (сая. төгрөг)	Q0	Q1	Q2	Q3	Q4	Q5	Q6	Q7	Q8
Хүүгийн орлого	123	370	354	267	224	188	144	82	58
ХБҮЦ-ийн хүүгийн төлбөр	0	181	181	181	181	91	91	91	91
Удирдлагын зардал	0	4	4	4	4	4	4	4	8
Төлбөр цуглуулах үйлчилгээний зардал	3	21	21	18	17	16	14	11	6
Хөрөнгө итгэмжлэн удирдах зардал	0	25	25	25	25	13	13	13	13
Үйл ажиллагааны ашиг	120	139	122	38	-4	65	22	-36	-60
Хүүгийн орлого	0	0	0	0	0	0	0	0	0
Татварын өмнөх ашиг	120	139	122	38	-4	65	22	-36	-60
Татварын зардал	-12	0	0	0	-30	0	0	0	0
Цэвэр ашиг	108	139	122	38	-34	65	22	-36	-60
Хуримтлагдсан ашиг	108	247	369	408	374	439	461	425	366

Зардлын тухай

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахтай холбоотой зардал

"Омни актив ТЗК" ХХК нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргаж, үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөрийг дуусах буюу 24 сарын хугацаанд дараах зардал төлбөр гаргахаар байна. Доорх зардал нь ТЗК нь үйл ажиллагаа явуулж байх хугацаанд гарах зардлууд юм.

Хүснэгт 10 "Омни актив ТЗК" ХХК үйл ажиллагааны зардал (төсөөлөл)

№	Зардал	Дүн	Давтамж
1.	Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн ажлын хөлс	Удирдаж буй хөрөнгийн 0.5 хувь	Улирал бүр
2.	Үйлчилгээ үзүүлэгчийн ажлын хөлс	Багцад орох мөнгөн урсгалын 2 хувь	Сар бүр
3.	Хөндлөнгийн аудитын ажлын хөлс	16,000,000	Жил бүр
4.	ТУЗ-ийн гишүүдийн цалин	16,800,000	Жил бүр
5.	Зээлийн програм	12,500,000	Нэг удаа
6.	Эрсдэлийн сан	250,000,000	Шаардлагатай тохиолдолд

Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн ажлын хөлс

"Омни актив ТЗК" ХХК-ийн Хөрөнгө итгэмжлэн удирдагчаар "Юнайтед Айр Файнэнс" ХХК ажиллана. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь үнэт цаас гаргагчтай Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ байгуулсны үндсэн дээр ТЗК-ийн мөнгөн хөрөнгө, багцын хөрөнгийг удирдах эрхийг олгосон. Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагааны хөлсийг улирал бүр нэг удаа төлнө.

Үйлчилгээ үзүүлэгчийн ажлын хөлс

Үйлчилгээ үзүүлэгч нь ТЗК-ийн багцын зээлийн эргэн төлбөрийг өөрийн хөрөнгөөс ангид зээлийн төлбөр цуглуулах дансанд цуглуулж, ТЗК-ийн төлбөр гүйцэтгэх данс



руу шилжүүлнэ. Үйлчилгээ үзүүлэгчийн хөлсийг тухайн сарын багцад орох мэнгэн урсгалын 2 хувиар тооцож төлнэ.



Хөндлөнгийн аудитын ажлын хөлс:

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журмын 8.1 дэх хэсэгт заасны дагуу жилд нэгээс багагүй удаа аудит хийлгэхээр “Гроутфинанс аудит” ХХК-тай “Аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээ” байгуулсан. Гэрээгээр нэг удаа хийгдэх аудитын төлбөрийг 16 сая төгрөг байхаар харилцан тохиролцсон болно. Хугацааны дундуур ТУЗ-ийн шийдвэрээр нэмэлт аудит хийгдэх тухай шийдвэрлэсэн бол ТУЗ-ийн зөвшөөрлөөр нэмж зардал гаргана.

Эрсдэлийн сан

Төлбөрийн тасалдал үүсэхээс сэргийлэн Эрсдэлийн санд 250 сая төгрөгийг байршуулах ба шаардлагатай тохиолдолд ашиглагдах юм.

Төлөвлөгдж буй дээр зардуул болон багцалсан зээлийн мэнгэн урсгал дээр үндэслэн үнэт цаас гаргагчийн мэнгэн урсгалыг доорх байдлаар төсөөлөв.

Мөнгөн урсгалын төсөөлөл

Хүснэгт 11 "Омни актив ТЭК" ХХК Мөнгөн урсгал(төсөөлөл)

ХБҮЦ Мөнгөн урсгал (сая. төгрөг)	Q1	Q2	Q3	Q4	Q5	Q6	Q7	Q8	
Хүүгийн орлого мөнгөн урсгал	123	370	354	267	224	188	144	82	58
Зээлийн үндсэн төлбөр	45	658	701	654	648	608	564	443	265
ХБҮЦ-ийн хүүгийн төлбөр	0	181	181	181	181	91	91	91	91
ХБҮЦ-ийн үндсэн төлбөр	0	0	0	0	2,500	0	0	0	2,500
Удирдлагын зардал төлсөн	0	4	0	0	0	0	0	0	0
Үйлчилгээний төлбөр төлсөн	3	21	21	18	17	16	14	11	6
Хөрөнгө итгэмжлэн удирдах ү.а төлсөн	0	25	25	25	25	13	13	13	13
Татварын зардал төлсөн	12	0	0	0	30	0	0	0	0
Үйл ажиллагааны мөнгөн урсгал	153	797	823	692	1,886	673	587	407	2,295
Хадгаламжийн хүүгийн орлого									
Өөрийн хөрөнгө оруулалт	80	0	0	0	0	0	0	0	0
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн урсгал	80	0							
Богино хугацаат өр төлбөр авсан /Эрсдэлийн сан/	0	0	0	0	0	0	0	0	0
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн урсгал	0	0	0	0	0	0	0	0	0
Мөнгөн урсгалын эхний үлдэгдэл	233	797	823	692	1,886	673	587	407	2,295
Мөнгөн урсгалын эцсийн үлдэгдэл	233	1,030	1,853	2,545	659	1,332	1,918	2,326	31
Зээл төлөх чадварын харьцаа	0	6	10	14	4	15	21	26	0

Angl

A circular red stamp featuring a portrait of a woman and the text "УДАЛІСА КАРПОВА" around the top edge and "Анна Карпова" in the center. A handwritten signature "Анна Карпова" is written across the stamp.

ТЗК байгуулах данс- орлого зарлагын урсгалын тодорхойлолт

ТЗК байгуулах данс, уг дансны орлого зарлагын урсгалын тодорхойлолт, тэдгээрийг захиран зарцуулах эрхтэй этгээдийн талаарх мэдээлэл дараах байдалтай байна.

1. Төлбөр гүйцэтгэх данс:

- Төлбөр гүйцэтгэх дансны орлогын тойм- Үйлчилгээ үзүүлэгчийн төлбөр цуглуулах данснаас багцын эргэн төлөлттэй холбоотой орлогыг хүлээн авна. Мөн эрсдэлийн сангийн хадгаламжийн данснаас шаардлагатай тохиолдолд орлого хүлээн авна.
- Зардлын тойм- Үнэт цаасны эргэн төлөлт, компанийн үйл ажиллагаатай холбоотой зардалууд гаргах, шаардлагатай тохиолдолд багц нэмж авах, гэсэн үндсэн зардалын урсгал гаргах эрхтэй байна. ТЗК-ийн гаргаж болох зардлыг “Төлбөр цуглуулах, үнэт цаас эзэмшигчдэд төлбөр төлөх журам”-д тусгах ба хөрөнгө итгэмжлэн удирдагчтай байгуулах гэрээнд гаргаж болох зардуудыг нарийвчлан тодорхойлсон.

2. Хадгаламжийн данс:

Эрсдэлийн сангийн хөрөнгийг ашиглагдахгүй хугацаанд хадгаламжийн дансанд байршуулна. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь шаардлагатай тохиолдолд хадгаламжийг цуцлан, мөнгөний үлдэгдлийг төлбөр гүйцэтгэх данс уруу татан шаардлагатай зарцуулалтуудыг хийх эрхтэй байна. Тус хадгаламжийн данснаас зөвхөн ТЗК-ийн байгуулсан төлбөр гүйцэтгэх данс уруу зарлага гаргах боломжтой байна.

ТЗК-ийн байгуулсан данснуудыг захиран зарцуулах эрхтэй этгээд нь “Хөрөнгө итгэмжлэн удирдагч” байна.

Дахин үнэлэх, өөрчлөх, эргүүлэн худалдаж авах

ТЗК-ийн хөрөнгийг дараах тохиолдолд дахин үнэлнэ. Үүнд:

- “Омни актив ТЗК” ХХК-ийн гаргаж буй Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны баталгаа болох хөрөнгө барьцаалсан зээлийн багцад өөрчлөлт оруулах, хөрөнгийг солих, нэмэх, хасах шаардлагатай үед
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.3-т заасан нөхцөл байдал бий болсон бөгөөд СЗХороо эрх хүлээн авагч томилсон тохиолдолд

ТЗК-г өөрчлөх тухай нөхцлүүд;

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12-р зүйлийн 12.7-д зааснаар “Тусгай зориулалтын компанийн хувьцаа эзэмшигч нь Хорооны зөвшөөрөлгүйгээр хувьцаагаа худалдах, арилжих, барьцаалах болон бусад хэлбэрээр шилжүүлэхийг хориглоно.” гэж заасан тул нэгдэх, нийлэх, хуваах, тусгаарлах хэлбэрээр өөрчлөн байгуулах тохиолдолд Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрөл авсаны үндсэн дээр гүйцэтгэнэ.

Дээрх хуулийн 22-р зүйлд зааснаар 22.1.Тусгай зориулалтын компанийг дараахь үндэслэлээр татан буулгана:

- 22.1.1. баталгаат үнэт цаасаар хүлээсэн үүргээ гүйцэтгэсэн;
- 22.1.2. баталгаат үнэт цаасны хөрөнгийн багцыг анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үүсгэн байгуулагч, худалдагч буцаан худалдаж авсан;
- 22.1.3. баталгаат үнэт цаасны төлбөр төлөх болон үнэт цаасны танилцуулгад заасан үүргээ биелүүлээгүйн улмаас нийт үнэт цаасыг эзэмшиж байгаа хөрөнгө оруулагчдын гуравны хоёроос дээш хувь нь татан буулгахыг шаардсан.





Хөндлөнгийн аудитын тухай

ТЗК нь үйл ажиллагаа явуулж байх хугацаанд Жилд нэгээс доошгүй удаа аудит хийлгэн тайлагнах шаардлагатай.

Хөндлөнгийн аудитор нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэгт болон холбогдох бусад хууль, журамд заасан дараах шаардлагыг хангасан этгээд байна. Үүнд:

1. Үнэт цаасны зах зээлийн тухайн хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.3 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан байх;
2. Хорооны 2013 оны 452 дугаар тогтоолоор батлагдсан Үнэт цаасны зах зээлийн оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг бүртгүүлэх тухай журмын 2.1-д заасан шаардлагыг ханган, мөн журмын 4.2-д заасны дагуу Хороонд бүртгэгдсэн байх;
3. Хөндлөнгийн аудиторын хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан нь Компанитай нэгдмэл сонирхолтой этгээд биш байх;
4. Аудитын тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан байх;
5. ХБҮЦГБТЗОЖурмын 8.2-д заасан шаардлагуудыг хангасан байх;
6. Холбогдох хууль тогтоомж, журамд заасан болон Хорооноос шаардлагатай гэж үзсэн бусад шалгуурыг хангасан байх.

Хөндлөнгийн аудиторын тавигдсан шалгуурыг хангаж буй оролцгчийг сонгох эсэхийг ТУЗ шийдвэрлэнэ. Ингэхдээ дараах аргуудаас аль зохистой гэсэн аргыг нь өөрийн үзэмжээр сонгож болно.

- Шаардлага хангасан этгээдтэй гэрээ шууд байгуулах,
- Хэд хэдэн оролцогчдоос харьцуулалтын арга ашиглан шалгаруулах
- Хязгаарлагдмал тендер шалгаруулалт зохион байгуулах
- Нээлттэй тендер шалгаруулалт зарлах.

Хөндлөнгийн аудитортой байгуулах гэрээнд дараах нөхцөлүүдийг заавал тусгасан байна. Үүнд:

1. Жилд нэгээс доошгүй удаа аудит хийнэ.
2. Аудитын шалгалт хийх цар хүрээ нь ХБҮЦГБТЗОЖурмын 8.3 дахь хэсэгт заасан хүрээг хамарсан байх;
3. Үйлчилгээний хэлс;
4. Талуудын эрх, үүрэг;
5. Талуудын хариуцлага;
6. Гэрээ цуцлах үндэслэл, журам;
7. Давагдашгүй хүчин зүйл, түүний үед талуудын авах арга хэмжээ;
8. Гэрээнд хэрэглэх хэл, хууль болон маргаан шийдвэрлэх харьяалал.

Хөндлөнгийн аудитортай байгуулсан гэрээг холбогдох хууль, гэрээнд заасан үндэслэлээр цуцалж, тэднийг сольж болно. Гэрээ цуцлах үндэслэл бий болсон гэж үзэж байгаа тохиолдолд цуцлах санал гаргах эсэх талаар ТУЗ-ийн хурлаар шийдвэрлэнэ. Холбогдох оролцогчтой байгуулсан гэрээг цуцалсан тохиолдолд түүнээс хойш 14 хоногийн дотор дараагийн этгээдийг сонгоно. Хөндлөнгийн аудитор солигдсон тохиолдолд СЗХороонд заавал мэдэгдэнэ. Хуульд өөрөөр заагаагүй, эсхүл ТУЗ өөрөөр шийдвэрлэгүй бол Хөндлөнгийн аудитортой байгуулсан гэрээг цуцалсан тохиолдолд шинээр сонгогдсон этгээдийг ажлаа хүлээн авах хүртэл хугацаанд хуучин Хөндлөнгийн аудитороос үйлчилгээг авна.





ҮНЭТ ЦААСНЫ
ТУХАЙ

А. Чир

2022 -01- 28

ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ

Үнэт цаасны нөхцөл


СЗХ
2022, № 12 өд.
БҮРТГЭВ
№ 01

Хүснэгт 12 Үнэт цаасны нөхцөл

Үнэт цаас гаргагч	"Омни Актив ТЗК" ХХК
Анхны үүрэг гүйцэтгэгч	"Омни Капитал ББСБ" ХХК
Үнэт цаасны төрөл	Зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас
Үнэт цаасны тоо ширхэг	50,000 ширхэг
Үнэт цаасны нэгжийн нэрлэсэн үнэ	100,000 ширхэг
Үнэт цаасны нийт дүн	5,000,000,000 төгрөг
Үнэт цаасны хугацаа	24 сар
Үнэт цаасны хүү	14.5 хувь (жилийн)
Хүү төлөгдөх хугацаа	Улирал тутам
Үндсэн төлбөр төлөгдөх хугацаа	12 сард 1 удаа
Үнэт цаасны төлбөр төлөгдөх эх үүсвэр	Хөрөнгийн багцын зээлийн үндсэн болон хүүгийн орлого
Үнэт цаасны хүүд ногдох татвар	Хувь хүн болон ААН-д хүүгийн орлогод ногдох дүнгээс таван хувь
Үнэт цаасны хадгалалт	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн данс
Арилжаалах зах зээл	Монголын хөрөнгийн бирж ТӨХК
Андеррайтер	"Апекс капитал ҮЦК" ХХК

Төстэй бүтээгдэхүүний хүүгийн харьцуулалт

График 20 Төстэй бүтээгдэхүүний хүүгийн харьцуулалт



Эх сурвалж: МХБ, Банкнуудын сайт




Д.Сүрье

Хүүг тогтоосон үндэслэл

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас нь тогтсон хугацаатай, тогтмол хүүтэй тул ЗГҮЦ, банкны хадгаламж, нээлттэй бонд, хаалттай бонд, ББСБ-ийн итгэлцэл зэрэг бүтээгдэхүүнтэй шинж чанарын хувьд төстэй гэж үзэхээр байна. ХБҮЦ-ны хүүг тогтоохын тулд эрсдэлийн түвшингээс харгалzan ЗГҮЦ, хадгаламжийн хүүгээс өндөр, хаалттай бондын хүүгээс бага, нээлттэй бондын хүүтэй ойролцоо байхаар тогтоов. 2020 оноос эхлэн бодлогын хүү буурч түүхэн доод хэмжээ болох 6 хувьд хүрснээр бүх төрлийн хүү буурч, инфляцийн түвшин өсөв. Топ 5 банкны 12 сарын хугацаатай хадгаламжийн түвшинг дундажлах үзэхэд 8 хувь байгааг инфляцийн түвшин 2021 оны 9 сарын байдлаар 9.2 хувьтай жишин үзвэл хадгаламжийн бодит өгөөж хасах утга уруу орсныг илтгэж байна. Иймд зах зээлд тогтмол өгөөжтэй, тогтсон хугацаатай төстэй бүтээгдэхүүний хэрэгцээ, эрэлт нэмэгдсэн гэж үзэж байна. Хаалттай бондын хувьд мэдээллийн хүртээмж харьцангуй хаалттай хүрээнд, цөөн тооны харилцагчдад хүрдэг, зөвхөн мэргэжлийн хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулах боломжтой бол ББСБ-ийн итгэлцэлийн хувьд тухайн ББСБ-ийн эрсдэлийг үнэлэх, гэрээний хүчин төгөлдөр байдлыг шалгах шаардлага үүсдэг нь мэргэжлийн бус хөрөнгө оруулагчдын хувьд бэрхшээлтэй байх зэрэг асуудлаас үүдэн олон нийтэд хүртээмж бага байна.

График 21 Зах зээлийн суурь хүүгийн төвшин





Эх сурвалж: YCX

Харин нээлттэй бонд болон ХБҮЦ-ны хувьд хугацааны дундуур борлогдох боломжтой, мэргэжлийн хөрөнгө оруулагчийн хязгаарлалтгүй, мэдээллийн хүртээмж өндөр зэрэг давуу талтайгаас гадна хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах зохицуулалтууд өндөр зэрэг давуу талтай байна. 2021 оны 10 сарын байдлаар МХБ-д нээлттэй арилжаалагдаж буй гурван төгрөгийн бонд, нэг ХБҮЦ бүртгэлтэй байна. МХБ-д нээлттэй арилжаалагдаж буй тогтмол өгөөжтэй бүтээгдэх хүүнүүд болон топ-5 банкны хадгаламжийн хувьг доор оруулав.


График 22 Арилжааны банкны хадгаламжийн хуугийн төвшин

График 23 Нээлттэй бүтээгдэхүүний хүүгийн төвшин



Эх сурвалж: МХБ, Банкнуудын албан ёсны сайт





Хөрөнгө оруулалтын өгөөж

Үнэт цаасны үндсэн төлбөрийг тэнцүү төлөлттэй 2 хувааж, 12 сар тутамд төлөх ба үнэт цаасны хүүг 3 сар тутамд үндсэн төлбөрийн үлдэгдэл дүнгээс тооцож төлнэ.
ХБҮЦ-ийн хөрөнгө оруулагчдад санал болгох хүү жилийн 14.5% байна. Хугацааны турш 12 сар тутамд үндсэн төлбөрийн эргэн төлөлт хийгдэх учир нийт өгөөж хувь 21.8% болно.

Хүснэгт 13 Хөрөнгө оруулалтын өгөөж

Анхны хөрөнгө оруулалт	5,000.0 сая төгрөг
Хүүгийн орлого	1,087.5 сая төгрөг
Хүүгийн татварын зардал 5%	54.4 сая төгрөг
Нийт өгөөжийн хувь	21.8%
Татварын дараах өгөөжийн хувь	20.7%

Хүүгийн төлбөр дахин байршуулснаарх тооцоолол:

Хүүгийн төлбөр нь улирал тутам буюу хугацааны дундуур төлөлттэй байх нь хөрөнгө оруулагч хүүг дахин байршуулах, хүүнээс хүү тооцох боломжийг бүрдүүлэх давуу талтай.

Хүснэгт 14 Хөрөнгө оруулалтын өгөөж (дахин байршуулсанаар)

Огноо	Нэрлэсэн үнэ	Үндсэн төлбөр	Хүү	Хүүгийн төлбөр	Тооцсон хүү
Улирал 0	5,000.0				
Улирал 1	5,000.0	-	181.3	181.3	
Улирал 2	5,000.0	-	181.3	362.5	6.6
Улирал 3	5,000.0	-	181.3	543.8	13.1
Улирал 4	2,500.0	2,500.0	181.3	725.0	19.7
Улирал 5	2,500.0	-	90.6	815.6	26.3
Улирал 6	2,500.0	-	90.6	906.3	29.6
Улирал 7	2,500.0	-	90.6	996.9	32.9
Улирал 8	-	2,500.0	90.6	1,087.5	36.1
Нийт	5,000.0	1,087.5			164.3

Дээрх хүснэгтэд үнэт цаасны улирал бүрийн хүүгийн төлбөрийг дахин байршуулсанаар 164.3 сая төгрөгийн буюу 3.29% (5,000.0 сая төгрөгөөс тооцсон) нэмэлт өгөөж авах боломжтойг харуулж байна. Ингэснээр нийт хүүгийн дотоод өгөөж 25% хүртэл нэмэгдэх боломжтой. Хөрөнгө оруулагч 12 сарын дараа төлөгдөх үндсэн төлбөрийн 50 хувийг мөн дахин байршуулах боломжтой ба үндсэн төлбөрийг ХБҮЦ-д дахин байршуулах тохиолдолд өгөөжийн түвшин 29 хувь, банкинд байршуулах тохиолдолд 26 хувь хүртэл өсөх боломжтой.


Хөрөнгө оруулагчдад хүүгийн төлбөрийн татварыг (хүүгийн орлогоос 5 хувь) суутгасан дүнгээр шилжүүлнэ.

Үнэт цаасны төлбөрийн бодолт

Төлбөр төлөх журмыг ТҮЗ-өөс баталсан “Үнэт цаасны төлбөр цуглуулах, үнэт цаасны төлбөр төлөх журмаар зохицуулж байна”. Тодруулбал, Анхдагч зах зээлийн арилжаа явагдаж, хоёрдогч зах зээлийн арилжаа эхлэх өдрөөс эхлэн хүүг тооцож эхэлнэ. Хүүгийн төлбөрийг 3 сар тутамд, үндсэн төлбөрийг 12 сард нэг удаа тэнцүү хуваан төлнэ.

Хүү болон үндсэн төлбөрийн төлөлтийг дараах байдлаар тооцож олгоно.





**Унэт цаасны төлбөрийн бодолтын дэлгэрэнгүй
Хүснэгт 15 Хүү тооцох аргачлал**

Үндсэн төлбөр төлөгдөх хугацаа	Өмнөх төлбөрийн огноо (Худалдан авсан огноо) + 12 сар
Хүүгийн төлбөр төлөгдөх хугацаа	Өмнөх төлбөрийн огноо (Худалдан авсан огноо) + 3 сар
Хүүгийн төлбөр (татварын өмнө)	$\frac{\text{Тоо ширхэг} * \text{Нэрлэсэн үнэ} * (14.5\%)}{12 \text{ сар}} * 3 \text{ сар}$
Хүүгийн төлбөр (татварын дараа)	$\frac{\text{Тоо ширхэг} * \text{Нэрлэсэн үнэ} * (13.78\%)}{12 \text{ сар}} * 3 \text{ сар}$
Үндсэн төлбөр	2 тэнцүү төлөлттэй
Нийт төлөгдөх дүн	$\frac{\text{Үндсэн төлбөр} + \frac{\text{Хүү тооцох дүн} * (13.78\%)}{12 \text{ сар}} * 3 \text{ сар} * 8 \text{ удаа}}{12 \text{ сар}}$

Төлбөр төлөх дараалал

Мөн "Унэт цаасны төлбөр цуглуулах, үнэт цаасны төлбөр төлөх журам"-д үнэт цаас гаргагчийн төлбөр төлөх дарааллыг зохицуулсан ба дараах байдалтай байна.

1. ТЗК-ийн ААН-ын орлогын албан татвар
2. Үнэт цаасны хүүгийн орлогын татвар
3. Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн төлбөр;
4. Үйлчилгээ үзүүлэгчийн төлбөр;
5. Хөндлөнгийн аудитын төлбөр;
6. Үнэт цаасны хүүгийн төлбөр;
7. Үнэт цаасны үндсэн төлбөр
8. Хөрөнгийн багцад хөрөнгө нэмж худалдан авах, солих, нэмэгдүүлэхтэй холбоотой зардал
9. ТЗК-ийн үйл ажиллагаатай холбоотой ТУЗ гишүүний цалин урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэл, татвар, үйл ажиллагааны зардал (вэб сайттай холбоотой зардал, санхүүгийн програмтай холбоотой зардал, мэдээлэл хүргэхтэй холбоотой зардал);
10. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, хадгалалттай холбоотой зардал;
11. Төрийн болон бусад эрх бүхий байгууллагад төлөгдөх зардал;
12. Банктай холбоотой зардал;
13. Энэ журмын 3.2.3-д зааснаас бусад татварыг хуулиар тогтоосон хугацаанд;
14. Бусад

Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь үнэт цаасны төлбөр хүлээн авах Үнэт цаас эзэмшигчдийн жагсаалтыг төлбөр төлөх өдрөөс ажлын 5 хоногийн өмнө ҮЦТХТ-өөс авна. Үнэт цаасны төлбөрийг ҮЦТХТ-өөс ирсэн Үнэт цаас эзэмшигчдийн нэrsийн дагуу шилжүүлэх бөгөөд заасан хугацаанаас өмнө үнэт цаасыг эзэмшиж байсан хөрөнгө оруулагчид үнэт цаасны төлбөр хүлээн авах эрхтэй байна.

Үнэт цаасны төлбөрийн график

Хүснэгт 16 Үнэт цаасны төлбөрийн график

Огноо	Улирал1	Улирал2	Улирал3	Улирал4	Улирал5	Улирал6	Улирал7	Улирал8	Нийт
Үнэт цаасны үлдэгдэл	5,000.0	5,000.0	5,000.0	5,000.0	2,500.0	2,500.0	2,500.0	2,500.0	0
Үндсэн төлбөр төлөлт	0	0	0	2,500.0	0	0	0	2,500.0	5,000.0
Хүүгийн төлбөр төлөлт	181.3	181.3	181.3	181.3	90.6	90.6	90.6	90.6	1,087.5

Dr. Chyld



2022-01-28


Үнэт цаасны төлбөрийн эх үүсвэр



Үнэт цаасны эргэн төлөлтийн эх үүсвэр нь ТЗК-д шилжүүлсэн 5 тэрбум төгрөгийн дүн бүхий зээлийн багцаас орох үндсэн төлөлтийн болон хүүгийн орлого байх юм. 24 сарын хугацааны турш багцад нийт 6.2 тэрбум төгрөгийн үндсэн болон хүүгийн төлөлтийн орлого орж ирэх хүлээлттэй байна. Тус тооцоолол нь одоогоор багцалсан зээлүүдийн гэрээгээр хүлээсэн үүргийг харуулах боловч хугацааны дундуур зээлийн төлөлтийн хугацаанд өөрчлөлт орох, зээлдэгч урьдчилан төлөх, хугацаа хэтрүүлэх, түүнтэй холбоотойгоор анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс шалгуур хангахгүй болсон зээлүүдийг солин шалгуур хангасан зээлүүдээр солих, худалдан авах зэрэг харилцаатай холбоотойгоор мөнгөн урсгалын төсөөлөлт өөрчлөлт орох боломжтой юм. Тус эрсдэлийг хаах зорилгоор 250 сая төгрөгийн эрсдэлийн сан байгуулсан ба зээлдэгчийн төлөлтийн графикт өөрчлөлт орох тохиолдолд түүнийг хянах этгээд болох хөрөнгө итгэмжлэн удирдагчтай “Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ”-г байгуулах ба “Багцын хөрөнгөд өөрчлөлт оруулах” журмыг баталсан болно.

Үнэт цаасжуулах хэлцлийн зураглал

Зураг 4 Үнэт цаасжуулах хэлцлийн зураглал






Хэлцлийн тойм

Хүснэгт 17 Хэлцлийн тойм хүснэгт

Үүсгэн байгуулагч/
Анхны үүрэг гүйцэтгүүлэгч

ТЗК-г үүсгэн байгуулагч "Омни капитал ББСБ" ХХК нь 5 тэрбумын үнийн дүн бүхий шалгуур хангасан зээлүүдийг багцлан үнэт цаасжуулах, ТЗК-д шилжүүлэх тухай ТУЗ-ын шийдвэрийг гаргасан. Багцалсан зээлийн анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн үүргийг мөн гүйцэтгэнэ.

Зээлийн шинжилгээ гаргагч

Грант Торнтон Аудит ХХК нь зээлийн багц болон багцад багтах зээлүүд холбогдох санхүүгийн шалгуурыг хангасан эсэх талаар дүгнэлт гаргасан.

Хуулийн фирм

"Өмгөөллийн Ханлекс партнерс" ХХН нь зээлийн багц болон багцад багтах зээлүүд холбогдох хуулийн шалгуур хангасан эсэх талаар дүгнэлт гаргасан. Мөн хэлцлийн зураглал, үнэт цаасны танилцуулгад тусгагдсан мэдээлэл нь үнэн зөв эсэх талаар дүгнэлт гаргасан.

ТЗК

Хуулийн болон санхүүгийн шалгууруудыг хангасан багцалсан зээлийг хүлээж аван, ХБҮЦ, идэвхитэй байх хугацаанд эзэмших, бүртгэх үүрэгтэйгээр түр байгуулагдах нэгж

Андеррайтер

Хэлцэл зохион байгуулах, зээлийн багцын санхүүгийн болон хуулийн шалгуурыг хамтран тодорхойлох, хөрөнгө босгох үүрэгтэй

Үйлчилгээ үзүүлэгч

Үүрэг гүйцэтгэгчтэй харилцан, тусгаарласан багцын хүү болон үндсэн төлбөрийг цуглуулахаар ТЗК-тай гэрээ байгуулсан

Хөрөнгө итгэмжлэгч

ТЗК-ийн хөрөнгийг хөрөнгө оруулагчдын эрх ашигт нийцүүлэн эзэмшиж, удирдах үүрэгтэй. Санхүүгийн зохицуулах хороонд улирал бүр тогтмол болон шаардлагатай тохиолдолд тухай бүр тайлан илгээнэ

Хөрөнгө оруулагч

ХБҮЦ-ыг худалдан авах, үндсэн төлбөрийг хүүгийн хамт хүлээн авах

ҮЦТХТ

Үнэт цаас хадгалагдана

МХБ

Арилжаа зохион байгуулах нэгж





Багцын тойм

Үнэт цаасжуулах хөрөнгийн багцын тасалбар болгох өдрийн байдлаарх мэдээллийг доорх байдлаар тоймлож харуулав. Шалгуур үзүүлэлт хангасан нийт 802 зээлдэгчийн 5,010,629 мянган төгрөгийн үлдэгдэл бүхий 808 зээлийн гэрээг багцалсан болно.

Багцын үндсэн үзүүлэлтүүд	
Нийт зээлийн үлдэгдэл /мян.төг/	5,010,629
Хэрэглээний зээл	1,328,078
Автомашины лизингийн зээл	1,621,131
Бизнесийн зээл	2,061,420
Нийт анх олгосон дүн /мян.төг/	6,236,663
Барьцааны дүн	11,049,058
Зээлийн гэрээний тоо	808
Зээлдэгчийн тоо	802
Зээлийн дундаж үлдэгдэл /мян.төг/	6,201
Хамгийн том 1 зээлийн нийт багцад эзлэх %	5.97%
Хамгийн том 10 зээлийн нийт багцад эзлэх %	25.86%
Хамгийн том 50 зээлийн нийт багцад эзлэх %	50.25%
Жигнэсэн дундаж үзүүлэлт	
Жигнэсэн дундаж хүү	2.9%
Жигнэсэн дундаж зээлийн анхны хугацаа /сар/	27.2
Жигнэсэн дундаж зээлийн үндсэн хугацаа /сар/	27.6
Жигнэсэн дундаж LTV	57.3%
Багцын зээлийн чанар	100% Хэвийн

Омни Актив ТЗК ХХК-ийн зээлийн багцын үндсэн үзүүлэлт нь дараах байдлаар хуульд заасан болон "Омни Актив ТЗК"-ийн ТУЗ-өөр баталсан санхүүгийн шаардлагыг хангаж байна. 4

- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны нэг удаагийн гаргалтыг баталгаажуулж байгаа хөрөнгийн нийлбэр нь хөрөнгийн багцыг бүрдүүлнэ: Үнэт цаас гаргагч 5.0 тэрбум төгрөгийн үнэт цаас гаргахаар төлөвлөж байгаа ба баталгаажуулж байгаа хөрөнгийн багцын үнэлгээ 5.0 тэрбум байна.
- Багцын хөрөнгөнд байх нийт барьцаа нь нийт хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны дүнгийн 110 хувиас их байх: 5 тэрбум төгрөгийн дүн бүхий үнэт цаасыг баталгаажуулж буй барьцааны дүн 11 тэрбум буюу 220 хувь байна.
- Зээлийн багцын жигнэсэн дундаж хүү нь үнэт цаасны дундаж хүүнээс тэнцүү буюу их байх: Үнэт цаасны нэрлэсэн хүү 1.2 хувь, хөрөнгийн багцын жигнэсэн дундаж хүү нь 2.9 хувь байна.
- Зээлийн багцын жигнэсэн дундаж хугацаа нь үнэт цаасны хугацаанаас багагүй байх: Үнэт цаасны хугацаа 24 сар ба хөрөнгийн багцын жигнэсэн дундаж хугацаа нь 27.6 сар байна.
- Нийт багцын жигнэсэн дундаж зээл болон барьцаа хөрөнгийн үнэлгээний харьцаа (LTV) 65 хувиас ихгүй байх: Хөрөнгийн багцын жигнэсэн дундаж зээл болон барьцаа хөрөнгийн үнэлгээний харьцаа 57.3 хувь байна.

Мөн зээлийн дундаж дүн 6.2 сая төгрөг, хамгийн том 1 зээлийн багцад эзлэх жин 6 хувь зэрэг нь зээл харьцангуй тархсан, төвлөрлийн эрсдэл бага байгааг харуулж байна.





Багцын анх олгосон зээлийн хугацаа

Зээлийн анхны хугацаа /сар/	Зээлийн тоо	Анх олгосон дүн /мян.төг/	
	Тоо	Хувь	Дүн
6-15	282	35%	622,183
15-30	406	50%	3,653,891
30 - дээш	120	15%	1,960,590
Нийт	808	100%	6,236,663
Хамгийн их /сар/	38		
Хамгийн бага /сар/	6		
Жигнэсэн дундаж /сар/	27.7		

Багцын зээлийн ихэнх хэсгийг буюу 69 хувийг 6-30 сарын хугацаатай зээлүүд эзэлж байна. Банк бус санхүүгийн байгууллагын салбарын хувьд 2021 оны хагас жилийн байдлаар нийт олгосон зээлийн 82.1 хувийг 1 сараас 2.5 жилийн хугацаатай зээлүүд эзэлжээ. Энэ нь багцын зээлийн хугацаа салбарын дундаж хугацаатай ойролцоо байгааг харуулж байна.

Багцын анх олгосон хугацааны мэдээлэл

Анх олгосон огноо	Зээлийн тоо		Анх олгосон дүн /мян.төг/	
	Тоо	Хувь	Дүн	Хувь
2018/12/19 – 2019/12/31	55	7%	669,060	6%
2020/01/01 – 2020/12/31	82	10%	974,350	12%
2021/01/05 – 2021/09/28	671	83%	4,593,253	82%
Нийт	808	100%	6,236,663	100%

Үнэт цаас гаргагчийн зээлийн хугацааны онцлогоос шалтгаалан багцын зээлийн олгосон хугацаа 2020 оны 1 сараас хойш олгогдсон зээл 94 хувийг эзэлж байна.

Багцын анх олгосон дүн

Анх олгосон дүн /мян.төг/	Зээлийн тоо		Анх олгосон дүн /мян.төг/	
	Тоо	Хувь	Дүн	Хувь
0-6,000	532	66%	947,563	15%
6,000-12,000	152	19%	1,512,760	24%
12,000-18,000	71	9%	987,040	16%
18,000-24,000	12	1%	247,300	4%
24,000 - дээш	41	5%	2,542,000	41%
Нийт	808	100%	6,236,663	100%
Хамгийн их	300,000			
Хамгийн бага	149.9			
Дундаж	7,718.6			

Зээлийн багцын 55 хувийг 0-18 сая төгрөгийн дүн бүхий, 45 хувийг 18 сая төгрөгөөс дээш зээл эзэлж байна.



2021-01-28

БҮРТГЭЛ-03



Багцын харьцаа хангалт (LTV)

Зээлийн тоо

Анх олгосон дүн /мян.төг/	Тоогоор	Тоогоор багцад эзлэх хувь	Үнийн дунгээр	Үнийн дунгээр багцад эзлэх хувь
0-40%	137	17%	524,812	8%
40%-55%	200	25%	1,407,335	23%
55%-65%	161	20%	1,423,445	23%
65%-80%	298	37%	2,806,012	45%
80%-94%	12	1%	75,059	1%
Нийт	808	100%	6,236,663	100%

Багцад тавигдах шаардлагын дагуу Хөрөнгийн багцын жигнэсэн дундаж барьцаа хангалт 65 хувь буюу түүнээс бага байна. Нийт багцын 62 хувийг барьцаа хөрөнгийн үнэлгээний харьцаа 65 хувиас бага зээлүүд эзэлж байгаа ба багцын жигнэсэн дундаж харьцаа 57.3 хувь байна. Нийт барьцааны дүн 11 тэрбум байгаа нь нийт багцын барьцаа хөрөнгийн хэмжээ хангалттай өндөр түвшинд байгааг илэрхийлж байна.

Зээлийн хүүгийн тархалт

Хүүгийн тархалт	Зээлийн тоо		Анх олгосон дүн /мян.төг/	
	Тоо	Хувь	Дүн	Хувь
2%-3%	204	25%	4,220,410	68%
3%-4%	604	75%	2,016,253	32%
Нийт	808	100%	6,236,663	100%
Хамгийн их	4%			
Хамгийн бага	2%			
Жигнэсэн дундаж	2.9%			

Хөрөнгийн багцын жигнэсэн дундаж хүү нь Багцад тавигдах шаардлагын дагуу 2.9 хувь байна. 2021 оны хагас жилийн байдлаар салбарын дундаж зээлийн жигнэсэн дундаж хүү мөн 2.9 хувь байна. Энэ нь анхны үүрэг гүйцэтгүүлэгчдийн олгодог дундаж зээлийн хүйтэй дүйцэж байгаа юм.

Зээлийн төрлөөр

Зээлийн төрөл	Зээлийн тоо		Анх олгосон дүн /мян.төг/	
	Тоо	%	Дүн	%
Хэрэглээ	564	70%	1,659,933	27%
Бизнес	53	7%	2,233,400	36%
Автомашин	191	24%	2,343,330	38%
Нийт	808	100%	6,236,663	100%

Зээлийн төрлөөр дээрх хэсэгт ангилав.



2022-01-28

СЭХ
он 2022 сар 01, 12
БҮРТГЭВ
№ 01

Барьцааны төрөл

Барьцааны төрөл	Зээлийн тоо		Барьцааны үнэлгээ /мян.төг/	
	Тоо	Хувь	Дүн	Хувь
Автомашин	238	29%	4,141,000	40%
Үл хөдлөх хөрөнгө	63	8%	5,092,268	46%
Хөдлөх хөрөнгө	507	63%	1,815,790	14%
Нийт	808	100%	11,049,058	100%

Багцад багтсан зээлүүдийн барьцааг автомашин барьцаалсан, үл хөдлөх хөрөнгө барьцаалсан, хөдлөх хөрөнгө барьцаалан гэх үндсэн гурван төрөлд хуваах боломжтой. Барьцаа хөрөнгийн төрлөөс хамааран багцад орох зээлийн хуулийн шалгуурт тусгаж, шалгуурыг хангасан зээлүүдийг багцалсан ба дэлгэрэнгүй дүгнэлтийг “Хуулийн дүгнэлт”-ээс унших боломжтой.

Багцын дүгнэлт

Зээлийн төрөлжүүлэлт: Багцад хэрэглээний зээл 26.5 хувь, автомашины лизингийн зээл 32.3 хувь, бизнесийн зээл 41.2 хувийг эзэлж байна. Зээлийн төрөл тус бүрт учирч болох эрсдэл, хамгаалалт болон барьцаа хөрөнгийн төрөл өөр өөр учир нийгэм эдийн засгийн аливаа өөрчлөлтөд нөлөөлөх нөлөөлөл ялгаатай байна. Багцад олон төрлийн зээл багтах нь нэг төрлийн зээлийн эрсдэлээс хамгаалж, эрсдэлийг төрөлжүүлж буй хэлбэр юм.

Барьцаа хөрөнгө: Зээлийн багцын жигнэсэн дундаж LTV харьцаа 57.3 хувь, багцын дүн болон үнэт цаасны дүнтэй харьцуулахад барьцаа хөрөнгийн хэмжээ 2 дахин өндөр байгаа нь барьцаа хөрөнгийн дүн хангалттай өндөр түвшинд байгааг илэрхийлнэ. Барьцаа хөрөнгийн төрөл үл хөдлөх хөрөнгө, хөдлөх хөрөнгө, автомашин гэх гурван төрөл буюу төрөлжсөн байгаа нь багцад учирч болох эрсдэлийг мөн бууруулж байна.

Зээлийн чанар: Багцад багтах зээлийн чанарын үзүүлэлт “100 хувь хэвийн” байна. Үнэт цаасны хугацаа дуусах хүртэлх хугацаанд чанарын үзүүлэлт “Хэвийн” зээлээр бүрдүүлэх холбогдох зохицуулалтуудыг “Багцын хөрөнгөд өөрчлөлт оруулах, түүнийг хэрэгжүүлэх” тухай журамд тусгаж өгсөн нь багцын хөрөнгөд учирч болох үндсэн эрсдэлийг хаасан болно.

Жигнэсэн дундаж үзүүлэлтүүд: Багцын хөрөнгийн анх олгосон дундаж хүү, хугацаа зэрэг үзүүлэлтүүд нь салбарын дундажтай ойролцоо буюу богино хугацаатай, бага дүнтэй зээлүүд эзэлж байна. Мөн жигнэсэн дундаж хугацаа, хүү зэрэг үзүүлэлтүүд багцын хуулийн болон санхүүгийн шалгуурыг давуулан биелүүлсэн үзүүлэлттэй буюу үнэт цаасны эргэн төлөлтийг төлж барагдуулах бүрэн чадамж бүхий төсөөлөлтэй байна.



2022 - 01 - 28

МУНДИАЛ-03

Багцад багтсан зээлийн төрөл, онцлог

СЗХ
2022.01.12 өдөр
БҮРТГЭВ
№ 01


Автомашины лизингийн зээл

Зээлийн нөхцөл	Урьдчилгаа төлбөр	
	Зээлийн хэмжээ	50 сая хүртэл төгрөг
	Зээлийн хүү /сараар/	2.9% - 2.7%
	Зээлийн хугацаа	36 сар хүртэл
	Барьцаа хөрөнгө	Худалдан авч буй авто машин
	Барьцаа хөрөнгийн үнэлгээ	Зах зээлийн үнэлгээгээр /олгож буй зээлийн хэмжээгээр
	Барьцаа хөрөнгийн өмчлөл	Омни каптиал ББСБ
	Барьцаа хөрөнгийн байршил	Улаанбаатар

Бизнесийн зээл

Зээлийн нөхцөл	Урьдчилгаа төлбөр	
	Зээлийн хэмжээ	0.5 – 300 сая хүртэл төгрөг
	Зээлийн хүү /сараар/	2.9% - 2.5%
	Зээлийн хугацаа	24 сар хүртэл
	Барьцаа хөрөнгө	<ul style="list-style-type: none"> • Эргэлтийн хөрөнгө • Авто машин • Орон сууц • Авто зогсоол / Офисын талбай • Хашаа байшин
	Барьцаа хөрөнгийн үнэлгээ	Зах зээлийн үнэлгээгээр /олгож буй зээлийн хэмжээгээр
	Барьцаа хөрөнгийн өмчлөл	Автомашин “Омни каптиал ББСБ”-ийн өмчлөлд, бусад үлл хөдлөх хөрөнгө нь Зээлдэгчийн өмчлөлд “Омни каптиал ББСБ”-ийн барьцаанд байдаг. ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙН БАРЬЦААНЫ ГЭРЭЭГЭЭР баталгаажиж Улсын бүртгэлийн байгууллагад Барьцаалбараар бүртгүүлсэн.

Д.Дүйн



Барьцаа хөрөнгийн
байршил

Улаанбаатар

Хэрэглээний зээл

Хэрэглээний зээл	Орон сууц барьцаалсан	Газар барьцаалсан	Автомашин барьцаалсан /Унаж явах нөхцөлтэй/	Хашаа байшин барьцаалсан	Авто зогсоол барьцаалсан
Урьдчилгаа төлбөр					
Зээлийн хэмжээ /Төгрөг/	150 сая хүртэл	50 сая хүртэл	50 сая хүртэл	10 сая хүртэл	10 сая хүртэл
Зээлийн хугацаа	36 сар хүртэл				
Зээлийн хүү	2.9% - 2.5%				
Барьцаа хөрөнгийн үнэлгээ		Зах зээлийн үнэлгээгээр /олгож буй зээлийн хэмжээгээр			
Барьцаа хөрөнгийн өмчлөл		Автомашин "Омни каптиал ББСБ"-ийн өмчлөлд, бусад үл хөдлөх хөрөнгө нь Зээлдэгчийн өмчлөлд "Омни каптиал ББСБ"-ийн барьцаанд байдаг. ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙН БАРЬЦААНИЙ ГЭРЭЭГЭЭР баталгаажиж Улсын бүртгэлийн байгууллагад Барьцаалбараар бүртгүүлсэн.			
Барьцаа хөрөнгийн байршил		Улаанбаатар			

Багцын түүхэн үзүүлэлт

Он	Нийт багц	Чанаргүй зээлийн багц	Зээлийн тоо	Жигнэсэн дундаж хүү	Чанаргүй зээл хувь	Салбарын дундаж чанаргүй зээл %	Зөрүү
2019 Q1	2,127.5	78,5	5	4.0%	3.69%	9.1%	5.4%
2019 Q2	2,487.0	117,2	7	3.8%	4.72%	8.9%	4.2%
2019 Q3	4,049.1	168,1	15	3.7%	4.15%	9.0%	4.8%
2019 Q4	4,903.3	165,34	18	4.0%	3.37%	8.5%	5.1%
2020 Q1	5,525.9	292,6	35	3.8%	5.30%	8.4%	3.1%
2020 Q2	6,177,4	243,1	38	3.7%	3.94%	8.7%	4.7%
2020 Q3	6,097,0	317,4	45	3.6%	5.21%	9.4%	4.1%
2020 Q4	7,502,9	433,41	45	3.5%	5.78%	10.3%	4.5%
2021 Q1	8,458,2	843,7	66	3.5%	9.98%	10.3%	0.3%
2021 Q2	10,084,4	779,5	64	3.2%	7.73%	9.7%	1.9%
2021 Q3	12,648,0	768,7	68	2.7%	6.08%	-	-



А. Сүрье

2022-01-28

СЭХ
2022 сар 12-дэй
БАРГЭВ

Багцалсан зээлийн төрлүүд болох бизнесийн зээл, автомашины лизингийн зээл, хэрэглээний зээл нь үүсгэн байгуулагчийн олгодог зээлүүдийг бүхэлд нь төлөөлэх учир багцад багтсан зээлийн төрлүүдийн чанарын түүхэн үзүүлэлтийг авч үзэхийн тулд үүсгэн байгуулагчийн нийт зээлийн багцын үзүүлэлтийг ашиглав. Компани түүхэн үзүүлэлтээс харахад зээлийн чанаргүйжих хувь салбарын дунджаас тогмол 1-5 нэгж хувь доогуур үзүүлэлттэй байна.



Багцын зээлийн санхүүгийн болон хуулийн шалгуур

СЭХ
2022 дэг, 12 дэдэр
БҮРТГЭВ
№ 01

Багцын хөрөнгийн санхүүгийн шалгуурыг дараах байдлаар тодорхойлсон:

- 1 "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль"- ийн 9 дүгээр заалтын шалгууруудыг хангасан байна.

- 1.1 Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны нэг удаагийн гаргалтыг баталгаажуулж байгаа хөрөнгийн нийлбэр нь хөрөнгийн багцыг бүрдүүлнэ.
- 1.2 Хөрөнгийн багцад байгаа хөрөнгө нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үед үнэт цаас гаргагчийн эзэмшилд байх бөгөөд эрхийн доголдолгүй хөрөнгө байна.
- 1.3 Хөрөнгийн багцад дараахъ хөрөнгийг оруулахыг хориглоно.
- Дуусаагүй барилга ба сул чөлөөтэй газрын барьцаа
- Зээл болон барьцаа хөрөнгийн үнэлгээний харьцаа нь хуульд заасан эрх бүхий этгээдээс тогтоосон хэмжээнээс хэтэрсэн барьцаат зээл
- Хугацаа хэтэрсэн хөрөнгө- Үүнд: Хугацаа хэтэрсэн хөрөнгөнд "чанаргүй" (хэвийн бус, эргэлзээтэй, муу) ангилалтай зээлүүдийг хамруулна.

- 2 Зээл болон хөрөнгийн багц нь дараах шаардлагыг хангасан байх

- 2.1 Тусгаарласан нийт багцаас орох мөнгөн урсгал нь (Багцад багтсан зээлийн үндсэн болон хүүгийн төлөлт) үнэт цаасны дагуу хүлээх үүргийг гүйцэтгэхэд хүрэлцэхүйц байх
- 2.2 Багцын хөрөнгөнд байх нийт барьцаа нь нийт ХБҮЦ-ийн дүнгийн 110 хувиас их байх
- 2.3 Зээлийн багцын жигнэсэн дундаж хүү нь үнэт цаасны дундаж хүүнээс тэнцүү буюу их байх
- 2.4 Зээлийн багцын жигнэсэн дундаж хугацаа нь үнэт цаасны хугацаанаас багагүй байх
- 2.5 Монгол төгрөгөөр тухайн зээл байх
- 2.6 Зээлийн стандарт нь зээлийн төрөл тус бүрт анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн дотооддоо мөрддөг журмын дагуу олгогдсон, журамд заасан шаардлагыг хангасан зээлүүд байх
- 2.7 Нийт багцын жигнэсэн дундаж зээл болон барьцаа хөрөнгийн үнэлгээний харьцаа (LTV) 65 хувиас ихгүй байх
- 2.8 Нийт зээлийн багцын жигнэсэн дундаж хүү 2.5 хувиас багагүй байх
- 2.9 Зээлийн багцын жигнэсэн дундаж хугацаа нь 24 сараас багагүй байна
- 2.10 Зээлийг шалгах болон шилжих өдрийн байдлаар зээлийн багцад багтах зээл нь "Хэвийн" ангилалд байх
- 2.11 Зээл олгосон өдрийн байдлаар зээлдэгч нь банк санхүүгийн байгууллагад чанаргүй зээлийн үлдэгдэлгүй байх. Анх олгоход чанаргүй зээлийн үлдэгдэлтэй байсан бол зээлийн багцыг тусгаарлах өдрөөр тэг үлдэгдэлтэй болсон байх. Зээлдэгч гэдэгт хувь хүний хувьд үндсэн зээлдэгч, аж ахуй нэгжийн хувьд хувьцаа эзэмшигч, ажилтнуудыг үл хамруулан тухайн аж ахуй нэгжийг ойлгоно.



Багцын хөрөнгөтэй холбоотой хуулийн шалгуурт дараах хэсгийг ойлгоно.

1. Шалгуур үзүүлэлт 1.

Фидуцийн зээлийн гэрээ, хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө барьцаалсан зээлийн гэрээ нь хуульд заасан шаардлагад нийцсэн, хүчин төгөлдөр, гэрээнд заасан үүрэг нь заавал биелэгдэх шинжтэй байх.

2. Шалгуур үзүүлэлт 2.

Фидуцийн гэрээ, хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээ нь хуульд заасан шаардлагад нийцсэн, хүчин төгөлдөр, гэрээнд заасан үүрэг нь заавал биелэгдэх шинжтэй байх.

3. Шалгуур үзүүлэлт 3.

Фидуцийн гэрээний дагуу автомашиныг анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд шилжүүлсэн байх, холбогдох бүртгэлийг хийлгэсэн байх, хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгийн барьцаа хөрөнгөөр үүргийн гүйцэтгэлийг тэргүүн ээлжинд хангуулах боломжтой байх.

4. Шалгуур үзүүлэлт 4.

Фидуцийн зүйл, үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээний барьцаа хөрөнгө нь хуульд заасны дагуутөлбөр гаргуулж болохгүй эд хөрөнгө биш байх.

5. Шалгуур үзүүлэлт 5.

Фидуцийн зээлийн гэрээ, хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө барьцаалсан зээлийн гэрээний үүрэг дуусгавар болоогүй, хүчин төгөлдөр, хэрэгжих боломжтой байх.

6. Шалгуур үзүүлэлт 6.

Фидуцийн гэрээ, хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээний шаардах эрх гуравдагч этгээдэд шилжих боломжтой, хууль, гэрээгээр хязгаарлагдаагүй байх.



Хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах тухай



Компани нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний дагуу багцыг шилжүүлэн авсан хөрөнгө нь ТУЗ-ийн баталсан шалгуур үзүүлэлтийг хангаж чадахгүй болсон, эсхүл журамд дурдсан үндэслэл бий болсон тохиолдолд багцын хөрөнгөд өөрчлөлт оруулах эрхтэй. Тодруулбал,

Компанийн ТУЗ-өөс баталсан Багцын хөрөнгөд өөрчлөлт оруулах, түүнийг хэрэгжүүлэх журам болон Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй байгуулсан Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээнд заасны дагуу багцын хөрөнгөд дараах байдлаар өөрчлөлт оруулах боломжтой.

- * Багцын хөрөнгийг солих;
- * Багцын хөрөнгийг нэмэгдүүлэх;
- * Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдах;

ХӨРӨНГИЙН БАГЦАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ҮНДЭСЛЭЛ

Багц дахь хөрөнгөд дор дурдсан үндэслэл бий болсон тохиолдолд шаардлага хангахгүй хөрөнгөд тооцож хөрөнгийг багцаас хасч, хөрөнгийг солино. Үүнд:

- Зээл хугацаанаас өмнө эргэн төлөгдсөн;
- Зээлдэгч нас барсан, сураггүй алга болсон, төлбөрийн чадваргүй болсон, зээлтэй холбоотой асуудлаар шүүхэд маргаан үүссэн, зээлдэгч нь залилан мэхлэх арга замаар зээл авсан байж болзошгүй, цагдаагийн байгууллагад гомдол гаргасан зэрэг зээлийн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон;
- Зээлдэгчийн хүсэлтээр зээлийн гэрээнд өөрчлөлт оруулсан нь Үнэт цаас эзэмшигч нар төлөх үнэт цаасны төлбөрийн нехцөлд нөлөөлөхүйц байна гэж компаниас үзсэн;
- Зээлийн эргэн төлөлтийн хугацаа нь 15 болон түүнээс дээш хоног хэтэрсэн; Хөрөнгийн багцын шалгуур үзүүлэлттэй холбоотойгоор Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн "Хөрөнгө худалдах худалдан авах гэрээ"-нд заасан аль нэг мэдэгдэл, баталгаа зөрчигдсөн.
- Зээлийн барьцаа хөрөнгө шаардлага хангахгүй болсон.

Багц дахь хөрөнгөд дор дурдсан үндэслэл бий болсон тохиолдолд багцын хөрөнгийг нэмэгдүүлнэ. Үүнд:


- Баталгаат үнэт цаасны хөрөнгийн багцаас орох орлого нь үнэт цаасны төлбөрийн үүргийг гүйцэтгэж хүрэхгүй болсон;
- Хөрөнгийн багцын нийт үнийн дүн нь төлөгдөөгүй үнэт цаасны төлбөрийн үнийн дүнгийн нийлбэрийн 110 хувиас бага болсон;
- Хөрөнгийн багцад байгаа хөрөнгийн дундаж хугацаа үнэт цаасны дундаж хугацаанаас бага болсон;
- Хөрөнгийн багцад байгаа хөрөнгийн дундаж хүү үнэт цаасны хүүгийн хэмжээнээс бага болсон;
- Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь багцын өгөөжийг нэмэгдүүлэх, төлбөрийн тасалдал үүсэхээс урьдчилсан сэргийлэх зорилгоор үнэт цаас эзэмшигчдэд төлөх үнэт цаасны төлбөрөөс бусад сул мөнгөн дүнгээр багц худалдан авах боломжтой гэж үзсэн, зээлийн багц худалдан авах талаар Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй харилцан тохиролцсон

Багц дахь хөрөнгөд дор дурдсан үндэслэл бий болсон тохиолдолд компани нь багцын хөрөнгийг анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдана. Үүнд:

- Хөрөнгийн багцын үлдэгдэл дүн анхны багцын хөрөнгийн нийт дүнгийн 20 хувьд хүрсэн тохиолдолд компанийн шаардлагаар;
- Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь энэхүү журамд заасны дагуу шаардлага хангахгүй хөрөнгийг бүхэлд нь солих хөрөнгийн жагсаалтыг компанийд гарган өгөх



2022-01-28



боловжгүй эсхүл гарган өгсөн жагсаалт нь шаардлага хангахгүй тохиолдолд солих боловжгүй хөрөнгийн багцын хэмжээгээр;

- Багцад байгаа хөрөнгийн 20 ба түүнээс дээш хувийн зээл нь 30 ба түүнээс дээш хоногийн хугацаа хэтрэлт үүссэн, энэхүү журамд заасны дагуу хөрөнгийг солиулахаар шаардсан боловч хөрөнгийг солиогүй тохиолдолд шаардлага хангахгүй багцын үнийн дүнгээр тус тус буцаан худалдана.
- Бусад тохиолдолд буюу зээлийн багцын үлдэгдэл дүн анхны багцын хөрөнгийн нийт дүнгийн 50 хувиас доош орсон тохиолдолд анхны үүрэг гүйцэтгүүлэгч буцаан худалдаж авах эрхтэй байна.

ТЗК-ийн Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь зээлийн багцад хяналт тавих ажлыг программаар өдөр бүр тогтмол хянах бөгөөд долоо хоног бүр хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах шаардлага үүссэн зээлийн мэдээллийг анхны үүрэг гүйцэтгүүлэгчид хүргүүлнэ.

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс орлуулах болон нэмэгдүүлэх хөрөнгийн жагсаалтыг хүргүүлж Хөрөнгө итгэмжлэн удирдагч дараах шаардлагыг хангаж буй эсэхийг шалгаж, барьцааны зүйлийн холбогдох бүртгэлийг хийснээр хөрөнгөд өөрчлөлт оруулсанд тооцно.

- * ТУЗ-өөс баталсан хууль болон санхүүгийн шалгуур хангаж буй эсэх;
- * Шаардлага хангахгүй болсон зээлийн үндсэн төлбөрөөс багагүй ;
- * Шаардлага хангахгүй болсон зээлийн сарын хуваарыт төлбөрөөс багагүй.





Эрсдэл, эрсдэлийн удирдлага

Учирч болох эрсдэлийг дараах 3 бүлэгт хуваан үзнэ.

1. Зээлдэгчтэй холбоотой эрсдэл
2. Үнэт цаас гаргах үйл ажиллагаанд оролцож буй этгээдүүдтэй холбоотой эрсдэл:
 - 2.1 Анхны үүрэг гүйцэтгэгч
 - 2.2 Үйлчилгээ үзүүлэгч
 - 2.3 Хөрөнгө итгэмжлэн удирдагч
3. Бусад гадны хүчин зүйлстэй холбоотой эрсдэл
 - Хууль, журам, зохицуулалт
 - Давагдашгүй хүчин зүйлс

Эрсдэл тус бүрийг задлан, хариу авах арга хэмжээг дор тусгав.

1. ЗЭЭЛДЭГЧТЭЙ ХОЛБООТОЙ ЭРСДЭЛ

Зээлдэгчтэй холбоотой эрсдэлд дараах тохиолдлуудыг хамруулан үзнэ.

- Зээлдэгч цаг хугацаанд нь зээлээ төлөхгүй байх, үндсэн болон хүүгийн төлөлтийн хоцрогдол үүсэх
- Зээлдэгч зээлээ хугацаанаас нь өмнө хаах
- Зээлдэгч зээлээ төлж чадахгүй болох

Зээлдэгчтэй холбоотой эрсдэлийг удирдах

- Зээлийн төлбөр төлөгдөхгүй болох болон хугацаанаасаа өмнө төлөгдөх эрсдэл үүссэн тохиолдолд багцад буй тухайн хөрөнгийг ижил дүнтэй, шаардлага хангасан зээлээр солих, эргүүлэн худалдаж авахыг хөрөнгө итгэмжлэн удирдагч шаардан Анхны үүрэг гүйцэтгүүлэгч хэрэгжүүлэх замаар эрсдэлийг бууруулна.
- Компани нь зээлдэгчтэй холбоотой эрсдэлийг бууруулах зорилгоор оролцогч бусад талуудтай хамтран ажиллах гэрээнд тус бүр эрсдэл бууруулах мэдээллийг цаг тухай бүр хүргэх, хянах, солих зохицуулалтуудыг оруулна. Мөн “Багцын хөрөнгөд өөрчлөлт оруулах журам” баталж ажиллана.

Зээлдэгчтэй холбоотой эрсдэлийг хаах үндсэн арга замыг “Багцын хөрөнгөд өөрчлөлт оруулах журам”-д заасан ба багцад багтас зээлүүд нь зээлийн чанар хэвийн ангилалтай болон Омни Актив ТЗК-ийн ТУЗ-с баталсан хуулийн болон санхүүгийн шаардлагыг хангаж байх шаардлагатай. Тус нөхцөл хангагдахгүй зээлүүд гарсан тохиолдолд тухай бүр үүсгэн байгуулагч бөгөөд анхны үүрэг гүйцэтгэгч шаардлага хангахгүй зээлийг солих, хөрөнгө итгэмжлэгчийн зүгээс багцыг анхны үүрэг гүйцэтгэгчийн хэвийн зээлүүдээр нэмэх зэрэг арга замаар эрсдэлийг бууруулахаар зохицуулсан. Ингэснээр багц дах зээлүүд чанаргүйжих, зээлүүд эрт төлөгдсөнөөр багц хүрэлцэхгүй болох гэх мэт үндсэн эрсдэлийг хааж байна.



2. ОРОЛЦОГЧ БУСАД ЭТГЭЭДҮҮДТЭЙ ХОЛБООТОЙ ЭРСДЭЛ:

2.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй холбоотой эрсдэл

- Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь хөрөнгийг сольж чадахгүй байх
- Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь татан буугдах, дампуурах

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй холбоотой эрсдэлийг удирдах

- Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь багцыг сольж чадахгүй, барьцаагаар үүрэг гүйцэтгэхэд цаг хугацааны алдагдал үүсэн үнэт цаасны төлбөрийг бүрэн барагдуулж чадахгүй нөхцөл үүссэн тохиолдолд эрсдлийн сангаас төлбөрийг барагдуулж, буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.
- Багцын шаардлагыг хангахгүй болсон зээлийг сольж чадахгүй нөхцөл үүссэн тохиолдолд тухайн зээлийн барьцааны, фидуцийн гэрээнд заасны дагуу барьцаагаар үүргийн гүйцэтгэлийг хангуулах;
- Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь сайн дурын үндсэн дээр эсхүл хуульд заасан үндэслэлээр татан буугдах тохиолдолд барьцаа хөрөнгөөр бусад төлбөр авагч нараас тэргүүн ээлжинд үүргийн гүйцэтгэлийг хангуулах ба барьцаа хөрөнгө нь шаардлагыг хангахгүй бол Иргэний хууль, Компанийн тухай хуульд заасан дарааллаар хангана. Хэрэв Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь дампуурсан тохиолдолд Дамгуурлын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.7-д заасны дагуу барьцаа хөрөнгөөр бусад нэхэмжлэгч нараас тэргүүн ээлжинд шаардлагыг хангах ба хэрэв барьцаа хөрөнгө нь шаардлагыг хангахад хүрэлцэхгүй бол ийнхүү хүрээгүй хэсгийг энгийн нэхэмжлэлийн дарааллаар хангана.
- ТЗК нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй холбоотой эрсдэлийг бууруулах зорилгоор холбогдох журам, гэрээнд тус бүр эрсдэл бууруулах, мэдээллийг цаг тухай бүр хүргэх, хянах, мэдээлэл солилцох зохицуулалтуудыг тусгасан байна.


Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй холбоотой эрсдэлийг бууруулахын тулд богино хугацаанд үүсч болох эрсдэлийг эрсдэлийн санг ашиглах, цаашлаад барьцаагаар үүргийн гүйцэтгэлийг хангуулах арга хэмжээг авна.

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй холбоотой багцын хөрөнгийг сольж чадахгүй байх эрсдэл нь зээлийн хүрэлцээ хангалтгүй байх нөхцөлд үүсэх ба тус нөхцөл үүсэх эрсдэл бага юм. 2021 оны 3 дугаар улирлын байдлаар анхны үүрэг гүйцэтгэгчийн нийт хөрөнгө 14.5 тэрбум төгрөг, зээлийн багцын үлдэгдэл 12 тэрбум төгрөг, байгаа нь багцын хөрөнгийг солиход хүрэлцэхүйц зээлийн багцтайг илтгэж байна. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь үүсгэн байгуулагчийн хувьд үнэт цаасны татан төвлөрүүлсэн хөрөнгийг мөн зээлийн багцыг нэмэгдүүлэхэд зарцуулна.

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч татан буугдах эрсдэл нь компанийн зээлийн чанарын нөхцөл болон аливаа хууль бус үйл ажиллагаатай холбоотойгоор үүсч болох юм. Хуулийн фирм нь анхны үүрэг гүйцэтгэгч бөгөөд үүсгэн байгуулагч болох "Омни капитал ББСБ" ХХК, тэдгээрийн эцсийн өмчлөгчдийн талаар хууль журмын шаардлагыг хангаж буй эсэх талаар эерэг дүгнэлт гаргасан. Мөн компанийн зээлийн чанаргүйжилтийн түүхэн үзүүлэлт салбарын дунджаас тогтмол доогуур хадгалагдаж ирсэн тул анхны үүрэг гүйцэтгэгч төлбөрийн чадваргүй болох, татан буугдах нөхцөл үүсэх эрсдэл маш бага юм.

Т.Н.Г.





2.2. Үйлчилгээ үзүүлэгчтэй холбоотой эрсдэл

- Үйлчилгээ үзүүлэгч нь төлбөрийг бүрэн гүйцэд, гэрээгээр хүлээсэн хугацааны дагуу цуглуулан ТЗК-д шилжүүлэхгүй байх
- Үйлчилгээ үзүүлэгч нь татан буугдах, дампуурах

Үйлчилгээ үзүүлэгчтэй холбоотой эрсдэлийг удирдах

- Үйлчилгээ үзүүлэгч нь “Төлбөр цуглуулах, үнэт цаас эзэмшигчдэд төлбөр төлөх журам”-д заасны дагуу зээлийн эргэн төлөлтийг цуглуулах данс банкинд тусгайлан нээлгэж, уг дансанд зөвхөн ТЗК-ийн хөрөнгийн багцад буй зээлүүдийн үндсэн болон хүүгийн төлөлтийг цуглуулан өөрийн бусад хөрөнгөөс ангид байлгана.
- Үйлчилгээ үзүүлэгчийн төлбөр цуглуулах данснаас ТЗК-ийн төлбөр гүйцэтгэх данс уруу зарлага гаргана. Үүнийг үйлчилгээ үзүүлэгч нь банктай байгуулсан гэрээ эсхүл холбогдох албан тоотоор мэдэгдэх замаар зарлагыг хязгаарлан, хэрэгжилтийг хангана.
- Үйлчилгээ үзүүлэгч нь төлбөр цуглуулах үйл ажиллагааг цаг хугацааны дагуу, бүрэн гүйцэд цуглуулах үүргээ санаатай буюу болгоомжгүй үйлдлийн улмаас зөрчсөний улмаас бусдад хохирол учруулсан бол “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль”-ийн 19.9-д заасны дагуу хохирлыг арилгана. Ингэхдээ учруулсан хохиролтой дүйх хэмжээний мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийг өөрийн хөрөнгөөс төлж барагдуулна.
- Үйлчилгээ үзүүлэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа биелүүлэхгүй байх, зохих ёсоор гүйцэтгээгүй эсхүл татан буугдах, дампуурах эрсдэл үүссэн тохиолдолд тусгаарласан зээлийн багцтай холбоотой авлага цуглуулах, төлбөр гүйцэтгэх үүргийн гүйцэтгэлийг хангуулах үйл ажиллагааг өөр хэвийн үйл ажиллагаатай үйлчилгээ үзүүлэгчид шилжүүлнэ.
- ТЗК нь үйлчилгээ үзүүлэгчтэй холбоотой эрсдэлийг бууруулах, үүссэн эрсдэлийг шийдвэрлэх зорилгоор холбогдох журам, гэрээнд эрсдэл бууруулах, мэдээллийг цаг тухай бүр хүргэх, хянах, мэдээлэл солилцох зохицуулалтуудыг тусгасан байна.

Үйлчилгээ үзүүлэгчтэй эрсдэлийг бууруулахаар үндсэн 2 арга хэмжээг тусгасан. Үүнд эрсдэлийн сан болон үйлчилгээ үзүүлэгч нь ТЗК-ийн багцаас орох мөнгөн урсгалыг өөрийн хөрөнгийн данснаас тусад шинээр нээсэн төлбөр цуглуулах дансанд байршуулах, тус данснаас зөвхөн ТЗК-ийн төлбөр гүйцэтгэх данс уруу шилжүүлэх түгжилт хийх багтана.



2.3. Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай холбоотой эрсдэл

- Хөрөнгө итгэмжлэгч нь багцын хөрөнгийг гэрээнд зааснаас гадуур, зүй бусаар удирдах, ашиглах
- Хөрөнгө итгэмжлэгч нь бэлэн мөнгөний удирдлага, багцын харьцаа зэргийг зохисгүй удирдах
- Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тусгай зөвшөөрлийг төрийн байгууллагаас цуцлах
- Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь татан буугдах, дампуурах

Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай холбоотой эрсдэлийг удирдах

- "Төлбөр цуглуулах, үнэт цаас эзэмшигчдэд төлбөр төлөх журам"-д заасны дагуу хөрөнгө итгэмжлэн удирдагч нь ТЗК-ийн банканд нээлгэсэн дансыг удирдах эрхтэй ба зарлага гарахдаа зөвхөн журам болон гэрээнд заасан гүйлгээг хийнэ. Зарлага гаргах тухайлсан данснуудын мэдээллийг ТУЗ-ын зүгээс Банкинд албан тоот байдлаар мэдэгдэн зөвхөн дурдсан данснууд уруу зарлага гаргах түгжилт хийх замаар эрсдэлийг удирдана.
- Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь багцын удирдлагатай холбоотой тайлан мэдээллийг үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээний дагуу үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагч, холбогдох эрх бүхий байгууллагад тогтмол хүргэх бөгөөд хууль болон гэрээнд зааснаас гадуур, зүй бусаар удирдаж, ашиглах тохиолдолд ТЗК-ийн ТУЗ нь хөрөнгө итгэмжлэн удирдагчийг нэн даруй солих шийдвэр гаргах эсхүл үйл ажиллагааг залруулах, хохирлыг барагдуулах тодорхой хугацаа өгөх эрхтэй. Мөн зүй бус хөрөнгийн удирдлагатай холбоотой аливаа хохирол учирсан тохиолдолд Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь өөрийн хөрөнгөөр бүрэн төлж барагдуулах талаар гэрээнд тодорхой тусгаж баталгаажуулсан байна;
- Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тусгай зөвшөөрлийг төрийн зохицуулах байгууллагаас цуцлах, хөрөнгө итгэмжлэн удирдагч нь татан буугдах, дампуурах нехцөл үүссэн тохиолдолд шаардлага хангах хөрөнгө итгэмжлэн удирдагчийг яаралтай шинээр сонгон ажиллуулна.
- ТЗК нь Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай холбоотой эрсдэлийг бууруулах, үүссэн эрсдэлийг шийдвэрлэх зорилгоор холбогдох журам, гэрээнд эрсдэл бууруулах, мэдээллийг цаг тухай бүр хүргэх, хянах, мэдээлэл солилцох зохицуулалтуудыг тусгасан байна.

Хөрөнгө итгэмжлэгчтэй холбоотой үндсэн эрсдэл нь хөрөнгийн зохисгүй удирдлага болон хөрөнгө итгэмжлэгч компани татан буугдах эрсдэл байна. Тус эрсдэлүүдийг хөрөнгө итгэмжлэгчтэй байгуулах гэрээ, төлбөр цуглуулах, үнэт цаас эзэмшигчдэд төлбөр төлөх журам зэргээр зохицуулсан ба эрсдэлээс урьдчилан сэргийлэх, түүний тулд мэдээллийг цаг тухай бүр хүргэх, хянах зохицуулалтуудыг хийсэн.



2022-01-28

СЭХ
он 2022.01.12 дээр
БҮРТГЭВ
№ 01

3. ГАДНЫ ХҮЧИН ЗҮЙЛСТЭЙ ХОЛБООТОЙ ЭРСДЭЛ

- 3.1.** ХБҮЦ, ТЗК, оролцогч талуудад тавигдах шаардлагатай холбоотой хууль журам, зохицуулалт өөрчлөгдөх эрсдэл


- Эрсдэлийн удирдлага:

Холбогдох өөрчлөлтүүдтэй холбоотой ТЗК-ийн ТУЗ нь хурал хуралдуулж, шаардлагатай бол эрсдэлийн үнэлгээ, үр нөлөөтэй холбоотой гадны байгууллага, хуулийн фирм зэргийг хөлслүүлэн ажилуулах, зохицуулах байгууллагуудтай тогтмол мэдээлэл солилцох, хурлын тогтоол гаргах замаар эрсдэлийг бууруулж ажиллана.

- 3.2.** Давагдашгүй хүчин зүйлстэй холбоотой эрсдэл, авах арга хэмжээ (Ковид, хөл хорио, улсын default, хэт өндөр инфляци, дипляци, байгалийн гамшиг хүчин зүйлс)

ЭРСДЭЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

- Талуудтай байгуулах гэрээнд үүсч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хянах, үссэн эсэхийг тодорхойлох зорилгоор тайлан мэдээлэл тогтмол хүлээн авах талаар тусгах ба хөрөнгө итгэмжлэн удирдагч, ТУЗ нь эрсдэлийг тодорхойлон түүний үр нөлөөг үнэлнэ. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь эрсдэл үүсэн тохиолдолд ТУЗ-д танилцуулан, үр нөлөөг тодорхойлно.
- Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь эрсдэлийн үнэлгээ хийх, эрсдэл удирдах арга хэмжээг ТУЗ-д танилцуулах, эрсдэл удирдах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- Үнэт цаасны төлбөрийн хугацаа хэтрэх, тасалдах эрсдэлээс сэргийлэх зорилгоор "Эрсдэлийн сан" байгуулна.
- ТЗК-ийн үйл ажиллагаанд хөндлөнгийн аудитор сонгон ажилуулна.
- Зээлдэгч болон холбоотой этгээдүүдтэй холбоотой эрсдэлээс урьдчилан сэргийлэхийн тулд ТЗК, хөрөнгө итгэмжлэн удирдагч нь холбогдох гэрээнүүд, журмуудад үүсч болох эрсдэл, авах арга хэмжээг тодорхой тусгах ба тэдгээр гэрээ журмууд нь хууль ёсны дагуу, нийцэлтэй байх талаар Хуулийн фирм дүгнэлт гаргасан байна.



Хууль эрх зүйн орчин



1. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагчтай холбоотой хууль эрх зүйн зохицуулалтууд

Үнэт цаас гаргагч нь үйл ажиллагаа нь хууль эрх зүйн орчны хувьд дараах хууль тогтоомжуудаар зохицуулагдаж байна. Үүнд:

- Монгол улсын үндсэн хууль
- Монгол улсын хууль
 - a. Иргэний хууль 2002
 - b. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль 2001
 - c. Компанийн тухай хууль 2011
 - d. Татварын ерөнхий хууль 2019
 - e. Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хууль 2019
 - f. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль 2019
 - g. Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль 2009
 - h. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль 2013
 - i. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль 2013
 - j. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тухай хууль 2010
- Зохицууллагч байгууллагаас гаргасан дүрэм журмууд
 - a. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журам 2011
 - b. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгийн багцыг тусгай тэмдэглэл хийж бүртгэх тухай журам 2013
 - c. Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам 2015
 - d. Үнэт цаасны зах зээл дэх дотоод мэдээллийн жагсаалт, түүнийг мэдээллэх журам 2019
 - e. Үнэт цаасанд нэгдсэн дугаар олгох журам 2010
- Хөрөнгийн биржийн журмууд /“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК/
 - a. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас бүртгэлийн журам 2020
 - b. Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам 2018
 - c. Арилжааны журам 2017
- Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн журмууд
 - a. Үнэт цаасны хадгаламжийн журам 2020
 - b. Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг бүртгэх үйл ажиллагааны журам 2019

2. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтууд

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн үйл ажиллагаа нь Банк бус санхүүгийн байгууллага болохын хувьд хууль эрх зүйн орчны хувьд дараах хууль тогтоомжуудаар зохицуулагдаж байна. Үүнд:

- Монгол улсын үндсэн хууль
- Монгол улсын Олон гэрээ
 - a. КОНВЕНЦИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ /Монгол Улс 2001 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр гарын үсэг зурсан Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай олон улсын Конвенц/
 - b. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц, түүний нэмэлт болох хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол, шилжин суурьшигчдыг газраар, далайгаар болон агаараар хууль бусаар оруулахын эсрэг протокол, галт зэвсэг, бүрдэл хэсэг, эд анги, галт хэрэгслийг хууль бусаар тээвэрлэх, үйлдвэрлэхийн эсрэг протоколд нэгдэн орсныг соёрхон батлах тухай /Палермогын конвенци/
- Монгол улсын хууль
 - a. Иргэний хууль 2002
 - b. Компанийн тухай хууль 2011



- c. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль 2002
- d. Банк, эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль 2021
- e. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль 2013
- f. Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль 2019
- g. Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль 2015
- Зохицуулагч байгууллагаас гаргасан дүрэм журмууд
 - a. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам 2016
 - b. Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам 2019
 - c. Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам 2020
 - d. Банкнаас бусад санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх тохиромжтой этгээдийг тодорхойлох журам 2020
 - e. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам 2019
 - f. Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, хорогдуулах, шинээр хувьцаа гаргах, худалдах, шилжүүлэхэд мөрдөх журам 2020
 - g. Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалуулагчид мэдээлэл өгөх журам 2010
 - h. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам 2018

3. Хөрөнгийн багцтай холбоотой эрх зүйн зохицуулалтууд

Үнэт цаас гаргагчийн санал болгож байгаа үнэт цаасны баталгаа болох Хөрөнгийн багцтай холбоотой харилцааг дараах хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулна. Үүнд:

- Монгол улсын хууль
 - a. Иргэний хууль 2002
 - b. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тухай хууль 2010
 - c. Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль 2019
 - d. Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль 2015
 - e. Авто тээврийн тухай хууль 1999
 - f. Автомобилээр хэрэгслийн бүртгэл, улсын дугаар олгох журам 2020

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-т зааснаар "Энэ хуулийн зорилт нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, түүнд хяналт тавих, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино" гэж тодорхойлсон байdag.

Дээрхээс үзвэл Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, түүнийг гаргагчтай холбоотой эрх зүйн үндсийг тогтоож байгаа эрх зүйн гол баримт бичиг нь энэ хууль болох бөгөөд уг хуулиар Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагч болон оролцогч этгээдүүдэд танигдах шаардлага, хөрөнгийн багцад тавигдах шаардлага, баталгаат үнэт цаас гаргах харилцаанд оролцогч этгээдүүдийн хоорондийн харилцаа, эрх үүрэг болон хөрөнгө оруулагчидийн эрх ашгийг хамгаалах зохицуулалтууд бүгд тусгагдсан байна. Дээрх хуульд үндэслэн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрөл олгох болон, үнэт цаасыг бүртгэх үйл ажиллагааг зохицуулагч байгууллага болох Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан журмуудаар зохицуулж байна.

Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 09 дугаар сарын 14 -ны өдрийн 266 дугаар тогтоолоор батлагдсан "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам"-ын нэг дэх хэсгийн 1.1-д зааснаар "энэхүү журмын зорилго нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэх, түүнд хяналт тавих, зах зээлийн харилцаанд оролцогчдод тусгай зөвшөөрөл олгох, шалгуур үзүүлэлтүүдийг тогтоох, эрх олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино" гэж заасан, Хөрөнгөөр батлгаажсан үнэт цаас гаргах тусгай



2022 -01- 28

СЭХ

8402 , бр. 1.2 алб.

БҮРТГЭВ

зөвшөөрөл олгох болон түүнийг бүртгэх, оролцогчдод тавих шалгуурыг тогтоох, эрх 01 олгохтой холбоотой харилцааг тусгайлан зохицуулсан байна.

Мөн энэхүү журмаар Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагч хуулийн этгээдтэй холбоотой Компанийн тухай хуулиар шийдвэрлэгдээгүй асуудлууд болох үүсгэн байгуулагчид тавигдах шаардлага, ТУЗ-ийн гишүүдэд тавигдах шаардлага зэргийг нарийвчлан зохицуулсан байна.

"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам"-аар хөрөнгөөр батлагаажсан үнэт цаасыг тус биржийн бүртгэлд бүртгэх, Бүртгэлийн шалгуур шаардлагыг тогтоох, Үнэт цаас гаргагчийн хүлээх үүрэг, түүнд биржээс хяналт тавих журмыг тогтоосон байна.

Омни актив ТЗК-тай холбоотой гэрээнүүд

Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний төсөл

Хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээ үзүүлэх гэрээний төсөл

Төлбөр цуглуулах үйлчилгээний гэрээний төсөл

Аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээ

Андеррайтерийн болон зөвлөх үйлчилгээний гэрээ

Хуульчийн зөвлөх үйлчилгээний гэрээ

Банктай байгуулах данс нээх гэрээ

Үйл ажиллагаанд хяналт тавих хөндлөгийн аудитортой байгуулсан гэрээ

Барьцааны гэрээ /Автомшинаас бусад хөдлөх эд хөрөнгө болон үл

Барьцааны гэрээ /Фидуци/

Омни актив ТЗК-ийн гаргаж буй ХБҮЦ-тай холбоотой дүрэм, журмууд

Журмын нэр

Хөндлөнгийн аудитор, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, солих тухай журам

ТУЗ-ийн үйл ажиллагааны журам

Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргэх журмын төсөл

Төлбөр цуглуулах, үнэт цаас эзэмшигчдэд төлбөр төлөх журам

Багцын хөрөнгөд өөрчлөлт оруулах журам

Эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх журам

Мөнгө, угаах терроризмийг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам

J. Chyld





ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭГЧИЙН ТУХАЙ

Ерөнхий танилцуулга, тусгай зөвшөөрөл авсан тухай мэдээлэл

Хөрөнгө итгэмжлэн удирдагч болох "Юнайтед Айр Файнэнс" ХХК нь 2021 оны 10-р сарын 28-нд Хорооны 473 дугаар тоот тогтоолоор үнэт цаасны зах зээл дээр "Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа" эрхлэх тусгай зөвшөөрлийг авч, үйл ажиллагаа явуулж байгаа болно.

Нэр:	"Юнайтед айр файнэнс" ХХК
РД:	2870657
Үүсгэн байгуулагдсан огноо:	2021.09.16
Эзэмшиж буй тусгай зөвшөөрөл	Хөрөнгө итгэмжлэн удирдах
Гүйцэтгэх удирдлагын мэдээлэл	Х.Маргад-Эрдэнэ
Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ	50,000,000₮
Арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй эсэх	Үгүй
Хаяг	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, СТӨ-ний 10 давхарт 1005 тоот
Хувьцаа эзэмшигчийн мэдээлэл	Ц.Нармандах – 100 хувь

"Юнайтед Айр Файнэнс" ХХК-ийн хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа

Банк, банк бус санхүүгийн байгууллага, ОССК болон Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрсөн бусад байгууллагын ТЗК-ийн санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлийг хөтлөх, мөнгөн хөрөнгийг зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалтад байршуулах, хөрөнгө оруулагч болон зохицуулагч байгууллагад тайлан мэдээ гаргах, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах ажлыг хийж гүйцэтгэнэ.


Компанийн удирдлага

Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрээр үүсгэн байгуулагдсан бөгөөд удирдлагын тогтолцоо нь тус компанийн дүрэмд заасны дагуу Компанийн эрх барих дээд байгууллага болох Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2 дахь хэсэгт заасны дагуу хувьцаа эзэмшигч өөрөө хэрэгжүүлнэ. Компани төлөөлөн удирдах зөвлөлтэй байх ба гүйцэтгэх захирал нь ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах тухай дүрэмд тусгажээ.

Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай байгуулах гэрээний тухай

Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь хөрөнгө оруулагчийн эрх ашигт нийцүүлэн хөрөнгийг эзэмших, удирдах үндсэн үргийн хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:





Хөрөнгийн багцыг удирдах, хяналт тавих

- Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс ТЗК-д Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний дагуу шилжүүлсэн хөрөнгийг жагсаалтын дагуу компанийн нэрийн өмнөөс өөрийн программ хангамжаар хүлээн авч, багцын бүртгэлийг цаасаар баталгаажуулах;
- Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь ТЗК-ийн хөрөнгийн багц дах зээлийн данс бүртгэлийг өөрийн компанийн данс бүртгэл, санхүүгийн тайлан тооцооноос тусад нь бүртгэх;
 - Зээлийн данс бүртгэлийг үйлчилгээ үзүүлэгчийн тайланд үндэслэн сард нэг удаа тулгах;
 - Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний дагуу шилжүүлэн авах хөрөнгө нь ТЗК-ийн ТУЗ-өөс баталсан шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхэд хяналт тавьж ажиллана;
 - Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь зээлийн данс бүртгэлийг хянаж, алдаа, зөрчил илэрсэн бол түүнийг залруулах арга хэмжээг тухай бүр авах, тийнхүү шаардлага Үйлчилгээ үзүүлэгчид хүргүүлэх;
 - Зээлийн багцтай холбоотой бичиг баримт, мэдээллийг анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үйлчилгээ үзүүлэгч нараас шаардан авах эрхтэй;

Багцын хөрөнгөд дараах байдлаар өөрчлөлт оруулна.

- Багцын хөрөнгийг солих;
- Багцын хөрөнгийг нэмэгдүүлэх;
- Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдах;

Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь хүлээсэн үүргээ үнэнч шударгаар биелүүлж, үнэт цаас эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалж, харилцан талуудын ашиг сонирхлыг хүндэтгэх, хууль болон гэрээнд зааснаас гадуур, зүй бусаар захиран зарцуулах, ашиглахгүй бөгөөд гагцхүү гэрээгээр тодорхойлсон эрх хэмжээний хүрээнд ажиллах тухай тусгажээ.

Хөрөнгө итгэмжлэн удирдагчийг солих, үйл ажиллагааг зохицуулах тухай

ТЗК-ийн хөндлөнгийн аудитор, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, солих тухай зохицуулалтад Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай байгуулсан гэрээг холбогдох хууль, гэрээнд заасан үндэслэлээр цуцалж, тэднийг сольж болох тухай тусгажээ. Мөн

- Компани нь гэрээ цүцлах үндэслэл бий болсон гэж үзэж байгаа тохиолдолд цүцлах санал гаргах эсэх талаар ТУЗ-ийн хурлаар шийдвэрлэх
- Гэрээг цуцалсан тохиолдолд түүнээс хойш 14 хоногийн дотор дараагийн этгээдийг сонгоно. Компани нь Холбогдох оролцогч өөрчлөгдсөн тухай холбогдох журмын дагуу Хороонд мэдэгдэх
- Хуульд өөрөөр заагаагүй, эсхүл ТУЗ өөрөөр шийдвэрлээгүй бол Холбогдох оролцогчтой байгуулсан гэрээг цуцалсан тохиолдолд шинээр сонгогдсон этгээдийг ажлаа хүлээн авах хүртэл хугацаанд хуучин оролцогчоос үйлчилгээг авах тухай тусгажээ.





ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА

БҮРТГЭВ-03

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах процессын зураглал



Уг процессын зураглал нь МХБ-ийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам болон СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам-д заасны дагуу бүтэцлэгдсэн болно.

Үнэт цаасны арилжаанд оролцох, захиалга авах заавар

- 1 Үнэт цаасны дансаа нээлгэх
МХБ-д бүртгэлтэй үнэт цаасны компаниудаас сонгон дансаа нээх
- 2 Брокероос өөрийн үнэт цаасны дансанд мөнгө байршуулах заавар авах, байршуулах
Үнэт цаасны данс нь 12 оронд байх бөгөөд брокероосоо уг мэдээллийг лавлах боломжтой
- 3 Захиалга өгөх
Дансаа цэнэглэсний дараа үнэт цаас худалдан авах захиалга өгөх

Мөнгө байршуулах заавар

Дансны нэр	Тухайн хөрөнгө оруулагчийн өөрийн нэр дээрх данс байна
Дансны дугаар	Данс нээлгэсэн үнэт цаасны компаниасаа өөрийн нэр дээрх дансны дугаарыг авна
Банкны нэр Гүйлгээний утга	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв Нэр, Регистр, Омни актив ХБҮЦ

[Signature]





Үнэт цаас эзэмшигчийн эрх

Үнэт цаас эзэмшигч нь дараах эрхтэй байна:

- Үнэт цаасыг биржийн арилжааны журмаар худалдан авснаар үнэт цаасыг эзэмшилдээ шилжүүлэн авах, шилжүүлэн авахыг шаардах
- Үнэт цаасны хүү болон үндсэн төлбөрийг тогтоосон хугацаанд хүлээн авах, төлөхийг Үнэт цаас гаргагчаас шаардах
- Үнэт цаас эзэмших эрхээ гуравдагч этгээдэд чөлөөтэй шилжүүлж, захиран зарцуулах, арилжаалах
- Үнэт цаас эзэмшиж буй хугацаандаа Үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагааны талаар мэдээлэл хүлээн авах, мэдээллээр хангахыг шаардах,
- Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны танилцуулга болон гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол биелүүлэхийг шаардах

Үнэт цаас гаргагчийн үүрэг

ТЗК нь өөрийн хөрөнгийг өмчлөх, бизнесийн үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх, эсхүл шинээр эхлүүлэх болон ХБҮЦ гаргах баримт бичиг, хэлцлийн баримт бичгийн дагуу үүрэг хүлээх, эсхүл хүлээсэн үүргээ биелүүлэхтэй холбоотой, эсхүл тэдгээрийг зохицуулдаг бүх хууль, журам болон зааврыг бүх талаар дагаж мөрдөх үүрэгтэй. Мөн

- ТЗК-н, эсхүл түүний өмнөөс тухай бүр гаргасан бүх мэдээлэл нь үнэн зөв, төөрөгдөл үүсгээгүй болон мэдээлэл орхигдуулаагүй байна.
- ТЗК гэрээгээр хүлээсэн үүргээ болон хэлцлийн баримт бичгийн заалтыг дагаж мөрдөх (гэрээний нөгөө тал үүргээс чөлөөлснөөс бусад тохиолдолд) болон бусад этгээдийг үүргээ гүйцэтгэхийг шаардах эрхээ цаг тухайд нь хэрэгжүүлэх.
- Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг бууруулахгүй байх: өөрийн гаргасан энгийн хувьцааг буцаан худалдаж авах, эсхүл зөвшөөрсөн хувь нийлүүлсэн хөрөнгө болон/эсхүл гаргасан хувьцааны хэмжээг буруулах, эсхүл эргүүлэн төлөхгүй байх;
- Бизнесийн үйл ажиллагааг өөрчлөх: ТЗК-н бизнесийн үйл ажиллагааг өөрчлөхгүй байх, дүрэмд тодорхой заагаагүй бизнес эрхлэх, эсхүл үйл ажиллагаанд оролцохгүй байх;
- ТЗК-н хөрөнгөд ХБҮЦ эзэмшигчдийн шаардах эрхээс өөр бусад зээлдүүлэгчийн шаардах эрх ямар ч үед үүсгэхгүй байлгах талаар боломжтой арга хэмжээнүүдийг авах;
- Зээл нь шалгуур үзүүлэлт хангасан байх: шалгуур үзүүлэлт хангагүй зээл худалдан авахгүй байх;

Татвар

Аж ахуйн нэгжийн орлогын татварын тухай хуулийн 20.2.5 дахь заалт болон хувь хүний орлогын албан татварын 20.1.5 дахь заалтын дагуу нээлттэй ХБҮЦ-ны хүүгийн орлогод 5 хувийн татвар ноогдуулна.



2022 -01- 28

СЭХ

04.02.2022 сар, 12 дээр

БҮРТГЭВ

Хөрөнгө оруулагчдад танилцуулах мэдээллийн тайллангийн агуулга

Компани нь мэдээлэл хүргэхдээ Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаас гарагчийн мэдээллийн ил тод байдлын журам, Монголын хөрөнгийн биржийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам болон энэхүү журамд заасны дагуу мэдээллийг цаг тухайд нь үнэн зөв, агуулгын хувьд хоёрдмол утгагүй, бүрэн гүйцэт мэдээлэх үүрэгтэй. Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргэх журмын дагуу үндсэн төлбөр төлөгдсөн өдрөөс хойш З хоногийн Үнэт цаасны төлбөр төлөгдсөн талаар мэдээллийг үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргэхээр зохицуулсан. Энэхүү мэдээлэлд үнэт цаасны төлбөрийг төлсний дараах үлдэгдлийн мэдээлэл, түүнийг хэрхэн ашиглах талаар дурдсан байна. Бусад хүргэх шаардлагатай мэдээллийн дэлгэрэнгүйг дор оруулав:

Улирал тутам хүргүүлэх мэдээллийг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор Хороо болон Биржид бичгээр, олон нийтэд Биржийн болон компанийн цахим хуудсаар дамжуулан мэдээлнэ.

- i. Багцын хөрөнгө, мөнгөн урсгалын хөдөлгөөн, үнэт цаасны төлбөр тооцоотой холбоотой мэдээлэл.
- ii. Улирлын санхүүгийн тайлан.

Эхний хагас жилийн мэдээллийг 8-р сарын сарын 01-ний өдрийн дотор Хороо болон Биржид бичгээр, олон нийтэд Биржийн болон компанийн цахим хуудсаар дамжуулан мэдээлнэ.

- i. Төлбөр, зарлага, хөрөнгө оруулагч нарт төлөх үнэт цаасны эргэн төлөлтөөс бусад хөрөнгө, хөрөнгө оруулалтаас олсон орлогын зарцуулалт;
- ii. Хөрөнгийн багцын мэдээлэл;
- iii. Хагас жилийн санхүүгийн тайлан.



Жил тутам хүргүүлэх мэдээллийг Хороо болон Биржид бичгээр, олон нийтэд Биржийн болон компанийн цахим хуудсаар дамжуулан мэдээлнэ

- i. Жилийн эцсийн тайланг дараа оны 2 дугаар сарын 20-ны өдрийн дотор;
- ii. Жилийн үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланг дараа оны 3 дугаар сарын сарын 31-ний өдрийн дотор.

Холбогдох шийдвэр, өөрчлөлт гарсан, тухай үйл явдал болсон өдрөөс хойш З хоногийн дотор дотор Хороо болон Биржид бичгээр, олон нийтэд Биржийн болон компанийн цахим хуудсаар дамжуулан мэдээлнэ

- i. Үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөрийн мэдээлэл, төлбөрийн гүйцэтгэлд сергөөр нөлөөлөх нөхцөл байдал үүсэх, хүүгийн төлбөрийг хугацаанд төлөөгүй тохиолдолд түүний шалтгаан авах арга хэмжээний талаар;
- ii. Хөрөнгийн багц, барьцааны зүйлийн нийт үний дүнгийн 10 хувь буюу түүнээс дээш хэмжээтэй өөрчлөлт орсон;
- iii. Бүртгэл бүхий үнэт цаастай холбоотой аливаа өөрчлөлт(ХБҮЦ-ны нөхцөл өөрчлөгдхөх,





төлбөрийн хуваарь өөрчлөгдхөх, хугацаанаас өмнө эргүүлэн дуудах, нэмэлт үнэт цаас гаргах зэрэг);

- iv. Бүртгэл бүхий ХБҮЦ-ны 10 хувиас дээш үнийн дүн бүхий буцаан дуудсан, эргүүлэн авсан үнэт цаасны мэдээлэл, цаашид 5 хувиар өөрчлөгдхөх тутам;
- v. Компанийн үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалт, дүрэм, журам, хяналтын багц эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан, холбоо барих хаяг, байршил, утас, зэрэгт өөрчлөлт орох;
- vi. Үнэт цаас эзэмшигчдийн эрхэд өөрчлөлт оруулсан, гэрээ, журамд тэдгээрийн эрх ашигт нөлөөлөх нэмэлт өөрчлөлт тусгах;
- vii. Үнэт цаас зэээмшигчдийн хурал, зохион байгуулахаар шийдвэрлэсэн тохиолдолд хурал хуралдуулах тухай шийдвэр, хурлын мэдэгдэл, хурлаас гарсан шийдвэр;
- viii. ХБҮЦ-ны харилцаанд оролцогч этгээд солигдох, бүтэц зохион байгуулалт өөрчлөгдхөх, түүнтэй байгуулсан гэрээнд өөрчлөлт орох;
- ix. Төлбөрийн чадваргүй болох, эсхүл бусад байдлаар шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа эхэлсэнтэй холбоотой мэдээлэл;
- x. Эрхий бүхий байгууллагаас компанийд авсан арга хэмжээний тухай;
- xi. Үнэт цаас эзэмшигчид, хөрөнгө оруулагчдын шийдвэр, ХБҮЦ гаргагчийн үйл ажиллагаа, үнэт цаасны үнэ ханшинд нөлөөлөх зах зээлийг урвуулан ашиглах, дотоод мэдээлэлд хамаарах бусад мэдээллүүд;
- xii. Хууль болон журмаар заасан бусад мэдээлэл.

Хөрөнгө оруулагчид нь нийтэд хүртээл болгосоноос гадна дараах мэдээллийг хүсэлт тавьсаны үндсэн дээр танилцаж болно. Үүнд:

- жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан,
- компанийн нэгдмэл сонирхолтой этгээдийн нэр, тэдгээрийн эзэмшлийн хувцааны төрөл, тоо хороо, биржийн журмаар тогтоосон бусад мэдээлэл



2022 -01- 28

СЗХ
он 2022 сар 12 даар
БҮРТГЭВ
№ 01

ҮНЭТ ЦААС ГАРГАХАД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУДЫН ТУХАЙ

“ХаанЛекс Партнерс” ХХН

Өмгөөллийн “ХаанЛекс Партнерс” ХХН (“ХаанЛекс”) нь 2011 онд анх байгуулагдсан бөгөөд банк санхүү, үнэт цаас, дэд бүтэц, эрчим хүч, шүүхийн маргаан, бизнесийн болон компанийн эрх зүйн салбарт голчлон хууль зүйн мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг хуулийн фирм юм. 2014 онд Өмгөөллийн “Эм Ди Эс энд ассошиэйтс” ХХН-тэй нэгдэж, Өмгөөллийн “Эм Ди Эс энд ХаанЛекс” ХХН-ийг байгуулан ажиллаж байсан бөгөөд 2018 онд буцаж тусгаарлан ба тэр цагаас хойш Өмгөөлийн “ХаанЛекс Партнерс” ХХН гэсэн нэрээр үйл ажиллагаагаа эрхэлж байна. Тус хуулийн фирм нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 33.2.1-д заасан хууль зүйн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдээр бүртгэгдсэн, үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээд бөгөөд тус хөрөнгийн зах зээлээс санхүүжилт татаж буй компаниудтай хамтран ажиллаж байсан арвин туршлагатай. Тухайлбал: СЗХ-ны захиалгаар Үнэт цаасны кастодианы журмын төслийг олон улсын зөвлөхтэй хамтран боловсруулах, “Эрээнцав” ХК, “Хай Би Ойл” ХК, “Даваанбулаг” ХК, “Түмэншууут” зэрэг компаниудын хувьцааг МХБ дээр шинээр нэмж гаргах IPO болон FPO-ийн ажилд хууль зүйн үйлчилгээ үзүүлэх, Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банкнаас “Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци” ХК-д хувьцаанд хөрвөх санхүүжилт олгох ажилд мөн хууль зүйн зөвлөгөө өгч ажилласан туршлагатай. Мөн Монгол Улсад хийгдсэн олон улсын шинжтэй томоохон гэрээ, хэлцлүүдэд эрх зүйн зөвлөгөө өгч, амжилттай ажилласан ба тэдгээрийн зарим нь олон улсын хэмжээнд танигдаж, хүлээн зөвшөөрөгдсөн. Түүнчлэн, хууль зүйн зөвлөгөө өгч ажилладаг үндсэн эрх зүйн салбарууд (банк санхүү, дэд бүтэц, бизнесийн эрх зүй, шүүхийн маргаан зэрэг)-аас гадна “ногоон санхүүжилт”-ийн эрх зүйн чиглэлээр ажилласан арвин туршлагатай.

Хууль зүйн үйлчилгээний гэрээ

Үнэт цаас гаргагч болон “ХаанЛекс партнерс” ХХН нь 2021 оны 09 сарын 02-ны өдөр “Хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ”-г байгуулсан.

Тус гэрээнд зааснаар хуулийн фирм нь:

- ХБҮЦ гаргахтай холбоотой хууль зүйн дүгнэлт боловсруулах.
- Зээлийн багцад тавигдах хууль зүйн шаардлагыг ТЗК-тай хамтран тодорхойлох, улмаар Зээлийн багцийн хуулийн шалгуур үзүүлэлтэд нийцсэн эсэх талаарх хуулийн хөндлөнгийн дүн шинжилгээ хийж, тайлан гаргах.
- ХБҮЦ гаргахтай холбоотой байгуулах гэрээ, хэлцэл, шийдвэрийн төсөл хянахаар тусгажээ.

Тус үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд хуулийн фирм нь шаардлагатай баримт бичигтэй танилцах, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэмд нийцүүлэн хууль зүйн үйлчилгээг үзүүлэх, Үйлчилгээг үзүүлэхдээ үнэн бодит мэдээллээр хангах зэрэг эрх үүрэгтэй байна. Мөн ТЗК нь үйлчилгээний талаар шаардлага, санал гаргах, үйлчилгээтэй холбоотой үнэн бодитой мэдээлэл, баримт бичгээр түргэн уурхай хангах, холбогдох асуулт, хүсэлтэд түргэн шуурхай хариу өгөх зэрэг оролцоог хангахаар тусгажээ.



2022-01-28

СЗХ
2022.01.12. оно
БҮРТГЭВ
№ 01

“Апекс капитал” УЦК

Компани анх 2011 онд үүсгэн байгуулагдсан ба 2018 онд компанийн менежментийн багийг шинэчилж одоогийн удирдлагын баг ажиллаж эхэлсэн. “Апекс капитал УЦК” ХХК нь СЗХ-ноос брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн тусгай зөвшөөрөлтэй, гадаад арилжааны үйлчилгээ үзүүлэх эрхтэйгээр харилцагчиддаа санхүүгийн цогц үйлчилгээ үзүүлсээр байна.

2018 оноос хойш Андеррайтерийн үйлчилгээг 40 орчим аж ахуйн нэгжид үзүүлэн санхүүжилт татах ажил дээр амжилттай ажилласан.

Андеррайтерийн хөрөнгийн зах зээлд хийсэн голлох ажлууд:

2018-2020 оныг хүртэл хаалттай хүрээний бондын санхүүжилтэд төвлөрөн ажилласан ба хамтран ажилласан байгууллагуудыг салбараар ангилбал:

- Хүнсний салбар
- Барилгын салбар
- Тээвэр зуучлалын салбар
- Санхүүгийн салбар
- Банк бус санхүүгийн байгууллагууд

2021 оны эхэн үеэс гуравдугаар улирлын байдлаар 55 тэрбум төгрөгийн хаалттай хүрээний бондын санхүүжилт дээр татан төвлөрүүлсэн амжилттай байна. Мөн хөрөнгийн зах зээлд нээлттэй арилжаалагдаг бүтээгдэхүүнүүд болох “Мандал Ирээдүйн өсөлт” хамтын хөрөнгө оруулалтын санд Андеррайтераар, “Сэнтрал Экспресс Си Ви Эс” ХК-ийн IPO үйл ажиллагаанд туслах андеррайтераар хамтран ажилласан.

Андеррайтертай байгуулсан гэрээ

- (ii) Баримт бичгийн хуулбарыг хүлээн авсан бол тэр нь эх хувийн үнэн зөв, бүрэн хуулбар мөн;
- (iii) Хэрвээ бид Баримт бичгийн төслийг хүлээн авсан бол ут баримт бичиг нь тус төслийн дагуу үйлдэгдэнэ;
- (iv) Бидэнд ирүүлсэн Баримт бичгүүдэд нэмэлт, өөрчлөлт ороогүй, эсхүл тэдгээр нь хүчингүй болоогүй;
- (v) ТЗК болон бусад оролцогч талууд нь Баримт бичгийг үйлдэх бүрэн эрхтэй бөгөөд түүнийг зохих журмын дагуу үйлдсэн буюу байгуулсан ба түүгээр хүлэсэн үүргээ биелүүлнэ;
- (vi) Аливаа этгээд нь санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдлээрээ төрөгдүүлэх, хууран мэхлэх үйл ажиллагаанд оролцоогүй. Аливаа этгээд нь энэхүү тайлангийн аливаа хэсгийг буруу болгох ямарваа үйл ажиллагаанд оролцоогүй буюу оролцохгүй;
- (vii) Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан болон хавсаргагдсан андеррайтер, аудитор болон бусад мэргэжлийн оролцогчдын гаргасан судалгаа, дүгнэлт, тайлан, санхүүгийн мэдээлэл нь үнэн зөв;
- (viii) Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан үйл баримт, мэдээлэл нь ирээдүйд хэрэгжих тохиолдолд тус үйл баримт, мэдээлэл нь хуулийн дагуу зохих ёсоор биелэгдэнэ;

Үнэт цаас гаргагч, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч этгээдүүд, бусад эрх бүхий байгууллага болон тэдгээрийн эрх бүхий албан тушаалтнуудаас ирүүлсэн баримт, мэдээлэл нь үнэн зөв, хүчин төгөлдөр.





2. Нэр томьёо ба товчилсон үгийн тайлбар

Дүгнэлтэд хаалтад тодорхойлсноос гадна дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

"МХБ" гэж "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийг;

"МХБ-ийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам" гэж МХБ-ийн ТУЗ-ийн 2020 оны 2020/06 тоот тогтоолоор баталсан "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам"-ыг;

"СЗХ" гэж Санхүүгийн зохицуулах хороог;

"СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам" гэж СЗХ-ны 2011 оны 266 тоот тогтоолоор баталсан "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх тусгай зөвшөөрөл олгох тухай журам"-ыг;

"ТУЗ" гэж төлөөлөн удирдах зөвлөлийг;

"УБЕГ" гэж Улсын бүртгэлийн срөнхий газрыг;

"Үнэт цаасны бүртгэлийн журам" гэж СЗХ-ны 2021 оны 225 тоот тогтоолоор баталсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ыг;





3. Хууль зүйн дүгнэлт

3.1. ТЗК-ийг үүсгэн байгуулах ажиллагаа болон түүнийг хуулийн этгээдийн бүртгэлд бүртгүүлсэн байдал нь хууль тогтоомжийн хүрээнд хийгдсэн, холбогдох шийдвэр, гэрчилгээ, дүрэм зэрэг нь хүчин төгөлдөр эсэх талаар

ТЗК-ийг үүсгэн байгуулах ажиллагаа болон түүнийг хуулийн этгээдийн бүртгэлд бүртгүүлсэн байдал нь хууль тогтоомжийн хүрээнд хийгдсэн, холбогдох шийдвэр, гэрчилгээ, дүрэм зэрэг нь хүчин төгөлдөр эсэхийг дараах асуултад хариулт өгөх замаар шалгав:

- (i) TЗK-ийг үүсгэн байгуулсан этгээд нь түүнийг байгуулах эрх бүхий субъект мөн эсэх?

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.4-т зааснаар тусгай зориулалтын компанийг банк, банк бус санхүүгийн байгууллага, орон сууцны санхүүжилтийн компани болон СЗХ-оос зөвшөөрсөн санхүүгийн бусад байгууллага байгуулж болох юм. "Омни Капитал ББСБ" ХХК нь СЗХ-нд бүртгэлтэй банк бус санхүүгийн байгууллага тул баталгаат үнэт цаас гаргах тусгай зориулалтын компанийг үүсгэн байгуулах эрх бүхий этгээд мөн байна.

- (ii) TЗK-ийг үүсгэн үүсгэн байгуулагдах үйл ажиллагаа нь хууль тогтоомжийн дагуу явагдсан эсэх?

"Омни актив" ХХК нь "Омни капитал ББСБ" ХХК-ийн ТУЗ-ийн ""Омни актив"" ХХК-ийг үүсгэн байгуулах тухай" 2021 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн 01 тоот шийдвэрийн дагуу үүсгэн байгуулагдаж, 2021 оны 8 дугаар сарын 16-ны өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт бүртгүүлсэн байна. "Омни капитал ББСБ" ХХК-ийн ТУЗ нь Компанийн тухай хуулийн 13.2, 76.1.18-т тус тус заасны дагуу дээрх шийдвэрийг гаргах бүрэн эрхтэй байна.

"Омни актив" ХХК нь хувьцаа эзэмшигч, үүсгэн байгуулагчийн 2021 оны 9 дүгээр сарын 28-ний өдрийн №ХЭХ-21/01 тоот шийдвэрийн дагуу автомашин, үл хөдлөх эд хөрөнгө, хөдлөх эд хөрөнгө барьцаалсан зээлийн хөрөнгө худалдан авах баталгаат үнэт цаас гаргах зорилгоор компанийн үйл ажиллагааны чиглэлийг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа болгон өөрчилж, компанийн дүрмийг шинэчлэн баталсан байна. Дээрх шийдвэрийн гүйцэтгэлийг хангах зорилгоор "Омни актив" ХХК-д хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож өгөхийг хүссэн өргөдлийг СЗХ-нд гаргасны дагуу тус үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг СЗХ-ны 2021 оны 11-р сарын 24-ний өдрийн 534 тоот тогтоолоор ТЗК-д олгосон байна. Тус тусгай зөвшөөрлийн үндсэн дээр ТЗК нь эрхлэх үйл ажиллагааны чиглэлийн өөрчлөлт болон шинэчилсэн дүрмийг 2021





оны 12 дугаар сарын 10-ны өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар бүртгүүлсэн байна.

ТЗК-ийг үүсгэн байгуулах болон түүнийг хуулийн этгээдийн бүртгэлд бүртгүүлэх ажиллагаа нь хууль тогтоомжийн хүрээнд хийгдсэн бөгөөд ТЗК-ийн холбогдох шийдвэр, улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм нь хүчин төгөлдөр байна.

3.2. ТЗК-ийн дүрэм, үндэсн үйл ажиллагаанд ашиглагдах журам, зааврууд нь хууль тогтоомжид нийцсэн эсэх талаар

Үнэт цаас гаргагчаас заавал батлах дүрэм, журмыг МХБ-ийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 3.2.12-т заасан байdag бөгөөд Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь тус журамд нийцүүлэн ТЗК-ийн үйл ажиллагаанд ашиглагдах дүрэм, журмын жагсаалтыг 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 05 тоот албан бичгээр бидэнд ирүүлсэн бөгөөд уг албан бичигт дараах дүрэм журмууд багтсан байна. Үүнд:

1. “Омни актив ТЗК” ХХК-ийн дүрэм;
2. ТУЗ-ийн үйл ажиллагааны журам;
3. Хөндлөнгийн аудитор, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, солих тухай журам;
4. Эрдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх журам;
5. Төлбөр цуглуулах, үнэт цаас эзэмшигчдэд төлбөр төлөх журам;
6. Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргэх журам;
7. Багцын хөрөнгөөд өөрчлөлт оруулах журам;
8. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам.

ТЗК-ийн дүрэм болон дээр дурдсан журмуудыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг нэг бүрчлэн шалгав. Үүнд:

I. ТЗК-ийн дүрэм:

ТЗК-ийн дүрмийг тус компанийн хувьцаа эзэмшигчийн 2021 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн ХЭХ-21/01 тоот шийдвэрийн хавсралтаар баталсан нь Компанийн тухай хуулийн 17.1 болон 62.1.1-т заасан шаардлагыг хангаж байна. Түүнчлэн уг дүрмийг УБЕГ-ын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдөр бүртгүүлсэн тул Компанийн тухай хуулийн 17.9-д заасны дагуу хүчин төгөлдөр гэж үзэж болохоор байна.

Агуулгын хувьд компанийн дүрэм нь Компанийн тухай хуулийн 16.2 болон Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.9-д заасан шаардлагыг тус тус хангасан байх





ёстай. ТЗК-ийн дүрэм нь нийт 9 зүйлтэй бөгөөд зүйл тус бүр нь дараах харилцааг зохицуулсан байна. Үүнд:

- (i) *Нэгдүгээр зүйл:* Компанийн зорилго, бүрэн болон товчилсон оноосон нэр, түүний хэлбэрийг тодорхойлсон товчилсон ялгах тэмдэглэгээ, компанийн хаяг, түүнчлэн баталгаат үнэт цаас бүрэн төлөгдж дууссан тохиолдолд татан буутдах тухай;
- (ii) *Хоёрдугаар зүйл:* Компанийн эрхлэх уйл ажиллагааны чиглэл;
- (iii) *Гуравдугаар зүйл:* Компанийн зарласан болон гаргасан хувьцааны тоо, тэдгээрийн төрөл, нэрлэсэн үнэ, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ;
- (iv) *Дөрөвдүгээр зүйл:* Компанийн эрх, үүрэг;
- (v) *Тавдугаар зүйл:* Компанийн хариуцлага;
- (vi) *Зуравдугаар зүйл:* Компанийн удирдлага, тэдгээрийн бүрэн эрх;
- (vii) *Долдугаар зүйл:* Компанийн үйл ажиллагаанд тавих хяналт;
- (viii) *Ниймдугаар зүйл:* Компанийг татан буулгах үндэслэл, журам;
- (ix) *Есдүгээр зүйл:* Дүрмийн хувь болон дурмийн хүчин төгөлдөр болох үндэслэл, зохицуулах хууль.

ТЗК-ийн дүрэм нь дээр дурдсан хуулийн шаардлагуудыг хангаж байгаа бөгөөд хууль тогтоомжтой зөрчилдөөгүй байна.

II. ТУЗ-ийн үйл ажиллагааны журам

ТЗК-ийн ТУЗ-ийн 2021 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн №ТУЗ-21/02 тоот шийдвэрийн хавсралтаар ТЗК-ийн ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг баталсан байна. Тус журам нь нийт 7 зүйлтэй бөгөөд тэдгээр нь дараах харилцааг зохицуулсан байна. Үүнд:

- (i) *Нэгдүгээр зүйл:* Журмын зорилго болон компанийн баталгаат үнэт цаас бүрэн төлөгдж дууссан тохиолдолд татан буутдах тухай;
- (ii) *Хоёрдугаар зүйл:* ТУЗ-ин үйл ажиллагааг зохицуулах хууль, журмууд;
- (iii) *Гуравдугаар зүйл:* Журамд ашиглагдсан нэр томъёоны тодорхойлолт;
- (iv) *Дөрөвдүгээр зүйл:* ТУЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүн, гишүүнд тавигдах шаардлага, хугацаа;
- (v) *Тавдугаар зүйл:* ТУЗ-ийн бүрэн эрх болон дарга гишүүдийн бүрэн эрх, үүрэг;
- (vi) *Зуравдугаар зүйл:* ТУЗ-ийн хурлын зар хүргэх, хуралд оролцох, санал егөх, хурлын хүчин төгөлдөр байдал болон шийдвэр гаргалт;
- (vii) *Долдугаар зүйл:* ТУЗ-ийн гишүүдийн хариуцлага, журмын хүчин төгөлдөр болох нөхцөл болон түүнд нэмэлт өөрчлөлт оруулах.

ТЗК-ийн багцын хөрөнгөд өөрчлөлт оруулахтай холбоотой зарим эрх, үүргээ хөрөнгө итгэмжлэн удирдагчтай байгуулах гэрээний дагуу түүнд шилжүүлэх болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд нэмэлт өөрчлөлт оруулах эрхийг ТУЗ-д олгох тухай нэмэлт, өөрчлөлтийг ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын Тав болон Долдугаар зүйлд ТЗК-ийн ТУЗ-



2022 -01- 28

БҮРТГЭВ-ОР



ийн 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн ТУЗ-21/07 тоот тогтоолоор оруулан, шинэчлэн баталсан байна. Энэ нь СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 3.12 болон Компанийн тухай хуулийн 76.1.13-т тус тус нийцэж байна.

Тус журам нь Компанийн тухай хуулийн 75 – 82 дугаар зүйл, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.8, СЗХ-ны 2014 оны 5 дугаар сарын 7-ны өдрийн 162 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан “Компанийн засаглалын кодекс”-ын 5 дугаар бүлэг, СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 3.12, 3.13, 3.14, 3.16-д заасан шаардлагыг хангаж байгаа бөгөөд хууль тогтоомжид нийцсэн байна. Түүнчлэн Компанийн тухай хуулийн 76.1.13-т заасны дагуу ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг ТУЗ-ийн хурлаар баталсан нь хуульд нийцэж байна.

III. Хөндлөнгийн аудитор, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, солих тухай журам

Энэхүү журмыг “Омни актив” ХХК-ийн ТУЗ-ийн 2021 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн ТУЗ-21/03 тоот тогтоолоор баталсан байх ба ТУЗ-ийн 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн ТУЗ-21/07 тоот тогтоолын дагуу нэмэлт өөрчлөлт оруулан баталсан байна. Уг журмаар хөндлөнгийн аудитор, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчид тавигдаа шаардлага, тэдгээрийг сонгох журам, гэрээнд заах нөхцөл, тэдгээрийг солих нөхцөл зэргийг зохицуулсан бөгөөд тус журам нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.6, 10.7, 33.2.3, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 19, 20, 40 дүгээр зүйл, Аудитын тухай хуулийн 19 дүгээр зүйл, Бүртгэлийн журмын 4, 8 дугаар зүйл, Биржийн журмын 2.7, 9.4 дэх хэсэгт заасан шаардлагыг хангаж байгаа ба хууль тогтоомжтой нийцэж байна.

IV. Эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх журам

Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь 2021 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн ТУЗ-21/04 тоот тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх журам”-ыг баталсан байна. Тус журам нь нийтдээ 7 зүйлтэй бөгөөд зээлдэгч, анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагч болон гадаад хүчин зүйлстэй холбоотой эрсдэл, тэдгээрийг удирдах, урьдчилсан сэргийлэх арга хэмжээ, эргэн төлөлтийг сайжруулах арга хэмжээтэй холбоотой харилцааг зохицуулсан байна. Энэ нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 41.1, МХБ-ийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 3.2.12.4 болон бусад хууль тогтоомжид заасан шаардлагын хүрээнд буюу эдгээртэй зөрчилдөхгүй байна. Түүнчлэн, Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 3.12, ТЗК-ийн дурмийн 6.2.7.3, ТУЗ-ийн Үйл ажиллагааны журмын 5.2.1.6-д тус тус заасны дагуу энэхүү журмыг батлах бүрэн эрхтэй байх тул хуульд нийцэж байна.





V. Толбор цуглуулах, үнэт цаас эзэмшигчдэд толбор толох журам

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2021 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн ТУЗ-21/04 тоот тогтоолын 5 дугаар хавсралтаар баталсан байх бөгөөд СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 3.12, ТЗК-ийн дүрмийн 6.2.7.3, ТУЗ-ийн Үйл ажиллагааны журмын 5.2.1.6-д тус тус заасны дагуу ТУЗ нь энэхүү журмыг батлах бүрэн эрхтэй байна. Тус журам нь нийт 7 зүйлтэй бөгөөд ТЗК-аас гаргах хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны төлбөрийг цуглуулах, үнэт цаас эзэмшигчдэд толбор төлөхтэй холбоотойгоор ТЗК, Үйлчилгээ үзүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагч болон бусад холбогдох этгээдийн хооронд үүсэх харилцааг зохицуулсан байгаа нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 19, 20 дугаар зүйл, СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 4 дүгээр зүйл болон бусад зүйл, заалтыг зөрчөөгүй бөгөөд холбогдох хуульд нийцсэн байна.

VI. Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргэх журам

Тус журмыг Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2021 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн ТУЗ-21/04 тоот тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан байх бөгөөд СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 3.12, ТЗК-ийн дүрмийн 6.2.7.3, ТУЗ-ийн Үйл ажиллагааны журмын 5.2.1.6-д тус тус заасны дагуу ТУЗ нь энэхүү журмыг батлах бүрэн эрхтэй байна. Уг журмаар Хөрөнгө оруулагч, Үнэт цаас эзэмшигч нарт компанийн үйл ажиллагааны талаар болон хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг тогтмол хүргэх, уг мэдээллийн төрөл, хэлбэр, давтамж, мэдээллийн ил тод байдлыг хангах, нийтэд хүргэх, нэгдсэн нэг мэдээллийн урсгалтай байх, түүнийг хэрэгжүүлэх, хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулсан байх бөгөөд эн нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20.1 дэх хэсэг болон Долдугаар бүлгийн Нэгдүгээр дэд бүлэг, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20.2.3, 39 дүгээр зүйл, СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 3.14.5, 3.19, 3.21, 3.22, 3.23, 3.24 дахь хэсэг, МХБ-ийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 9.5, 9.6, 9.7 дахь хэсэг, СЗХ-ны 2015 оны 443 дугаар тогтооюур батлагдсан “Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам”, СЗХ-ны 2019 оны 72 тоот тогтооюур батлагдсан “Үнэт цаасны зах зээл дэх дотоод мэдээллийн жагсаалт, түүнийг мэдээлэх журам”-ын холбогдох зүйл, заалтад нийцсэн байна.

VII. Багцын хоригод оөрчлөлт оруулах журам

Тус журмыг Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2021 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн ТУЗ-21/04 тоот тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан байх бөгөөд СЗХ-ны Хөрөнгөөр





баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 3.12, ТЗК-ийн дүрмийн 6.2.7.3, ТУЗ-ийн Үйл ажиллагааны журмын 5.2.1.6-д тус тус заасны дагуу ТУЗ нь энхүү журмыг батлах бүрэн эрхтэй байна. Багцын хөрөнгөд өөрчлөлт оруулах журам нь нийт 5 зүйлтэй байх бөгөөд Үнэт цаас гаргагчийн гаргаж буй баталгаат үнэт цаасны баталгаа болох барьцаалсан зээлийн багцад буй хөрөнгийг солих, нэмэх, хасах замаар багцад өөрчлөлт оруулахтай холбоотой харилцааг зохицуулсан байна. Энхүү журмын заалтууд нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 9 дүгээр зүйл, 12.11.5, 12.13, 15 дугаар зүйл, 18.2 дахь хэсэг, СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 3.12, 3.18, 3.19, 3.22 дахь хэсэгт заасан шаардлагуудыг зөрчөөгүй байх тул холбогдох хууль тогтоомжид нийцэж байна.

VIII. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам

СЗХ-ны "Банкнаас бусад санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх тохиромжтой этгээдийг тодорхойлох журам"-ын 1.2.1, 2.1.1.2, 3.1.2.1 дэх хэсэг, СЗХ-ны эрх зүйн байдлын тухай хуулийн 3.1.6-д тус тус заасны дагуу Үнэт цаас гаргагч нь "Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэх, терроризмтой тэмцэх чиглэлээр тавигдах шаардлага, ёс зүйн шалгуур зэргийг тусгасан бодлого, журам"-тай байх шаардлагатай. Уг шаардлагын дагуу ТЗК-ийн ТУЗ-ийн 2021 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн ТУЗ-21/04 тоот тогтоолын 2 дугаар хавсралтаар уг журмыг баталсан байх бөгөөд энхүү журам нь холбогдох хууль тогтоомжид нийцэж байна.

3.3. Үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч этгээдтэй байгуулсан болон ТЗК-ийн үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой бусад гэрээ, хэлцэл нь хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх, үйл ажиллагаанд сергөөр нөлөөлөх үр дагавар байгаа эсэх талаар

Баталгаат үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч этгээд гэдэгт "МХБ-ийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 2.5.5.3.-т заасны дагуу дараах этгээдуудийг хамруулан авч үзлээ. Үүнд:

- (i) андеррайтер;
- (ii) анхны үүрэг гүйцэтгүүлэгч;
- (iii) үйлчилгээ үзүүлэгч;
- (iv) хөрөнгө итгэмжлэн удирдагч.

ТЗК нь 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 04 тоот албан бичгээр ТЗК-ийн үйл ажиллагаатай холбоотойгоор байгуулагдсан гэрээнүүдийн жагсаалтыг ирүүлсэн бөгөөд тус





жагсаалтад тусгагдсан гэрээ, хэлшэл тус бүрийг хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг доорх байдлаар шалгалаа. Үүнд:

I. Xөрөнгө худалдах, худалдан авах гэрээний төсөл

Үнэт цаас гаргагч нь 2021 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн ТУЗ-21/05 тогтоолын дагуу Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс хөрөнгийн багц худалдан авах тухай шийдвэрлэж, уг багцад тавигдах шалгуур үзүүлэлтийг баталсан байна. Түүнчлэн Үнэт цаас гаргагчид зээлийн багцын хөрөнгө худалдах тухай шийдвэрийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн ТУЗ-21/27 тоот тогтоолоор баталсан байна. Иймд уг гэрээний төслийг ТЗК-ийн ТУЗ-ийн 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн ТУЗ-21/08 тоот тогтоолоор баталсан байх бөгөөд СЗХ-оос Үнэт цаас гаргагчийн баталгаат үнэт цаасыг бүртгэх зөвшөөрөл олгосны дараа “Омни капитал БСБ” ХХК-тай байгуулахаар тогтоосон байна. Тус гэрээний төслөөр Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс Үнэт цаас гаргагчид шалгуур үзүүлэлтийг хангасан зээлийн авлагын эрх, түүнд дагалдах эрхүүдийг худалдах, Үнэт цаас гаргагч нь хэлэлцэн тохиролцсон үнийг төлөх болон бусад холбогдох харилцааг зохицуулсан байна. Уг гэрээний төсөл нь дараах хавсралттай байх бөгөөд эдгээр нь уг гэрээний салшгүй хэсэг байна. Үүнд:

1. Зээлийн багцад тавигдах ерөнхий шалгуур;
2. Зээлийн багцад тавигдах хууль зүйн шалгуур;
3. Гэрээний туслай нөхцөл;
4. Хөрөнгийн жагсаалт;
5. Бусад шаардлагатай баримт бичиг.

Дээр дурьдсан гэрээний төсөл нь Монгол Улсын Иргэний хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын холбогдох зүйл заалт болон бусад хууль тогтоомжид нийцсэн байна.

II. Xөрөнгийн багцын барьцааны гэрээний төсөл

Үнэт цаас гаргагч болон “Омни капитал БСБ” ХХК нарын хооронд дараах төрлийн барьцааны гэрээ байгуулагдах бөгөөд эдгээр гэрээний төслийг ТЗК-ийн ТУЗ-ийн 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн ТУЗ-21/08 тоот тогтоолоор СЗХ-оос Үнэт цаас гаргагчийн баталгаат үнэт цаасыг бүртгэх зөвшөөрөл олгосны дараа байгуулахаар тогтсон байна. Үүнд:

1. *Фидуцын барьцааны гэрээний төсөл:* Фидуцын барьцааны гэрээний төсөл: Энэхүү гэрээний төслөөр ТЗК болон “Омни капитал БСБ” ХХК-ийн хооронд байгуулах “Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ”-ний дагуу шилжүүлж буй Хөрөнгийн багцад хамаарах үүргийн гүйцэтгэлийн хангуулах зорилгоор анхны үүрэг гүйцэтгэгчтэй (зээлдэгчтэй) байгуулсан фидуцийн гэрээнд заасан фидуцийн зүйлийн





өмчлөх эрхийг ТЗК-д барьцаалулахтай холбоотой харилцааг зохицуулсан байх бөгөөд энэ нь Монгол Улсын Иргэний хууль, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцсэн байна.

2. **Барьцааны гэрээний төсөл (автомшинаас бусад хөдлөх хөрөнгө болон үл хөдлөх хөрөнгийн барьцааны эрхийг шилжүүлэх гэрээний төсөл):** Энэхүү гэрээний төслөөр “Омни капитал ББСБ” ХХК болон ТЗК нарын хооронд байгуулах “Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ”-ний дагуу шилжүүлж буй Хөрөнгийн багцад хамаарах үүргийн гүйцэтгэлийг хангуулах зорилгоор анхны үүрэг гүйцэтгэгчтэй (зээлдэгчтэй) байгуулсан барьцааны гэрээний шаардах эрхийг шилжүүлэх, барьцаалулахтай холбогдон бий болсон харилцааг зохицуулсан байх бөгөөд энэ нь Монгол Улсын Иргэний хууль, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцсэн байна.

III. Хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээ узүүлэх гэрээний төсөл

Энэхүү Гэрээний төслөөр ТЗК-ийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргах үйл ажиллагаатай холбоотой Хөрөнгө итгэмжлэн удирдагчаас үзүүлэх үйлчилгээ, үйлчилгээний хөлс төлөх болон гэрээний дагуу хамтран ажиллах зарчим, талуудын эрх, үүргийг зохицуулсан байх бөгөөд энэхүү гэрээг ТЗК-ийн ТУЗ-ийн 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн ТУЗ-21/09 тоот тогтоолоор СЗХ-с Үнэт цаас гаргагчийн баталгаат үнэт цаасыг бүртгэх зөвшөөрөл олгосны дараа байгуулахаар тогтсон байна. ТЗК нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.11.4, СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 3.17-д тус тус заасны дагуу энэхүү гэрээг байгуулах эрхтэй байх ба ТУЗ нь СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 3.12, ТЗК-ийн дүрмийн 6.2.7.3, ТУЗ-ийн Үйл ажиллагааны журмын 5.2.2.2-д тус тус заасны дагуу ТЗК-н нэрийн өмнөөс энэхүү гэрээг байгуулах, гэрээний төслийг батлах шийдвэрийг гаргах бүрэн эрхтэй байна. Уг гэрээний төсөл нь үндсэн хэсгээс гадна 22 зүйл бүхий ерөнхий нөхцөл, 5 зүйл бүхий тусгай нөхцөлөөс бүрдэх бөгөөд эдгээр нь Монгол Улсын Иргэний хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйл, СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 4 дүгээр зүйл, МХБ-ийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 2.7 заалтыг тус тус зөрчөөгүй, холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

IV. Толбор цуглүүлах үйлчилгээ узүүлэх тухай гэрээний төсөл



2022 -01- 28

БҮРТГЭВ-03



Энэхүү гэрээг батлах тухай ТЗК-ийн ТУЗ-ийн 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн ТУЗ-21/10 тоот шийдвэрийн дагуу тус гэрээг СЗХ-оос Үнэт цаас гаргагчийн баталгаат үнэт цаасыг бүртгэх зөвшөөрөл олгосны дараа байгуулахаар тогтсон байна. ТЗК нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.11.4, СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 3.17-д тус тус заасны дагуу энэхүү гэрээг байгуулах эрхтэй байх ба ТУЗ нь СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 3.12, ТЗК-ийн дүрмийн 6.2.7.3, ТУЗ-ийн Үйл ажиллагааны журмын 5.2.2.5-д тус тус заасны дагуу ТЗК-н нэрийн өмнөөс энэхүү гэрээг байгуулах шийдвэрийг гаргах бүрэн эрхтэй байна. Тус гэрээ нь нийт 9 зүйлтэй бөгөөд Үнэт цаас гаргагчийн гаргах хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны төлбөрийг үүрэг гүйцэтгэгчээс цаг хугацаанд нь цуглуулан, ТЗК-д шилжүүлэх, бүртгэлийг хөтлөх, тайлагнахтай холбоотой харилцааг зохицуулсан байна. Гэрээний заалтууд нь Монгол Улсын Иргэний хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 19 дүгээр зүйл, СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 4 дүгээр зүйл, МХБ-ийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 2.7 дахь хэсэг болон холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

Түүнчлэн үйлчилгээ үзүүлэгч нь СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 4.2, 4.3, 4.4-т заасан шалгуур шаардлагыг хангаж байгаа болох нь “Омни капитал ББСБ” ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм, “Омни капитал ББСБ” ХХК-ийн захирлын 2021 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн Б/63 тоот тушаал, “Омни капитал ББСБ” ХХК-ийн 2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 924 тоот албан бичиг, 2020 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн “Банк бус санхүүгийн програм хангамж нийлүүлэх гэрээ”, 2021 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн Г/32 тоот хөдөлмөрийн гэрээ зэргээр нотлогдож байна.

V. Аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээ

ТЗК-ийн ТУЗ-ийн 2021 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн ТУЗ-21/11 тоот шийдвэрийн дагуу Хөндлөнгийн аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээг байгуулах шийдвэрийг гаргасан ба уг гэрээнд гарын үсэг зурах бүрэн эрхийг ТУЗ-ийн дарга С.Бямбасүрэнд олгосон байна. ТУЗ нь СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 3.12, ТЗК-ийн дүрмийн 6.2.7.3, ТУЗ-ийн Үйл ажиллагааны журмын 5.2.2.5-д тус тус заасны дагуу гэрээ байгуулах шийдвэр гаргах бүрэн эрхтэй байна. Энэхүү гэрээгээр Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 40.1, СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 8.1-т заасан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд жилд нэгээс доoshгүй удаа хийх хөндлөнгийн аудитын хяналт, шалгалттай холбоотой харилцааг зохицуулсан байх бөгөөд энэ нь Аудитын тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль тогтоомжид нийцэж байна.

VI. Зээлийн шинжилгээ гаргах аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээ:



2022 -01- 28

БҮРТГЭВ-01



“Омни актив” ХХК болон “Грант Торнтон аудит” ХХК нар нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахад зориулсан зээлийн багцад шинжилгээ хийж, тэдгээр нь зохих шалгуурыг хангаж, холбогдох хууль тогтоомжид болон холбогдох үйлчилгээний олон улсын стандарт 4400-т нийцэж буй эсэхэд шалгаж дүгнэлт гаргах зорилгоор 2021 оны 8 дугаар сарын 23-ны өдөр ХАГ-21/03 тоот “Аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээ” байгуулсан байх бөгөөд тус гэрээ нь Аудитын тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль тогтоомжид нийцэж байна.

Түүнчлэн “Грант Торнтон аудит” ХХК нь Аудитын тухай хуулийн 19 дүгээр зүйл, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.3, СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 8.2 болон Үнэт цаасны бүртгэлийн журмын 11 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангаж байгаа аудитын компани болох нь түүний улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм, Аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн 020-1999 тоот гэрчилгээ, Үнэт цаасны зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг шинэчлэн бүртгэх тухай СЗХ-ны 2014 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн 23 дугаар тогтоол, “Грант Торнтон аудит” ХХК-ийн 2021 оны 11 дүгээр сарын 8-ны өдрийн 193 тоот Мэдэгдэл зэргээр нотлогдож байна.

VII. Хувьчийн зөвлөх үйлчилгээний гэрээ:

ТЗК болон Өмгөөллийн “ХаанЛекс Партерс” ХХН нар нь 2021 оны 9 дүгээр сарын 02-ны өдөр 07 тоот “Хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ” байгуулсан бөгөөд уг гэрээгээр Үнэт цаас гаргагчаас хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг нийтэд санал болгон нээлттэй гаргахтай холбоотой хууль зүйн дүгнэлт боловсруулах, Зээлийн багцийн хуулийн шалгуур үзүүлэлтэд нийцсэн эсэх талаарх хуулийн хөндлөнгийн дун шинжилгээний тайлан бэлтгэхтэй холбогдон бий болох харилцааг зохицуулсан байна. Энэ гэрээ нь Монгол Улсын Иргэний хууль, МХБ-ийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 2.5.5, 2.7 дахь хэсэг болон холбогдох хуульд нийцсэн байна.

Өмгөөллийн “ХаанЛекс Партерс” ХХН нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахтай холбоотой хөндлөнгийн хууль зүйн дүгнэлт гаргах бүрэн эрхтэй бөгөөд үүнд харшлах шалтгаан байхгүй болох нь түүний үүсгэн байгуулах баримт бичиг, улсын бүртгэлийн гэрчилгээ, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Улсын бүртгэлийн ерөнхий газар”-ын <http://opendata.burtgel.gov.mn/> хаягт заасан нээлттэй мэдээлэл, Санхүүгийн зохицуулах хорооны 338 тоот тогтоол болон Баталгаа гаргах тухай албан бичгээр нотлогдоно. Түүнчлэн ТЗК-ийн ТУЗ нь СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 3.12, ТЗК-ийн дурмийн 6.2.7.3, ТУЗ-ийн Үйл ажиллагааны журмын 5.2.2.2-д тус тус заасны дагуу ТЗК-н нэрийн өмнөөс энхүү гэрээг байгуулах шийдвэрийг гаргах бүрэн эрхтэй байх тул гэрээг хүчин төгөлдөр гэж үзнэ.

VIII. Андеррайтерын болон зөвлөх үйлчилгээний гэрээ:



2022 -01- 28

БҮРТГЭВ-00



“Омни капитал ББСБ” ХХК, “Омни актив” ХХК болон “Алекс капитал УЦК” ХХК нар нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасан тусгай зориулалтын компани үүсгэн байгуулж, түүгээр дамжуулж хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гарган олон нийтэд санал болгож, МХБ-ээр арилжаалах ажлыг зохион байгуулах болон үүнтэй холбогдон талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулах зорилгоор 2021 оны 08 дугаар сарын 30-ны өдөр 06/ADK/21/81 тоот “Андеррайтерын үйлчилгээ үзүүлэх гэрээ”-г байгуулсан байна. Тус гэрээгээр талуудын эрх, үүрэг, харинчлага, гүйцэтгэх ажил үйлчилгээ, үнэ, хугацаа зэргийг зохицуулсан байгаа нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 41 дүгээр зүйл, МХБ-ийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн бүртгэлийн журмын 2.4, 2.7-д заасан шаардлагыг хангаж байгаа бөгөөд холбогдох хуульд нийцсэн байна.

Түүнчлэн “Алекс капитал УЦК” ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм, 2011 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн ТЗ 301/62 тоот тусгай зөвшөөрлийн гэрчилгээ болон уг компанийн “Мэдэгдэл, баталгаа гаргах тухай” 2021 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 136 тоот албан бичиг зэргээс дүгнэвэл тус компани нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, СЗХ-ны Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрлийн журмын дагуу андеррайтерын үйл ажиллагааг эрхлэн, дээрх гэрээг байгуулах эрхтэй этгээд байна.

3.4. Үнэт цаас гаргагч нь үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч бусад этгээдтэй ашиг сонирхлын зорчилттай эсэх талаар

Үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч бусад этгээд гэдэгт дараах этгээдийг хамааруулан авч үзсэн болно. Үүнд:

- (i) андеррайтер;
- (ii) анхны үүрэг гүйцэтгүүлэгч;
- (iii) үйлчилгээ үзүүлэгч;
- (iv) хөрөнгө итгэмжлэн удирдагч;
- (v) зээлийн шинжилгээ гаргагч аудитор;
- (vi) хуулийн фирм.

Ашиг сонирхлын зөрчил байгаа эсэхийг тогтоохын тулд мөн Компанийн тухай хуулийн 89 дүгээр зүйлд заасан нөхцөл байдал үүссэн болон ТЗК, үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч этгээдүүд нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 13.3 болон Банкны тухай хуулийн 3.1.2-т заасан харилцаатай эсэхийг тогтоон шалгах шаардлагатай болсон ба үүний дараах байдлаар гүйцэтгэсэн болно:

- (i) Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагч болох “Омни капитал ББСБ” ХХК-аас 2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 923-тоот албан бичгээр Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 13.3 болон Банкны тухай хуулийн 3.1.2-т заасан холбоотой этгээдийн жагсаалтыг бидэнд ирүүлсэн болно. Уг албан бичигт дурдсан



ОХИЙН STOCK EXCH

2022 -01- 28

БҮРТГЭВ

СЗХ
он 7000011112
БҮРТГЭВ
№ 01

этгээдүүдэд андеррайтер, хөрөнгө итгэмжлэн удирдагч, хөндлөнгийн аудитор болон хуулийн фирм нар нь байхгүй тул холбоотой этгээдүүд биш байна.

- (ii) Үнэт цаас гаргагч болон “Омни капитал ББСБ” ХХК-аас андеррайтер, хөрөнгө итгэмжлэн удирдагч, хөндлөнгийн аудитор болон хуулийн фирмтэй санхүүгийн болон санхүүгийн бус нэгдмэл ашиг сонирхолтой тухайгаа дор дурдсан албан бичгээр бидэнд ирүүлсэн болно. Үүнд:
- “Омни актив” ХХК-ийн 2021 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 05 тоот Баталгаа гаргах тухай албан бичиг;
 - “Омни капитал ББСБ” ХХК-ийн 2021 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 896 тоот албан бичиг.
- (iii) Үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч этгээдүүд нь Үнэт цаас гаргагчтай санхүүгийн болон санхүүгийн бус нэгдмэл ашиг сонирхолтой тухай дор дурдсан албан бичгийг бидэнд ирүүлсэн. Үүнд:
- “Юнайтэд айр файнэнс” ХХК-ийн 2021 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 11-01 тоот албан бичиг;
 - “Грант торnton аудит” ХХК-ийн 2021 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 193 тоот албан бичиг;
 - “Апекс капитал УЦК” ХХК-ийн 2021 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 136 тоот албан бичиг;
 - Өмгөөллийн “ХаанЛекс партнерс” ХХН-ийн 11 дүгээр сарын 08-ны өдрийн У/21/218 тоот албан бичиг

Дээрхээс дүгнэвэл үйлчилгээ үзүүлэгч этгээдээс бусад хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч этгээдүүдийн хооронд ашиг сонирхлын зөрчил үүсээгүй байна.

Үйлчилгээ үзүүлэгч этгээд болох “Омни капитал ББСБ” ХХК нь Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч байх тул хуульд заасны дагуу холбогдох этгээдүүд байх боловч Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 19.8-д заасны дагуу анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь үйлчилгээ үзүүлэгчийн үүргийг гүйцэтгэж болохоор байна. Түүнчлэн уг гэрээг Компанийн тухай хуульд заасан сонирхлын зөрчилтэй хэлэлтийг байгуулах журмын дагуу байгуулсан байх тул хуульд нийцсэн гэж дүгнэж байна.

3.5. Үнэт цаасны танилцуулга, түүнд тусгагдсан мэдээлэл нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, бусад холбогдох хууль журамд нийцж буй эсэх, үнэн зөв, хүчин төгөлдөр эсэх

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны танилцуулга нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.5, СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 2.9,





МХБ-ийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 4 дүгээр зүйлд заасан шаардлагыг тус тус хангасан байх ёстой. Үнэт цаас гаргагчийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны танилцуулга нь нийт 9 бүлгээс бүрдэх бөгөөд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны танилцуулгад заавал тусгах сурь мэдээллийг бүрэн багтаасан байх тул холбогдох хууль журамд нийцж байна гэж үзэж болохоор байна.

Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан мэдээллийн үзүүн зөвийг оролцогч этгээдүүдийн үүсгэн байгуулах болон бусад үндсэн баримт бичигтэй тулган шалгах, оролцогч этгээдүүд болон төрийн эрх бүхий байгууллагаас тодруулга, лавлагаа авах замаар шалгахад түүнд тусгагдсан мэдээллүүд нь тухайн баримт бичигтэй нийцж байх тул үнэт цаасны танилцуулга, түүнд тусгагдсан мэдээллийг үзүүн зөв, хүчин төгөлдөр гэж дүгнэж байна. Дэлгэрэнгүй хууль зүйн шинжилгээ, дүгнэлтийг Хавсралт № 3-аас үзнэ үү.

Түүнчлэн үнэт цаасны танилцуулгад тусгагдсан ТЗК болон “Омни капитал ББСБ” ХХК-ийн эрх бүхий албан тушаалтуудын талаарх мэдээлэл үзүүн зөв бөгөөд хуульд нийцсэн эсэх тухай хууль зүйн шинжилгээ, дүгнэлтийг Хавсралт № 4-аас үзнэ үү.

Дүгнэлт гаргасан:

J. Batjargal
Гомбосурэнгийн Батжаргал
Хуульч, нөхөрлөлийн гишүүн

Идэрханчлал Урсацбаир
Гүйцэтгэх захирал, хуульч, нөхөрлөлийн гишүүн

2021 оны 12 дугаар сарын 14-ний өдөр

19



160



Хасалт № 1

**ХУУЛЬ ЗҮЙН ДУГНЭЛТ ГАРГАХТАЙ ХОЛБОТОЙГООР ТӨРИЙН БОЛОН ХОЛБОГОДХ БУСАД БАЙГУУЛЛАГААС АВСАН
ЛАВЛАГАА, БАРИМТ БИЧГИЙН ЖАГСАЛТ**

№	Лавлагaa, тодорхойлолт	Онгосон газар	Огноо / Дугаар
1			
1.1	Хуудийн эргээдийн эрүүгийн хариуцлага хүчээж байгаа эсх тухай тодорхойлолт	Цагдаагийн срөнхий газар	2021.10.15
1.2	Хуудийн эргээдийн эрүүгийн хариуцлага хүчээж байсан эсх тухай тодорхойлолт	Цагдаагийн срөнхий газар	2021.10.15
1.3	Шүүхийн шийдвэрээр бусад төлбөртэй эсх тухай тодорхойлолт	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх срөнхий газар	2021.10.15
1.4	Хуудийн эргээдийн дэлгэрэнгүй лавлагaa	Улсын бургалдийн срөнхий газар	2021.10.15
1.5	Татварын тооцогтоой эсх тухай тодорхойлолт	Татварын срөнхий газар	2021.11.10
1.6	Ажлын олонгчийн нийгмийн даатгалын шимтэл төлөлтийн тодорхойлолт	Нийгмийн даатгалын срөнхий газар	2021.11.10
1.7	Татварын оршиж үзүүлдэгийн лавлагaa	Татварын срөнхий газар	2021.11.10
1.8	Нийгмийн даатгалын шимтэл төлөлтийн тодорхойлолт	Нийгмийн даатгалын срөнхий газар	2021.11.10
1.9	Зөвлөлийн мэдээллийн сангийн лавлагaa	Монголбанк	2021.11.04
1.10	СЗХ-ноос хариуцлага тооцож байгаагүй болон зохицой харьцааны шалгуур хангаж байгаа эсх талаарх тодорхойлолт	Санхүүгийн зохицуулах хороо	2021.10.05 9/3448
1.11	СЗХ-ны тодорхойлолт	Санхүүгийн зохицуулах хороо	2021.11.17 9/4006
1.12	Давамгай байдалтай эсх, Өрсөлдөөний тухай хууль зөрчсөн эсх талаарх лавлагaa	Шударга орсөлдөөн, хөрзгэлгүйчиний төлөөг газар	2021.11.09 01/2083
1.14	Захиргааны хэрэг хянаас шийдвэрээр ажиллаганд ихэвхэмжлийч болон гурвалдагч элтээдээр оролцож байсан эсх тухай лавлагaa	Захиргааны хүргийн анхан шатны шүүх	2021.11.10 7036
1.15	Арбитрт ихэмжлигч, хариулагч, гурвалдагч элтээдээр оролцож байсан эсх тухай лавлагaa	Монголын олон улсын арбитр	2021.11.09 4/1463
1.16	Шүүхийн тусгай архивын лавлагaa	Шүүхийн төрөлжсон архив	2021.11.11 1/9990
2			
2.1	Зөвлөлийн мэдээллийн сангийн лавлагaa	Монголбанк	2021.10.18



D. Dyl



2022 -01- 28

БҮРТГЭВ-0.



№	Лавлагат, тодорхойлолт	Олонцон газар	Огноо / Дугаар
2.2	Нийгмийн даатгалын шимтэл төлөлтийн талаарх тодорхойлолт	Нийгмийн даатгалын ерөнхий газар	2021.11.10
2.3	Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тухай тодорхойлолт	Цагдаагийн срөнхий газар	2021.10.18
2.4	Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт	Цагдаагийн срөнхий газар	2021.10.18
2.5	Шүүхийн шийдвэрээр бусад төлбөргүй эсэх тухай тодорхойлолт (иргэн)	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх срөнхий газар	2021.10.18
2.6	Захиргааны хэрэг хянан шийдвэрээр ажиллагаанд ихээмжлийг болон гуравдагч этгээдээр оролцож байсан эсэх тухай лавлагас	Захиргааны хэргийн анхан шатны шүүх	2021.11.10 7054
2.7	Арбитрт ихээмжлийг, хариуцагч, гуравдагч этгээдээр оролцож байсан эсэх тухай лавлагас	Монголын олон улсын арбитр	2021.11.09 4/1472
2.8	Шүүхийн тусгай архивын лавлагас	Шүүхийн төрөлжсон архив	2021.11.11 1/9999
3	Омни Капитал ББСБ ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн, эсийн омчлолт	Ч.Даваасүрэнгийн талаарх лавлагат, тодорхойлолт	
3.1	Зээлийн мэдээллийн сангийн лавлагас	Монголбанк	2021.10.18
3.2	Нийгмийн даатгалын шимтэл төлөлтийн талаарх тодорхойлолт	Нийгмийн даатгалын срөнхий газар	2021.10.18
3.3	Нийгмийн даатгалын шимтэл төлөлтийн талаарх тодорхойлолт	Нийгмийн даатгалын срөнхий газар	2021.11.11
3.4	Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тухай тодорхойлолт	Цагдаагийн срөнхий газар	2021.10.18
3.5	Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт	Цагдаагийн срөнхий газар	2021.10.18
3.6	Шүүхийн шийдвэрээр бусад төлбөргүй эсэх тухай тодорхойлолт (иргэн)	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх срөнхий газар	2021.10.18
3.7	Захиргааны хэрэг хянан шийдвэрээр ажиллагаанд ихээмжлийг болон гуравдагч этгээдээр оролцож байсан эсэх тухай лавлагас	Захиргааны хэргийн анхан шатны шүүх	2021.12.07 7443
3.8	Арбитрт ихээмжлийг, хариуцагч, гуравдагч этгээдээр оролцож байсан эсэх тухай лавлагас	Монголын олон улсын арбитр	2021.11.09 4/1470
3.9	Шүүхийн тусгай архивын лавлагас	Шүүхийн төрөлжсон архив	2021.11.11 1/10000
4	Омни Капитал ББСБ ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх захирал / Омни Актив ТЭК ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн С.Нинагийн талаарх лавлагат, тодорхойлолт		
4.1	Зээлийн мэдээллийн сангийн лавлагас	Монголбанк	2021.10.18
4.2	Нийгмийн даатгалын шимтэл төлөлтийн талаарх тодорхойлолт	Нийгмийн даатгалын срөнхий газар	2021.09.23
4.3	Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тухай тодорхойлолт	Цагдаагийн срөнхий газар	2021.09.23
4.4	Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт	Цагдаагийн срөнхий газар	2021.10.18
4.5	Шүүхийн шийдвэрээр бусад төлбөргүй эсэх тухай тодорхойлолт (иргэн)	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх срөнхий газар	2021.09.23
4.6	Захиргааны хэрэг хянан шийдвэрээр ажиллагаанд ихээмжлийг болон гуравдагч этгээдээр оролцож байсан эсэх тухай лавлагас	Захиргааны хэргийн анхан шатны шүүх	2021.11.10 7052



2022 -01 - 28

БҮРТГЭВ-03

СЗХ
он/2022 сар 11.12
БҮРТГЭВ
№ 01

№	Лавлагас, тодорхойлолт	Олонгсон газар	Огноо / Дугаар
4.7	Арбитрт нэхэмжилгч, хариуцагч, гуравдагч этгээдээр оролцож байсан эсэх тухай лавлагас	Монголын олон улсын арбитр	2021.11.09 4/1467
4.8	Иргэнэ олгох тодорхойлолт	Монголын татварын алба	2021.09.29
4.9	Шүүхийн тусгай архивын лавлагас	Шүүхийн төрөлжсөн архив	2021.11.11 1/9995
5	Омни Капитал ББСБ ХХК-ийн ТҮЗ-ийн гишүүн Г.Ууланбаярын талаарх лавлагас, тодорхойлолт		
5.1	Зээлийн мэдээллийн сангийн лавлагас	Монголбанк	2021.10.18
5.2	Нийгмийн даатгалын шимтэлээ төлөлтийн талаарх тодорхойлолт	Нийгмийн даатгалын срөнхий газар	2021.10.19
5.3	Иргэний эрүүгийн харинчлагыг хүлээж байгаа эсэх тухай тодорхойлолт	Цагдаагийн ерөнхий газар	2021.10.18
5.4	Иргэний эрүүгийн харинчлагыг хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт	Цагдаагийн ерөнхий газар	2021.10.18
5.5	Шүүхийн шийдвэрээр бусад төлбөргүй эсэх тухай тодорхойлолт (иргэн)	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх срөнхий газар	2021.10.18
5.6	Захиргааны хэрг хянан шийдвэрээр ажиллагаанд нэхэмжилгч болон гуравдагч этгээдээр оролцож байсан эсэх тухай лавлагас	Захиргааны хэргийн анхан шатны шүүх	2021.11.10 7049
5.7	Арбитрт нэхэмжилгч, хариуцагч, гуравдагч этгээдээр оролцож байсан эсэх тухай лавлагас	Монголын олон улсын арбитр	2021.11.09 4/1464
5.8	Шүүхийн тусгай архивын лавлагас	Шүүхийн төрөлжсөн архив	2021.11.11 1/9997
6	Омни Капитал ББСБ ХХК-ийн ТҮЗ-ийн гишүүн / Эсийн омчлогч (ЦБОН) Э.Пүрвсүрэнгийн талаарх лавлагас, тодорхойлолт		
6.1	Зээлийн мэдээллийн сангийн лавлагас	Монголбанк	2021.10.18
6.2	Нийгмийн даатгалын шимтэлээ төлөлтийн талаарх тодорхойлолт	Нийгмийн даатгалын срөнхий газар	2021.11.10
6.3	Иргэний эрүүгийн харинчлагыг хүлээж байгаа эсэх тухай тодорхойлолт	Цагдаагийн срөнхий газар	2021.10.18
6.4	Иргэний эрүүгийн харинчлагыг хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт	Цагдаагийн срөнхий газар	2021.10.18
6.5	Шүүхийн шийдвэрээр бусад төлбөргүй эсэх тодорхойлолт (иргэн)	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх срөнхий газар	2021.10.18
6.6	Иргэний унэмэлхийн хуудбар		
6.7	Захиргааны хэрг хянан шийдвэрээр ажиллагаанд нэхэмжилгч болон гуравдагч этгээдээр оролцож байсан эсэх тухай лавлагас	Захиргааны хэргийн анхан шатны шүүх	2021.11.10 7048
6.8	Арбитрт нэхэмжилгч, хариуцагч, гуравдагч этгээдээр оролцож байсан эсэх тухай лавлагас	Монголын олон улсын арбитр	2021.11.09 4/1471
6.9	Шүүхийн тусгай архивын лавлагас	Шүүхийн төрөлжсөн архив	2021.11.11 1/9998
7	Омни Капитал ББСБ ХХК-ийн ТҮЗ-ийн хараат бус Гишүүн М.Даваабаярын талаарх лавлагас, тодорхойлолт		
7.1	Зээлийн мэдээллийн сангийн лавлагас	Монголбанк	2021.12.01



2022 -01- 28

БҮРТГЭВ-08



№	Лавлагас, тодорхойлолт	Олонгосон газар	Огноо / Дугаар
7.2	Нийгмийн даатгалын шимтэг тололтийн талаарх тодорхойлолт	Нийгмийн даатгалын срөнхий газар	2021.11.30
7.3	Иргэний зуудын хариуслага худээж байгаа эсэх тухай тодорхойлолт	Цагдаагийн срөнхий газар	2021.12.02
7.4	Иргэний зуудын хариуслага худээж байсан эсэх тухай тодорхойлолт	Цагдаагийн срөнхий газар	2021.12.01
7.5	Шүүхийн шийдвэрээр бусад төлбөргүй эсэх тухай тодорхойлолт (иргэн)	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх срөнхий газар	2021.12.02
7.6	Арбитрт изхэмжилгэч, хариулагч, гуравдагч этгээдээр оролцож байсан эсэх тухай лавлагас	Монголын олон улсын арбитр	2021.12.07 4/1677
7.7	Иргэний үзүүлэхийн лавлагас	Улсын бүртгэлийн срөнхий газар	2021.11.29
7.8	Иргэнд олгох тодорхойлолт	Татварын срөнхий газар	2021.11.30
7.9	Захиргааны хэрэг хянан шийдвэрэлх ажиллагаанд изхэмжилгэч болон гуравдагч этгээдээр оролцож байсан эсэх тухай лавлагас	Захиргааны хөргийн анхан шатны шүүх	2021.11.10 7048
7.10	Шүүхийн тусгай архивын лавлагас	Шүүхийн төрөлжсон архив	2021.12.08 1/1028I
8	Омни Капитал ББСБ ХХК-ийн Ерөнхий Нийтлан Н.Намжилмаагийн талаарх лавлагас, тодорхойлолт		
8.1	Захиргааны хэрэг хянан шийдвэрэлх ажиллагаанд изхэмжилгэч болон гуравдагч этгээдээр оролцож байсан эсэх лавлагас	Захиргааны хөргийн анхан шатны шүүх	2021.11.10 7047
8.2	Арбитрт изхэмжилгэч, хариулагч, гуравдагч этгээдээр оролцож байсан тухай эсэх	Монголын олон улсын арбитр	2021.11.09 4/1468
8.3	Шүүхийн тусгай архивын лавлагас	Шүүхийн төрөлжсон архив	2021.11.11 1/9994
8.4	Зээлийн мэдээллийн сангийн лавлагас	Монголбанк	2021.11.04
8.5	Нийгмийн даатгалын шимтэг тололтийн талаарх тодорхойлолт	Нийгмийн даатгалын срөнхий газар	2021.10.19
8.6	Иргэний зуудын хариуслага худээж байгаа эсэх тухай тодорхойлолт	Цагдаагийн срөнхий газар	2021.10.19
8.7	Иргэний зуудын хариуслага худээж байсан эсэх тухай тодорхойлолт	Цагдаагийн срөнхий газар	2021.10.19
8.8	Шүүхийн шийдвэрээр бусад төлбөргүй эсэх тухай тодорхойлолт	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх срөнхий газар	2021.10.19
9	"Омни Актийн" ТЗК ХХК-ийн талаарх лавлагас, тодорхойлолт		
9.1	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн лавлагас	Улсын бүртгэлийн срөнхий газар	2021.12.10
9.2	Татвар төлөгчийн гарчилгээ	Монголын татварын алба	2021.11.29
9.3	Аж ахуй нэгжийн байгууллагын тодорхойлолт	Монголын татварын алба	2021.11.29
9.4	Дансны хуудла	Голомт банк	2021.11.09
9.5	Хуулийн этгээдийн нэр аварчлалын тухай лавлагас	Улсын бүртгэлийн срөнхий газар	2021.12.10
9.6	Шүүхийн шийдвэрээр бусад төлбөргүй эсэх тодорхойлолт	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх срөнхий газар	2021.12.10





№	Лакагив, тодорхойлолт	Олонгосон газар	Отнош / Дугаар
9.7	Хуулийн эгээдийн эрүүгийн хариушлага хүлээж байгаа эсэх тухай тодорхойлолт	Цагдаагийн срөнхий газар	2021.12.10
9.8	Хуулийн эгээдийн эрүүгийн хариушлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт	Цагдаагийн срөнхий газар	2021.12.10
10	Омни Актив ТЗК ХХК-ийн Хараат бус гишүүн, ТҮЗ-ийн дарга С.Бямбасүрэнгийн талаарх лавлагас, тодорхойлолт		
У10.1	Зээлийн мэдээллийн сангийн лавлагас	Монголбанк	2021.11.04
10.2	Нийгмийн даатгалын шимтэл төвлөгийн талаарх тодорхойлолт	Нийгмийн даатгалын срөнхий газар	2021.10.01
9.3	Иргэний эрүүгийн хариушлага хүлээж байгаа эсэх тухай тодорхойлолт	Цагдаагийн срөнхий газар	2021.10.01
9.4	Иргэн олгох тодорхойлолт	Татварын срөнхий газар	2021.10.01
9.5	Шүүхийн шийдвэрээр бусад төлбөргүй эсэх тодорхойлолт (иргэн)	Шүүхийн шийдвэр түйштгэх срөнхий газар	2021.10.01
9.6	Захиргааны хөргө хянан шийдвэрээр ажиллагаванд ижхэмжлигч болон гуравдагч эгээдээр ороцож байсан эсэх тухай лавлагас	Захиргааны хэргийн анхан шатны шүүх	2021.11.10 7051
9.7	Арбитрт ижхэмжлигч, хариулагч, гуравдагч эгээдээр ороцож байсан эсэх тухай лавлагас	Монголын олон улсын арбитр	2021.11.09 4/1465
9.8	Шүүхийн тусгай архивын лавлагас	Шүүхийн төрөлжсөн архив	2021.11.11 1/9992
